



Future Tech[↑] INNOVATION

НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

"Фьючер Тек Инновэйшн хамтын биржээр
арилжаалагддаг ХОС" ХХК

Хөрөнгө оруулалтын менежментийн компани
"БАЛАНСЭД ГРӨҮТ МЕНЕЖМЕНТ" ХХК



"Фьючер-Тек Инновэйшн хамтын биржээр арилжаалагддаг ХОС" ХХК (цаашид "ХОС" гэх) нь энэхүү Нэгж эрхийн танилцуулга (цаашид "Танилцуулга" гэх)-г бэлтгэх үеийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "Хороо" гэх) болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох "Монголын Хөрөнгийн Бирж" ХК (цаашид "Хөрөнгийн бирж" гэх)-ийн холбогдох дүрэм, журамд заасны дагуу Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий үнэт цаасны компани (цаашид "Мэргэжлийн оролцогч" гэх)-аар дамжуулан нэгж эрхээ Хөрөнгийн бирж дээр олон нийтэд нээлттэй санал болгож байна.

Энэхүү Танилцуулгаар Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох журамд заасан үнэт цаасыг олон нийтэд нээлттэй санал болгохтой холбоотой бүхий л шаардлагатай мэдээ мэдээллийг агуулахыг зорьсон болно.


Энэхүү Танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус дүн шинжилгээ, үнэлгээ, дүгнэлтийг орлохгүй ба хөрөнгө оруулагч та өөрийн бие даасан, хараат бус дүн шинжилгээ, үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргах бөгөөд Танилцуулга нь ХОС-ийн нэгж эрх олон нийтэд нээлттэй арилжаалагдаж байгаатай холбогдуулан хөрөнгө оруулагчдад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шаардлагатай бүхий л мэдээллүүдийг бүрэн гүйцэд хүргэхэд чиглэсэн болно.

ХОС-ийн нэгж эрхийг Хороо болон Хөрөнгийн бирж бүртгэсэн нь уг нэгж эрхийн эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани буюу "Балансэд грөүт менежмент" ХХК (цаашид "ХОМК" гэх) болон түүний удирдаж байсан бусад хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны түүхэн гүйцэтгэл нь энэхүү нэгж эрхийг гаргаж буй ХОС-ийн ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй. Энэхүү нэгж эрхийг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, энэхүү Танилцуулга, нэгж эрх гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Энэхүү Танилцуулгад тусгагдсан бүхий л мэдээ мэдээлэл, тоо, баримт материал дахь агуулгыг тийнхүү тусгагдсан байдлаас нь зөрүүтэй, ялгаатай, худал, төөрөгдүүлсэн байдлаар бусдад түгээхийг хориглоно. Хэрэв түгээсэн тохиолдолд ХОС болон ХОМК хариуцлага хүлээхгүй болно.

Хөрөнгө оруулагч нь ХОС-ийн нэгж эрхийг худалдан авч, хууль ёсны дагуу эзэмшсэн тохиолдолд энэхүү Танилцуулгад тусгагдсан нөхцөл, нэгж эрх эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, эрсдэлтэй холбогдсон мэдээлэл, нөхцөл, журамтай танилцаж хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Энэхүү Танилцуулгад тусгагдсан аливаа мэдээ мэдээллийн талаар илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл авах болон тодруулах зүйлс байх тохиолдолд ХОМК болон/эсхүл Мэргэжлийн оролцогчдод хандана уу.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026-07-09
БҮРТГЭВ-03



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ОРОЛЦОЖ БҮЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ

ХОМК

“Балансэд Греүт Менежмент” ХХК



Регистрийн дугаар: 6819532

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Цэнтрал Тауэр, 4 давхар, 409 тоот

Холбоо барих утас: (976) 7775-2050

Цахим хуудас: www.balancedgrowth.mn

Кастодиан

“Голомт Банк” ХК



Регистрийн дугаар: 2075377

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын 5, Голомт банк төв байр

Холбоо барих утас: (976) 7011-1646

Цахим хуудас: www.golomtbank.com

Хөндлөнгийн хуулийн зөвлөх

“Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс” ХХН



Регистрийн дугаар: 5495997

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Холбоо барих утас: (976) 11-330048

Цахим хуудас: www.mdsa.mn



1. Товч танилцуулга	13
1.1. Хөрөнгө оруулалтын сангийн товч танилцуулга	14
1.2. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн товч танилцуулга	16
1.3. Хөрөнгө оруулалтын онцлог	17
2. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах зах зээл	18
2.1. Макро орчны төлөв байдал	19
2.2. Зах зээлийн төлөв байдал	28
2.3. Хууль эрхзүйн орчин	52
3. Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга	54
3.1. Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга	55
3.2. Хөрөнгө оруулалтын сангийн удирдлага	58
3.3. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа болон түүний үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, журмын талаарх мэдээлэл	74
3.4. Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн төлөвлөгөө	97
4. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулга	101
4.1. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулга	102
4.2. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээр гэрчлэгдэх эрх, үүрэг	103
4.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд байршуулах	105
4.4. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа	106
4.5. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах, захиалга өгөх заавар	107
4.6. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн худалдан авах хувь	108
4.7. ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах, буцаан авах үйл ажиллагаа	108
5. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гаргах ажиллагаанд оролцсон байгууллагууд	115
5.1. Мэргэжлийн оролцогч	116
5.2. Кастодиан	117
5.3. Хөндлөнгийн хуулийн зөвлөх байгууллага	118
5.4. Хөндлөнгийн аудитын байгууллага	119
6. Хавсралт	120



2025-07-20

БҮРТГЭВ-03

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ



Хүснэгт 1: ХОС-ийн товч танилцуулга	14
Хүснэгт 2: ХОС-ийн нэгж эрхийн товч танилцуулга	16
Хүснэгт 3: Хөрөнгө оруулалтын онцлог, давуу тал	17
Хүснэгт 4: Дэлхийн бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал, бүс нутгаар	19
Хүснэгт 5: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал	25
Хүснэгт 6: Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ, 2024 он	27
Хүснэгт 7: Хиймэл оюун ухааны хөгжлийн үе шат, түүний мэдээлэл	32
Хүснэгт 8: Хиймэл оюун ухааны технологийн дэд бүтцийн ерөнхий түвшний энгийн тайлбар	32
Хүснэгт 9: Стэнфордын Их Сургуулийн "AI Index 2025" тайлангийн хураангуй мэдээлэл	34
Хүснэгт 10: Хиймэл оюун ухааны технологийн дэд бүтцэд оролцогчдын орлогын өсөлтийн таамаглал	37
Хүснэгт 11: Зэсийн эрэлт болон нийлүүлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс	38
Хүснэгт 12: Эрчим хүчний салбарын дэд ангилал ба тэдгээрийн төлөв байдал	40
Хүснэгт 13: Цахилгаан эрчим хүчний эрэлтийн гол хүчин зүйлс	40
Хүснэгт 14: Эрчим хүчний оновчлолд ашиглагдах хиймэл оюун ухааны хэрэглээ болон тэдгээрийн салбар бүр дэх хэрэглэх боломж	42
Хүснэгт 15: Эдийн засгийн сектор болон сэдэвчилсэн ETF рүү орсон, гарсан мөнгөн урсгал	45
Хүснэгт 16: Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр, төрлийн ангилал	48
Хүснэгт 17: Хөрөнгө оруулалтын сангийн үндсэн ойлголт	48
Хүснэгт 18: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй зарим хамтын хөрөнгө оруулалтын сангуудын ерөнхий мэдээлэл	49
Хүснэгт 19: ХОС-ийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх зарим эрх зүйн актын мэдээлэл	52
Хүснэгт 20: Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга	55
Хүснэгт 21: ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын мэдээлэл	59
Хүснэгт 22: ХОС-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн	62
Хүснэгт 23: ХОМК-ийн хуулийн этгээдийн бүртгэл	63
Хүснэгт 24: ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга	65
Хүснэгт 25: ХОМК-ийн Гүйцэтгэх удирдагын баг болон хүний нөөцийн мэдээлэл	66
Хүснэгт 26: ХОМК-ийн үйлчилгээ үзүүлж буй "Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС" ХХК-ийн мэдээлэл	69
Хүснэгт 27: ХОМК-ийн үйлчилгээ үзүүлж буй "Би Жи Эм үл хөдлөх хөрөнгийн багц хувийн ХОС" ХХК-ийн мэдээлэл	70
Хүснэгт 28: ХОС-ийн Бодлогын баримт бичгийн хураангуй агуулга	74
Хүснэгт 29: Индекс тэй холбоотой ерөнхий мэдээлэл	76
Хүснэгт 30: Технологийн салбар болон эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтыг төлөөлөх ETF-ийг үнэлэх матриц	78
Хүснэгт 31: Индексийн эхлэлийн багц	79
Хүснэгт 32: Индексийн эхлэлийн багцын гүйцэтгэлтэй холбоотой ерөнхий мэдээлэл	80
Хүснэгт 33: Индексийн эхлэлийн багц дахь ETF-үүдийн хамгийн өндөр дүнгээр эзэмшиж буй хувьцаа	81
Хүснэгт 34: Индексийн эхлэлийн багц дахь ETF-үүдийн эзэмшиж буй хувьцааны эдийн засгийн салбарын тараан байршуулалт	81
Хүснэгт 35: ХОС-д учирч болзошгүй эрсдэл, түүний тодорхойлолт, эрсдэлийг хэмжих үзүүлэлт, эрсдэлийн удирдлагын зарчим	84
Хүснэгт 36: ХОС-ийн санхүүгийн төсөөллийг бэлтгэхэд ашигласан голлох таамаглал, түүний үндэслэл	97
Хүснэгт 37: Үнэт цаас гаргагчийн ХОС-ийн орлогын төсөөлөл, сая төгрөг	97
Хүснэгт 38: ХОС-ийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөг	98
Хүснэгт 39: ХОС-ийн мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл, сая төгрөг	98
Хүснэгт 40: ХОС-ийн санхүүгийн тайлангийн голлох харьцаа үзүүлэлтүүдийн төсөөлөл	99
Хүснэгт 41: ХОС-ийн нэгж эрхийн танилцуулга	102

СЗХ
2025.07.09
БҮРТГЭВ
№01

Хүснэгт 42: ХОС-ийн нэгж эрхээр гэрчлэгдэх эрх, үүрэг, холбогдох бусад мэдээлэл.....	103
Хүснэгт 43: ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах үйл ажиллагааны дараалал, холбогдох мэдээлэл	109
Хүснэгт 44: ХОС-ийн нэгж эрхийг буцаан авах үйл ажиллагааны дараалал, холбогдох мэдээлэл	110
Хүснэгт 45: "Алекс Капитал ҮЦК" ХХК-ийн мэдээлэл	116
Хүснэгт 46: "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн мэдээлэл.....	116
Хүснэгт 47: "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн талаарх мэдээлэл	116
Хүснэгт 48: "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-ийн талаарх мэдээлэл.....	116
Хүснэгт 49: Кастодианы мэдээлэл	117
Хүснэгт 50: Хуулийн зөвлөх байгууллагын мэдээлэл	118
Хүснэгт 51: Хөндлөнгийн аудитын байгууллагын мэдээлэл	119



2026-07-20

БҮРТГЭВ-03

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

CSA
2026.07.09
БҮРТГЭВ
№ 01

Зураг 1: Зардлын аргаар тооцсон АНУ-ын түүхэн эдийн засгийн өсөлт, түүний задаргаа	20
Зураг 2: АНУ-ын эдийн засгийн өсөлтийн таамаглал, 2026 он	20
Зураг 3: АНУ-ын түүхэн тарифын орлого	21
Зураг 4: Дэлхийн бүс нутгуудын түүхэн инфляцын түвшин, цаашдын таамаглал	21
Зураг 5: Дэлхийн бүс нутгуудын түүхэн бодлогын хүүгийн түвшин, цаашдын төсөөлөл	22
Зураг 6: Монгол Улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд	23
Зураг 7: Монгол Улсын эдийн засгийн мөчлөг	24
Зураг 8: Монгол Улсын ДНБ, ам.доллароор	24
Зураг 9: Монгол Улсын инфляцын түвшин	25
Зураг 10: Монголбанкны бодлогын хүүгийн түүхэн үзүүлэлт болон 2026 оны таамаглал	26
Зураг 11: Монголбанкны бодлогын хүүгийн түүхэн үзүүлэлт болон 2026 оны таамаглал	26
Зураг 12: Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний түүх	27
Зураг 13: S&P 500 индекс дэх компаниудын нэгж хувьцаанд ногдох ашгийн харьцааны өсөлт, салбараар, 2025 оны 3-р улирал	28
Зураг 14: S&P500 индекс дэх компаниудын цэвэр хөрөнгө болон ХТЭХӨА-ийн харьцааны түүхэн үзүүлэлт	29
Зураг 15: Хиймэл оюун ухааны технологитой холбоотой зардал, тэрбум ам.доллар	29
Зураг 16: Үнэт цаасны зах зээлийн голлох үзүүлэлтүүд, 2025 оны 3-р улирал	30
Зураг 17: Технологийн хөгжлийн түүхэн үе шат	31
Зураг 18: Бүтээгч хиймэл оюун ухаан (Generative AI)-ны зах зээлийн орлогын өсөлтийн таамаглал	36
Зураг 19: Дэлхийн зэсийн эрэлтийн салбарын задаргаа, 2025-2040 он	37
Зураг 20: Дэлхийн зэсийн эрэлт болон нийлүүлэлт, 2025-2040 он	38
Зураг 21: Дата төвүүдийн цахилгааны хэрэглээтэй холбоотой мэдээлэл	41
Зураг 22: Нийт үйл ажиллагаа явуулж буй хамтын сангийн тоо, удирдаж буй хөрөнгийн хэмжээ (AUM), их наяд ам.доллар	43
Зураг 23: Нийт үйл ажиллагаа явуулж буй хамтын сангуудын хөрөнгө оруулалтын хуваарилалт, бүс нутгаар	43
Зураг 24: Дэлхий дээр үйл ажиллагаа явуулж буй ETF-ийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ, тэрбум ам.доллар	44
Зураг 25: АНУ-ын хамтын ХОС болон ETF-ийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ	44
Зураг 26: АНУ дахь хамтын ХОС болон ETF-ийн тоо ширхэг, хувиар	44
Зураг 27: Нийт үйл ажиллагаа явуулж буй хедж сангуудын удирдаж буй хөрөнгө (AUM), их наяд ам.доллар	46
Зураг 28: Дэлхий дээр үйл ажиллагаа явуулж буй тэтгэврийн сангийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ, их наяд ам.доллар	46
Зураг 29: Нийт үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын сангийн бүрэлдэхүүн, ХОС-ийн хэлбэрээр, 2024 оны байдлаар	47
Зураг 30: ХОС-ийн удирдлагын бүтэц	58
Зураг 31: ХОМК-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл	63
Зураг 32: ХОМК-ийн бүтэц, зохион байгуулалт	64
Зураг 33: ХОС-ийн үйл ажиллагааны ерөнхий схем	74
Зураг 34: Индексийн багц болон АНУ-ын хувьцааны зах зээлийн голлох индексийг дагадаг ETF-ийн үр дүн	80
Зураг 35: ХОС-ийн эрсдэлийн удирдлагын гурван давхар хамгаалалтын шугам болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо	82
Зураг 36: Сангийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны зураглал	105
Зураг 37: ХОС-ийн нэгж эрхийг худалдан авах захиалга өгөх заавар	107
Зураг 38: ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах, болон нэгж эрхээ буцаан авах үйл ажиллагаа	108



2025-07-20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР


2026.07.09
БҮРГЭВ
№ 01

Товчилсон үг Тайлбар
Монгол товчилсон үгс

ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГҮТББ	Гишүүддээ Үйлчилдэг Төрийн Бус Байгууллага
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮТӨЦХҮ	Менежментийн Үйлчилгээний Төлбөрийн Өмнөх Цэвэр Хөрөнгийн Үнэлгээ
НҮТББ	Нийгэмд Үйлчилдэг Төрийн Бус Байгууллага
ОУВС (IMF)	Олон Улсын Валютын Сан
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
СЭЗИС	Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ҮЦЗЗ	Үнэт Цаасны Зах Зээл
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв
ҮЦК	Үнэт Цаасны Компани
ХАА	Хөдөө Аж Ахуй
ХБАС	Хамтын Биржээр Арилжаалагддаг Сан
ХБҮЦ	Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас
ХК	Хувьцаат Компани
ХОБХ	Хөрөнгө Оруулалтын Бодлогын Хороо
ХОС	"Фьючер Тек Инновэйшн хамтын биржээр арилжаалагддаг ХОС" ХХК
ХОМК	"Балансэд Грөүт Менежмент" ХХК
ХТЭХӨА	Хүү, Татвар, Элэгдэл, Хорогдлын Өмнөх Ашиг
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ХХН	Хязгаарлагдмал Хариуцлагатай Нөхөрлөл
ШУТИС	Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль
ЭЗХАХБ (OECD)	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Ба Хөгжлийн Байгууллага

Гадаад товчилсон үгс

ADR	American Depositary Receipt – Америкийн хадгаламжийн бичиг
AI	Artificial Intelligence – Хиймэл оюун ухаан
AUM	Assets Under Management – Удирдаж буй хөрөнгийн хэмжээ
AWS	Amazon Web Services – Amazon компанийн үүлэн тооцооллын үйлчилгээ
CAGR	Compounded Annual Growth Rate – Жилийн дундаж нийлмэл өсөлт/өгөөж
CFA	Chartered Financial Analyst – Итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч
CPU	Central Processing Unit – Төв процессор
EAM	Ensemble Active Management – Ханасан олонлогт тулгуурласан актив удирдлага
EPS	Earnings Per Share – Нэгж хувьцаанд ногдох ашиг
ETF	Exchange Traded Fund – Биржээр арилжаалагддаг сан
EY	Ernst & Young
FATF (ФАТФ)	Financial Action Task Force – Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллага
GPU	Graphics Processing Unit – График процессор
HDFS	Hadoop Distributed File System – Hadoop-ийн тархмал файл хадгалах систем
IBM	International Business Machines – Олон улсын мэдээллийн технологийн компани
IMF	International Monetary Fund – Олон Улсын Валютын Сан



Нэр томьёо БҮРТГЭВ-03 Тайлбар

Бирж	Монгол Улсын хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, гадаад улсын хувьд тухайн улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг нийтэд санал болгон худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нөхцөлийг бүрдүүлж, үнэт цаасны арилжааг зохион байгуулах чиг үүрэг бүхий үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж буй хуулийн этгээд. /Тухайн улсын хууль тогтоомж, дүрэм журамд өөрөөр тодорхойлж болно/
Бодлогын баримт бичиг	ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зорилго, стратеги, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарчим, чиглэл, хөрөнгө оруулалтын багц, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавигдах хязгаарлалт болон холбогдох бусад харилцааг зохицуулах хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг.
Гаргасан нэгж эрх	Нэгж эрх эзэмшигчдэд худалдсан нэгж эрх бөгөөд энэ нэгж эрхийн хэмжээгээр хөрөнгө оруулалтын сангийн эзэмшил тодорхойлогдоно.
Зарласан нэгж эрх	Хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан хөрөнгө оруулалтын сангийн зарласан нэгж эрх.
Кастодиан	Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг тухайн сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдаж буй хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр тооцоог гүйцэтгэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг холбогдох хууль тогтоомж болон хөрөнгө хадгалах гэрээний хүрээнд үзүүлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ҮЦЗЗ-д зохицуулалттай хуулийн этгээд.
Мэргэжлийн оролцогч	ХОС-ийн нэгж эрхийг хөрөнгө оруулалтын багцаар солилцож, нэгж эрхийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд арилжаалах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий ҮЦЗЗ-д зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий үнэт цаасны компани.
Мэргэжлийн оролцогчийн гэрээ	ХОС болон Мэргэжлийн оролцогчийн хооронд байгуулагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг хөрөнгө оруулалтын багцаар солилцох гэрээ".
Нэгж эрх	Хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаас.
Нэгж эрх эзэмшигч	Тухайн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулж сангийн нэгж эрхийг эзэмшигч иргэн, хуулийн этгээд.
Нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл	Холбогдох гэрээний үндсэн дээр нэгж эрх эзэмшигч гишүүдийн бүртгэлийг хөтөлж буй Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын хөтлөх бүртгэл.
Нэгж эрх эзэмшигчдийн хурал	Хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага

2026-07-20

СЭХ
2026.07.09 өдөр

БҮРТГЭВ

Нэгж эрхийг
танилцуулга

БҮРТГЭВ-03

Хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах саналыг хүргүүлэхтэй холбоотой, уг санг үүсгэн байгуулагчаас холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журмын дагуу бэлтгэсэн баримт бичгийн бүрдэл.

Хамтын хөрөнгө оруулалтын сан	Нэгж эрхээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгон хөрөнгө төвлөрүүлэх эрх бүхий хөрөнгө оруулалтын сан.
ХОМК	ХОС-тай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр ХОС-ийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд буюу "Балансэд Грөүт Менежмент" ХХК.
ХОС	ХОМК-ийн удирдлага дор мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нэгж эрхээ олон нийтэд нээлттэй санал болгох замаар хөрөнгө төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг төлөөлж ажиллах "Фьючер Тек Инновэйшн хамтын биржээр арилжаалагддаг ХОС" ХХК.
ХОС-ийн актив	Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүн.
ХОС-ийн нэгж эрхийн нэрлэсэн үнэ	Хөрөнгө оруулалтын сангийн дүрмээр тогтоосон ХОС-ийн нэгж эрхийн нэрлэсэн үнэ.
ХОС-ийн ТУЗ	ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын чөлөөт цагт ХОС-ийн эрх барих дээд байгууллага.
Хөрөнгө оруулалтын зөвлөх	ХОМК-аас томилогдсон ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий мэргэшсэн үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх.
Хөрөнгө оруулалтын менежментийн компани	Тухайн хөрөнгө оруулалтын сантай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдаж буй, Хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд.
Хөрөнгө оруулалтын сан	Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах сан.
Хөрөнгө оруулалтын сангийн зардал	Хөрөнгө оруулалтын санд бусдаас үзүүлэх хөрөнгө итгэмжлэн удирдах, кастодиан, брокер, нягтлан бодох бүртгэлийн зэрэг үйлчилгээний нийт төлбөр.
Хөрөнгө оруулалтын хэрэгсэл	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн хүрээнд Хорооноос тогтоосон бөгөөд тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогод заасан хөрөнгө оруулалт хийж болох санхүүгийн хэрэгсэл.
Хөрөнгө оруулалтын багц	Тухайн хөрөнгө оруулалтын сангийн Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн дагуу хөрөнгө оруулалтын хэрэгслээр бүрдүүлсэн багц.
Хөрөнгө хадгалах гэрээ	ХОС болон Кастодианы хооронд байгуулсан "Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээ".



2026-07-20

Хөрөнгийн бирж

БҮРТГЭВ-03

ХОС-тай "Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ"-г байгуулсны үндсэн дээр ХОС-ийн нэгж эрхийн арилжааг зохион байгуулах чиг үүрэг бүхий этгээд буюу "Монголын Хөрөнгийн Бирж" ХК.

Хувийн хөрөнгө
оруулалтын сан

Нэгж эрхээ мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгон гэрээний үндсэн дээр хөрөнгө төвлөрүүлэх эрх бүхий хөрөнгө оруулалтын сан.

Хувь нийлүүлсэн
хөрөнгө

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн нэгж эрхийн нэрлэсэн үнийн дүн.

Цэвэр хөрөнгийн
үнэлгээ эсхүл Цэвэр
активын үнэлгээ

Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хасаад үлдсэн хөрөнгийн дүн.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026-07-20

БҮРТГЭВ-03

СЭХ

2026.07.09 өдөр

БҮРТГЭВ

№ 01

O1

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



1.1. **2026 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

ХОС-ийн талаарх ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1: ХОС-ийн товч танилцуулга

ХОС-ийн хуулийн этгээдийн бүртгэл


ХОС-ийн оноосон нэр	▪ "Фьючер Тек Инновэйшн хамтын биржээр арилжаалагддаг ХОС" ХХК
ХОС-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар	▪ 9011894544
ХОС-ийн регистрийн дугаар	▪ 7295945
Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	▪ 2026 оны 06-р сарын 17-ны өдөр
Үйл ажиллагааны чиглэл	▪ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа
ХОС-ийн хэлбэр	▪ Хамтын ХОС
ХОС-ийн төрөл	▪ Нэгж эрхээ зохицуулалттай этгээдийн эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгслээр солих замаар сангийн активаа бүрдүүлдэг, бирж дээр нэгж эрх нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан (Биржээр арилжаалагддаг сан буюу Exchange traded fund)
ХОС-ийн стратегийн төрөл ¹	▪ Үнэт цаасны индексийн сан буюу арилжаа эрхлэх байгууллагаас тооцон гаргадаг индексийн багцад багтдаг үнэт цаасанд хөрөнгө оруулах сан.
ХОС-ийн үйл ажиллагаа явуулах хугацаа	▪ 10 жил (Энэ хугацааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу нэг удаа сунгаж болно)
ХОС-ийн Гүйцэтгэх захирал ²	▪ Д.Одмаа

ХОС-ийн Хөрөнгө оруулалтын удирдлага

ХОС-ийн баримтлах индекс	▪ Фьючер Тек Инновэйшн Индекс (цаашид "Индекс" гэх)
Индекс тооцогч	▪ "Монголын Хөрөнгийн Бирж" ХК
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зорилго	▪ ХОС нь үйл ажиллагааны зардлыг тооцохоос өмнөх өгөөжийн гүйцэтгэлийг Хөрөнгийн биржийн тооцон гаргадаг Фьючер Тек Инновэйшн Индекс (Future Tech Innovation Index)-ийн гүйцэтгэлтэй ойролцоо байлгахыг зорьж ажиллана. ▪ ХОС нь Индексийг дагахдаа бүрэн хуулбарлах (Full replication) замаар идэвхгүй буюу пассив хөрөнгө оруулалтын удирдлагын стратегийг хэрэгжүүлнэ.
Хөрөнгө оруулалтын стратеги	<i>Идэвхгүй хөрөнгө оруулалтын удирдлага гэдэг нь ХОС өөрийн үйл ажиллагаандаа баримтлахаар сонгосон индексийн багцын бүтэцтэй нийцүүлэн хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлж, тухайн индексийн гүйцэтгэлтэй ойролцоо өгөөж хүртэхийг зорьдог стратеги юм.</i> ▪ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх; ▪ Ашигт малтмалын бүтээгдэхүүнд суурилсан хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх; ▪ Мөнгөн хөрөнгө, 12 сараас ихгүй хугацаатай банкны хадгаламж, гадаад улсын Засгийн газраас гаргасан богино хугацаатай үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан богино хугацаатай үнэт цаас болон Монгол Улсын Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас; ▪ Холбогдох хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас баталсан журам, тогтоол, шийдвэрийн дагуу зөвшөөрөгдсөн бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүд.
ХОС-ийн хөрөнгө оруулах боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгсэл	

¹ Хорооны 2025 оны 02-р сарын 25-ны өдрийн 64 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам"-ын 16 дугаар зүйлийн 16.1-т хамтын ХОС-г хөрөнгө оруулалтын стратегиас хамааруулан ангилахаар заасан болно.

² ХОС-ийн Гүйцэтгэх удирдлагыг Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр ХОМК хэрэгжүүлэх ба ХОС-ийн ТУЗ-өөс ХОМК-ийн Гүйцэтгэх захирлыг, эсхүл түүний санал болгосон этгээдийг ХОС-ийн Гүйцэтгэх захирлаар томилно.



ХОС-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх

- Ж.Номин
- Б.Анхбаяр
- Менежментийн үйлчилгээний төлбөр: Жилийн 1.5%³

ХОМК-д төлөх төлбөр

Энэхүү төлбөртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Танилцуулгын 57-р хуудаснаас харна уу.

ХОС-ийн үйл ажиллагаанд оролцогч талууд

ХОМК

- "Балансэд Грөүт Менежмент" ХХК

Кастодиан

- "Голомт Банк" ХК

Хөндлөнгийн аудитын байгууллага⁴

- "Мэжикконсалтинг аудит" ХХК
- "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК
- "Голомт Капитал ҮЦК" ХХК
- "Таван Богд Капитал ҮЦК" ХХК
- "Алекс Капитал ҮЦК" ХХК

Мэргэжлийн оролцогч

Нэгж эрх гаргах үйл ажиллагаанд оролцогч тал

Хөндлөнгийн хуулийн зөвлөх

- "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН

³ ХОС-аас ХОМК-д төлөх МҮТӨЦХҮ-нд үндэслэн тооцоолно.

⁴ Хөндлөнгийн аудитын байгууллагыг өөрчлөх, сонгох асуудлыг ХОС-ийн ТҮЗ-ийн хурлаар шийдвэрлэх тул хөндлөнгийн аудитын байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр олон нийтэд мэдээлнэ.



2026-07-20

1.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

БҮРТГЭВ-03

СЭХ
2026.07.09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХОС-ийн санал болгож буй нэгж эрхтэй холбоотой товч мэдээллийг дараах байдлаар танилцуулж байна.

Хүснэгт 2: ХОС-ийн нэгж эрхийн товч танилцуулга

ХОС-ийн нэгж эрхийн талаарх мэдээлэл

Үнэт цаасны төрөл	■ ХОС-ийн нэгж эрх
ХОС-ийн нэгж эрхийн нэрлэсэн үнэ	■ 1,000 төгрөг
ХОС-ийн зарласан нэгж эрхийн тоо, ширхэг	■ 200,000,000 ширхэг
ХОС-д татан төвлөрүүлэх хөрөнгийн дээд хэмжээ	■ 200,000,000,000 төгрөг
ХОС-ийн анхдагч зах зээлд татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ ⁵	■ 10,000,000,000 төгрөг

ХОС-ийн нэгж эрхийн арилжаа

Нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа	■ ХОС нь зарласан нэгж эрхээ Мэргэжлийн оролцогчийн эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын багцаар солих замаар хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлэх тул ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа нь зөвхөн ХОС болон Мэргэжлийн оролцогч нарын хооронд явагдана. ■ ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа буюу нэгж эрхийг олон нийтэд нээлттэй санал болгох, худалдахтай холбоотой ажиллагааг Мэргэжлийн оролцогч хэрэгжүүлнэ.
Нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа	■ Мэргэжлийн оролцогч нь ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг Хөрөнгийн биржээр дамжуулан явуулж, ХОС-ийн нэгж эрхийн Зах зээл үүсгэгчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. ■ Мэргэжлийн оролцогч нь ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нэгж эрхийг эцсийн хөрөнгө оруулагчдад санал болгох ба эцсийн хөрөнгө оруулагч нь нэгж эрхийг зөвхөн мөнгөн хөрөнгөөр Хөрөнгийн бирж дээрээс худалдан авна.
Нэгж эрх арилжаалагдах бирж	■ "Монголын Хөрөнгийн Бирж" ХК
Нэгж эрхийн симбол	■ FTI
Нэгж эрхийн үнэ илэрхийлэгдэх валют	■ Монгол төгрөг (MNT) ■ ХОС-ийн нэгж эрх нь Хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалагдана.
Нэгж эрхийн хөрвөх чадвар	■ Мэргэжлийн оролцогчид нь ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийг үүсгэх буюу хөрвөх чадварыг хангаж ажиллана.

⁵ ХОС-ийн анхдагч зах зээлээс татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ нь 5.0 тэрбум төгрөг байна.



Давуу тал, онцлог

Товч мэдээлэл

Дэлгэрэнгүй

- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц Future Tech Innovation индексийг дагах бөгөөд тус Индекс нь хиймэл оюун ухааны технологид суурилсан салбарууд болон түүнийг хүрээлсэн экосистем буюу чип үйлдвэрлэл, эрчим хүч, түүхий эд зэрэг чиглэлүүдийг нэгтгэсэн бүрэлдэхүүнтэй билээ.


Хиймэл оюун ухааны дэд бүтцийн эрэлтийн холбоо хамаарал



Ирээдүйг нэг багцад

ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын бүрдэл /Индексийн багцад үндэслэв/

76-р хуудас



- ✓ Хөрөнгө оруулагч нь өөрийн харилцдаг дотоодын брокерын компаниар дамжуулан "Монголын Хөрөнгийн Бирж" ХК дээрээс Future Tech Innovation ETF-ийг худалдан авч, хөрөнгө оруулах боломжтой. ХОС нь хөрөнгө оруулалтын багцаа ам.доллараар бүрдүүлэх тул хөрөнгө оруулагч ам.долларын өгөөжийг өөрийн багцдаа оруулах боломжтой.



Монголын хөрөнгийн биржээс дэлхийн зах зээлд хөрөнгө оруулах



107-р хуудас



БҮРТГЭВ-03

2026.07.09
ОН САР АЛАД
БҮРТГЭВ
№ 01

02

САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗАХ ЗЭЭЛ

FTI

ХАМТЫН БИРЖЭЭНИЙН
ХОС ХЯК

УЛААНБААТАР ХОТ

7295-
9086

2.1026 - МАКРО ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.11 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

БҮРТГЭВ-03

CSX
2026.07.09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Дэлхийн эдийн засгийн цаашдын чиг хандлага: 2025 онд дэлхийн эдийн засаг харьцангуй сайн гүйцэтгэлтэй байсан ба үүнд, АНУ-ын импортын тарифын өөрчлөлт, түүнтэй холбоотой улс төрийн тодорхойгүй байдал зэрэг хүчин зүйлсийг дэлхийн улс орнууд харьцангуй сайн даван туулсан нь голлон нөлөөлжээ. Улмаар, Олон Улсын байгууллагын шинжээчид дэлхийн эдийн засгийг 2025-2027 онд жилд дунджаар 3.0%-3.1%-ийн өсөлт үзүүлнэ гэж таамаглаж байна.

Хүснэгт 4: Дэлхийн бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал, бүс нутгаар

Улс	2025 оны эдийн засгийн өсөлт				2026 оны эдийн засгийн өсөлт				2027 оны эдийн засгийн өсөлт		
	Bloomberg	OYBC	OECD	Дундаж	Bloomberg	IMF	OECD	Дундаж	Bloomberg	OECD	Дундаж
Дэлхий	3.0%	3.2%	3.2%	3.1%	2.9%	3.1%	2.9%	3.0%	3.0%	3.1%	3.1%
АНУ	2.0%	2.0%	2.0%	2.0%	2.0%	2.1%	1.7%	1.9%	2.0%	1.9%	2.0%
Евро бүс	1.4%	1.2%	1.3%	1.3%	1.1%	1.1%	1.2%	1.1%	1.4%	1.4%	1.4%
БНХАУ	4.9%	4.8%	5.0%	4.9%	4.5%	4.2%	4.4%	4.4%	4.2%	4.3%	4.3%

Эх сурвалж: ЭЗХАХБ (OECD), ОУВС (IMF), Bloomberg Economics

БНХАУ-ын эдийн засаг нь 2025 оны 2-р улиралд шинжээчдийн төсөөллөөс өндөр буюу өмнөх оны мөн үеэс 5.2%-аар өссөн байна. Хэдийгээр үл хөдлөх эд хөрөнгийн салбарын хямрал үргэлжилж байгаа боловч экспорт, үйлчилгээний болон аж үйлдвэрийн салбарын өсөлт нэмэгдсэн нь 2-р улирлын бодит эдийн засгийн өсөлт шинжээчдийн хүлээлтээс давах гол шалтгаан болжээ. Дэвшилтэт технологи дахь хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр аж үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл өссөн гэж шинжээчид үзэж байна.

Евро бүсийн эдийн засаг 2025 оны 2-р улиралд өмнөх оны мөн үеэс 1.4%-аар өссөн үзүүлэлттэй байна. Мөнгөний зөөлөн бодлогын нөлөөгөөр хэрэглээ, хөрөнгө оруулалт алгуур сэргэж байгаа бол тайлант улиралд экспорт, тэр дундаа БНХАУ руу чиглэсэн экспорт өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн, Евро бүсийн зарим улс орнууд АНУ-тай худалдааны хэлэлцээр амжилттай хийсэн нь тодорхой бус байдлыг бууруулан улмаар, 2025 оны өсөлтийн төсөөлөл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.


АНУ-ын эдийн засаг 2025 оны 2-р улирлын байдлаар 3.8% (жилчилсэн)-ийн өсөлт үзүүлсэн ба үүнд, хиймэл оюун ухаан (AI) болон дата төвүүдийн барилгын ажилд оруулсан хөрөнгө оруулалт болон импортын тарифын бодлогоос үүдэн импортын хэмжээ буурч, улмаар цэвэр экспортын түвшин өссөн зэрэг нь өсөлтөд голлон нөлөөлсөн байна.



Зураг 1: Зардлын аргаар тооцсон АНУ-ын түүхэн эдийн засгийн өсөлт, түүний задаргаа

БҮРТГЭВ-03


2026.07.09 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Эх сурвалж: Bloomberg Economics

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп татварын ачааллыг бууруулах, төрийн зарцуулалтыг оновчлох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх зорилготой "One Big Beautiful Bill Act" (OBVBA) хуулийг 2025 оны 7-р сарын 04-ний өдөр баталсан. 2025 оны хувьд уг хуулийн нөлөө ихэвчлэн хөрөнгө оруулалтын урамшуулал, эрэлтийг нэмэгдүүлэх зэрэг хэлбэрээр илэрч байгаа ба энэ нь тоног төхөөрөмж, судалгаа шинжилгээнд хийсэн зардлыг бүрэн зардалд тооцох боломж олгож байна. Өрхүүдэд чиглэсэн шинэ татварын хөнгөлөлтүүд мөн 2025 оны эхнээс хэрэгжиж эхэлсэн байна. Эдгээр хүчин зүйлсэд үндэслэн суурь төсөөллөөр бодит ДНБ-ий өсөлт 2025 оны 4-р улиралд ойролцоогоор 1% орчим болон саарч, 2026 оны эхний хагаст 3%-ийн түвшинд эргэж өсөөд, 2026 оны эцсээр 1%-2%-ийн түвшинд тогтворжино хэмээн шинжээчид үзэж байна.

Зураг 2: АНУ-ын эдийн засгийн өсөлтийн таамаглал, 2026 он



Эх сурвалж: Bloomberg Economics

АНУ нь импортын тарифаа огцом нэмэгдүүлснээр 2025 оны 6-р сараас 9-р сарын хооронд сар тутмын дундаж нь 29 тэрбум ам.доллараас давсан татварын орлого бүрдсэн байна. Одоогийн байдлаар эдгээр тарифтай холбоотой зардлын ихэнхийг АНУ-ын жижиглэнгийн худалдаачид өөрсдөө шингээсэн гэж эдийн засагчид үзэж байгаа бөгөөд 2025 оны 4-р улирал болон 2026 онд энэхүү зардлыг хэрэглэгчдэд үнээр дамжуулан "шилжүүлэх" хандлага нэмэгдэнэ үзэж байна. Одоогийн түвшнээс тарифын хэмжээ өөрчлөгдөхгүй гэж үзвэл, тарифын өсөлт нь 2025 оны эхний

хагаст жилийн инфляцын түвшнийг нэмэгдүүлж, бодит хэрэглээний зардлыг шахах нөлөө үзүүлээд, түүнээс цааш макро түвшний нөлөө нь аажмаар буурах хүлээлттэй байна.

БҮРТГЭВ-03

Зураг 3: АНУ-ын түүхэн тарифын орлого




Эх сурвалж: Bloomberg Economics

Улс орнуудын инфляцын түвшин, цаашдын чиг хандлага

2020 оны цар тахлын дараагаар мөнгөний болон сангийн тэлэх бодлого, геополитикийн нөхцөл байдлын улмаас дэлхийн улс орнуудын инфляц сүүлийн 30-40 жилийн хугацаан дахь хамгийн өндөр түвшиндээ хүрсэн билээ. Үүний үр дүнд дэлхийн ихэнх улс орнуудын мөнгөний бодлого боловсруулагчид мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлснээр инфляцын эрч саарсаар байгаа ч төв банкнуудын зорилтот түвшнээс өндөр хэвээр байна.

Зураг 4: Дэлхийн бүс нутгуудын түүхэн инфляцын түвшин, цаашдын таамаглал



Эх сурвалж: Bloomberg Economics

АНУ: АНУ-ын жилийн инфляцын түвшин 2025 оны 9-р сарын байдлаар 3.0%-д хүрч нэмэгдсэн байна. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын улс орнуудад тогтоосон импортын өндөр тариф хэрэгжиж эхэлснээр 2025 оны эцсээр инфляцын түвшин 3.0%-ийг давж нэмэгдэх төлөвтэй байсан ч ажилгүйдлийн түвшин өсөж, иргэдийн эрэлт сулран, газрын тосны үнэ тогтвортой бага түвшинд байгаа зэрэг хүчин зүйлсээс үүдэн 3.0%-аас бага гарна гэж шинжээчид үзэж байна. Түүнчлэн, ирэх 2 жилийн хугацаанд АНУ-ын инфляцын түвшин алгуур буурч төв банкны зорилтот түвшин болох 2.0%-д хүрч буурна гэсэн хүлээлт зах зээлд үүсээд байна.

БНХАУ: БНХАУ-ын дотоодын эрэлт сул байгаагаас шалтгаалж инфляц бага түвшинд байсаар байна. Үйлдвэрлэгчийн үнийн индекс сүүлийн 34 сар дараалан жилийн өмнөх үеэс буураад байгаа бол 2025 оны 7-р сарын байдлаар жилийн инфляцын түвшин 0.0% байсан байна.

Евро бүс: Евро бүсийн инфляц сүүлийн улирлуудад аажмаар саарч, Европын Төв Банкны зорилтот түвшинтэй ойртох хандлага ажиглагдаж байна. Эрчим хүч болон хүнсний үнийн өсөлт тогтворжсон, мөн мөнгөний хатуу бодлогын нөлөө дотоод эрэлтийг сааруулснаар үнийн дарамт буурч байгаа боловч үйлчилгээний салбарын инфляц болон цалинтай холбоотой зардлын өсөлт харьцангуй өндөр хэвээр байна.



2026-07-20

Улс орнуудын бодлогын хүү, цаашдын чиг хандлага

БҮРТГЭВ-03

СЗХ


2026.07.09 өдөр

БҮРТГЭВ

№ 01

АНУ: АНУ-ын Холбооны Нөөцийн Сан нь 2025 оны эхэн үеэс хойш бодлогын хүүд өөрчлөлт оруулаагүй ба 2025 оны 9-р сарын хурлаар 0.25%-аар бууруулж 4.0%-4.25%-ийн интервалд, 10-р сарын хурлаар мөн 0.25%-аар бууруулж 3.75%-4.00%-ийн интервалд хүргэх шийдвэрийг гаргаад байна. Эдийн засагчид болон Олон Улсын байгууллагуудын шинжээчид Холбооны Нөөцийн Санг бодлогын хүүгээ 2026 оны эцэс хүртэл нийтдээ 2-3 удаа бууруулна гэсэн хүлээлттэй байна.

Зураг 5: Дэлхийн бүс нутгуудын түүхэн бодлогын хүүгийн түвшин, цаашдын төсөөлөл



Эх сурвалж: Bloomberg Economics

БНХАУ: БНХАУ-ын Ардын банкнаас 2025 оны 5-р сарын хурлаар бодлогын гол хүүнүүдээ 0.1%-аар бууруулж, түүнээс хойш өөрчлөөгүй байна.

Евро бүс: Европын төв банк 2025 оны 9-р сарын 11-ний өдрийн хурлаар бодлогын хүүгээ 2.15% түвшинд хэвээр хадгалах шийдвэр гаргасан ба шинжээчид 2025 оны төгсгөлд бодлогын хүүгээ дахин 0.25%-аар бууруулна гэж таамаглаж байна.



22

22

Монгол Улсын макро эдийн засгийн голлох түүхэн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Зураг 6: Монгол Улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын эдийн засгийн өсөлт

Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлт 2020 оны цар тахлын дараагаар 2022 болон 2023 онуудад хүчтэй сэргэж өндөр өсөлттэй байсан бол 2024 оны эцэс болон 2025 оны эхний 2 улирлын байдлаар буцаад аажмаар саарч байгаа дүр зураг ажиглагдаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар дотоодын эдийн засаг 5.6%-аар тэлсэн бөгөөд үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлжээ. Үүнд:

- ✓ Өвөл, хаврын саруудад цаг агаар таатай байж, ХАА-н салбар 35.6%-аар тэлж, нийт өсөлтийн 3.6%-ийг дангаараа бүрдүүлсэн;
- ✓ Аж үйлдвэр, барилгын салбар эхний хагас жилд 9.6%-аар нэмэгдэж, нийт өсөлтийн 1.0%-ийг бүрдүүлсэн;
- ✓ Орон сууц, эмнэлэг, сургууль, төмөр замын барилгын ажлын гүйцэтгэл өндөр байж барилгын салбар 25.2%-аар өссөн;
- ✓ Бөөрөлжүүтийн цахилгаан станц ашиглалтад орсон нь эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг дэмжсэн;
- ✓ Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл эрчимжиж, зэсийн баяжмалын олборлолт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад огцом нэмэгдсэн хэдий ч бусад гол түүхий эдийн олборлолт болох нүүрс 11.4%, газрын тос 11.0%, алт 16.2%-аар тус тус буурсантай холбоотойгоор уул уурхайн салбар эхний хагас жилд төдийлөн өсөлт үзүүлээгүй байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв


Сүүлийн 25 жилийн хугацааны өсөлтийн тоон мэдээллээс харвал Монгол Улсын эдийн засаг 6 жилийн мөчлөгтэйгөөр урт хугацааны дундаж өсөлтөөсөө өсөж, буурсан дүр зураг ажиглагдаж байгаа бөгөөд хамгийн сүүлд 2021 онд эдийн засгийн уналтын дараагаар 2022 болон 2023 онуудад хүчтэй өсөлт үзүүлж сүүлийн 2 жилийн хугацаанд тогтворжих хандлагатай байна.

2026-07-20

Зураг 7: Монгол Улсын эдийн засгийн мөчлөг

БҮРТГЭВ-03

СЗХ
2026.07.20
БҮРТГЭВ
№ 01




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ХОМК-ийн тооцоолол

Түүнчлэн, 2000-2024 оны хугацаанд Монгол Улсын бодит эдийн засаг жилд дунджаар 6.0%-аар өссөн ба ОУВС-ийн шинжээчид болон Сангийн яамны зүгээс 2025-2030 он хүртэлх хугацаанд ойролцоогоор таван-н бодит өсөлт үзүүлнэ гэж таамаглаж байна. Энэхүү эдийн засгийн өсөлтийн таамаглал нь дараах үндсэн хүчин зүйлсэд үндэслэсэн байна. Үүнд:

- ✓ Нүүрсний экспортын хэмжээ 2025-2027 онуудад харгалзан 80, 83.8, 88.8 сая тонн байх;
- ✓ Төсөвт тусаагүй мега төслүүдийн бүтээн байгуулалтад 2025 онд 458 сая ам.доллар, 2026 онд 1,093 сая ам.доллар, 2027 онд 638 сая ам.долларын санхүүжилтүүд тус тус хийгдэх;
- ✓ Цаг агаарын урьдчилсан төлөв хэвийн байх тохиолдолд.

Инфляцын түвшнээр засварласан бодит ДНБ нь сүүлийн 10 жилийн хугацаанд өсөлттэй байгаа хэдий ч үүнийг ам.доллараар илэрхийлбэл өсөлттэй биш харин ч уналттай буюу 12%-аар буурсан байна.

Зураг 8: Монгол Улсын ДНБ, ам.доллараар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, ХОМК-ийн тооцоолол



Монгол Улсын инфляцын түвшин

Монгол Улсын инфляцын түвшин цар тахлын үетэй харьцуулахад буурсан боловч Монголбанкны зорилтот түвшнээс өндөр хэвээр байна. Инфляцын түвшин улсын хэмжээнд 2025 оны 11-р сард өмнөх оны мөн үеэс 8.2%-аар, өмнөх сараас 0.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 9: Монгол Улсын инфляцын түвшин



Эх сурвалж: Монголбанк, ХОМК-ийн тооцоолол

2026 онд эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс бага зэрэг сааран эрэлтийн шинжтэй инфляцын дарамт багасах, гадаад инфляц өмнөхөөс саарах зэргээс шалтгаалан хүнсний бус инфляц буурахаар байна. Харин 2025 онд хуурай зун болсноос үүдэн импортын хүнсний үнэ нэмэгдэх, дотоод зах зээлд мах, гурил, хүнсний ногооны үнэ харьцангуй өндөр үнэтэй байгаа нь хүнсний инфляц 2026 оны эхний хагаст өмнөхөөсөө өсөх хэдий ч энэ оны өндөр өсөлттэй байсан суурь үеийн нөлөөгөөр оны эцсээр өмнөхөөсөө буурахаар байна.

Түүнчлэн, Монголбанк болон Олон Улсын байгууллагуудын зүгээс Монгол Улсын инфляцын түвшнийг энэ оны эцсээр 10% руу өсөж, 2026 болон 2027 онуудад алгуур буурч 6%-8%-ийн түвшинд хүрнэ гэж таамаглаж байна.


Хүснэгт 5: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал

Байгууллага	2025E	2026E	2027E
Монголбанк	8.1%	6.9%	5.1%
ОУВС	8.7%	8.6%	7.9%
Дэлхийн банк	10.0%	8.0%	7.5%
Дундаж	8.9%	7.8%	6.8%

Эх сурвалж: Монголбанк, "Мөнгөний Бодлогын Тайлан" 2025 оны 9-р сар; ОУВС, "Эдийн засгийн таамаглал" 2025 оны 9-р сар, Дэлхийн Банк, "Дэлхийн эдийн засгийн таамаглал" 2025 оны 5-р сар

Монголбанкны бодлогын хүүгийн түвшин


Таамаглалын гол үндэслэл нь ирэх онуудад инфляцын түвшин алгуур буурах, эдийн засгийн өсөлт олон жилийн дунджаасаа бага зэрэг доогуур байх зэрэг хүчин зүйлс байна. Харин эсрэгээрээ инфляц зорилтот түвшиндээ хүртэл буурахгүй байх, түүхийн эдийн дэлхийн зах зээл дэх үнэ буурах, үүний нөлөөгөөр ханш хүчтэй сулрах зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр бидний таамаглалаас өсөх магадлалтай.



2026.07.09

Зураг 10: Монголбанкны бодлогын хүүгийн түүхэн үзүүлэлт болон 2026 оны таамаглал

БҮРТГЭВ-03




Эх сурвалж: Монголбанк, ХОМК-ийн тооцоолол

АНУ-ын долларын ханш

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны эхнээс 5.1%-аар суларч, 2025 оны 3-р улирлын эцсийн байдлаар 3,592.8 төгрөгтэй тэнцэж байна. Төгрөгийн ханш ийнхүү сулрахад 2025 оны эхний хагаст нүүрсний үнэ хурдтайгаар буурсан, экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс багассан нь нөлөөлсөн байна.

ХОМК нь International Parity Condition буюу валютын хүлээгдэж буй ханшийн өөрчлөлт нь тухайн валютын инфляцын түвшин болон хүүгийн түвшний зөрүүтэй уялдан тодорхойлогдоно гэсэн онолын нөхцөлд үндэслэн валютын ханшийн таамаглалыг боловсруулсан. Энэхүү онолын загварыг 2010 оноос хойших түүхэн өгөгдөлд туршин шалгахад, богино хугацаанд таамагласан ханш нь бодит ханшаас зөрөх хандлагатай боловч урт хугацаанд бодит болон таамагласан ханш нэг чиглэлд хөдөлж, ойртон тэнцэх хандлага ажиглагдсан. Үүний үндсэн дээр төгрөгийн ам.доллартой харьцах ханшийг ирэх хоёр жилийн хугацаанд "Суурь", "Сайн", "Муу" гэсэн гурван нөхцөлөөр таамагласан бөгөөд суурь нөхцөлийн хүрээнд төгрөгийн ханш цаашид суларч, хоёр жилийн дараа 1 ам.доллар 4,222 төгрөгт хүрнэ гэж тооцоолж байна.

Зураг 11: Монголбанкны бодлогын хүүгийн түүхэн үзүүлэлт болон 2026 оны таамаглал




Эх сурвалж: Монголбанк, ХОМК-ийн тооцоолол

Монгол Улсын зээлжих зэрэглэл

Монгол Улсын зээлжих зэрэглэл гэдэг нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас тухайн улсад олгосон зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг эргэн төлөх чадварыг, мөн зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм. Монгол Улсын Сангийн яам болон Монголбанкны зүгээс Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 1999 оноос эхлэн Стандарт энд Пүүрс (S&P) Фитч рэйтингс болон Мүүдис Инвесторс Сервис агентлагуудаар тогтоолгож эхэлсэн байна.

Эдгээр агентлагуудаас 2024 оны байдлаар Монгол Улсын эдийн засагт хийсэн судалгаандаа үндэслэн зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B+" болон "B2" түвшинд тогтоосон ба энэ нь Монгол Улс



2025-07-30

түүхэн хугацааны туршид хамгийн өндөр зээлжих зэрэглэлийн түвшиндээ эргэн очсон үйл явдал болоод байна.

БҮРТГЭВ-03

БҮРТГЭВ
№ 01


Хүснэгт 6: Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ, 2024 он

Үнэлгээ тогтоосон агентлаг	Зээлжих зэрэглэл	Зээлжих зэрэглэлийн төлөв	Үнэлгээ гаргасан огноо
Стандарт энд Пүүрс (Эс энд Пи)	B+ (Outlook: Positive)	Тогтвортой	2024 он
Фитч рэйтингс (Фитч)	B+ (Outlook: Stable)	Тогтвортой	2024 он
Мүүдис Инвесторс Сервис (Мүүдис)	B2 (Outlook: Stable)	Тогтвортой	2024 он

Эх сурвалж: Фитч Рейтингс, Стандарт энд Пүүрс (Эс энд Пи) агентлаг, Мүүдис Инвесторс Сервис (Мүүдис) агентлаг


Зураг 12: Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний түүх

Стандарт энд Пүүрс агентлаг



Эх сурвалж: Стандарт энд Пүүрс (Эс энд Пи) агентлаг

Фитч Рейтингс



Эх сурвалж: Фитч Рейтингс

Энэхүү зээлжих зэрэглэлийн үнэлгээний өсөлтөд Монгол Улсын дунд хугацааны эдийн засгийн харьцангуй тогтвортой өсөлт, Засгийн газрын өрийн түвшин, ба нэг хүнд ногдох ДНБ нь "B" зэрэглэлийн орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа зэрэг нь голлон нөлөөлсөн байна. Гэсэн хэдий ч, Монгол Улсын эдийн засаг гадаад санхүүжилт болон БНХАУ руу чиглэсэн түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай, валютын нөөц бага, их хэмжээний гадаад өртэй зэрэг шалтгаанаар гадаад шокод мэдрэмтгий хэвээр байна.



2025-07-20
2.2.

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

БҮРТГЭВ.03

2.2.1. АНУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ




АНУ-ын хувьцааны зах зээл 2025 оны эхний хагаст хэлбэлзэл ихтэй байсан хэдий ч гурав дахь жилд дараалан хоёр оронтой тооны өсөлт (S&P 500 индекс 2025 оны 3-р улирлын байдлаар 17% өссөн байна) үзүүлээ. Энэхүү өсөлт нь АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн бодлогын хүү сүүлийн гурван жил 4%-аас дээш түвшинд хадгалагдсан, хэрэглэгчдийн эрэлт удааширсан, төсвийн дэмжлэг багассан зэрэг макро эдийн засгийн хувьд хязгаарлагдмал орчинд хиймэл оюун ухааны технологийн өсөлттэй холбоотойгоор бий болсноороо онцлогтой.

Улмаар, хиймэл оюун ухааны экосистем дэх компаниудын үнэлгээ хэт өндөр байгаа эсэх нь хөрөнгө оруулагч нарын анхаарлыг татаж байгаа ба хиймэл оюун ухааны технологитой холбоотой хувьцааны зах зээлийн өсөлтийг 2000-д оны "Dotcom хямрал (Интернэтийн хямрал)"⁶-тай харьцуулсан судалгааны үр дүн дараах байдалтай байна. (Хиймэл оюун ухааны технологийн салбарын дэлгэрэнгүй судалгааг энэхүү Танилцуулгын 73-р хуудаснаас харна уу.)

✓ Бодит ашигт суурилсан өсөлт

Интернэтийн хямралын үеийн компаниуд орлогогүйгээр зах зээлийн үнэлгээгээ өсгөж байсан бол өнөөгийн технологийн томоохон компаниудын үнэ болон ашигт ажиллагаа тодорхой түвшинд уялдаатай байна. Тухайлбал, S&P 500 индекс дэх мэдээллийн технологийн салбарын компаниудын нэгж хувьцаанд ногдох ашгийн үзүүлэлт (EPS)⁷ харьцаа үзүүлэлт нь 2025 оны 3-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56%-аар өссөн байна.

Зураг 13: S&P 500 индекс дэх компаниудын нэгж хувьцаанд ногдох ашгийн харьцааны өсөлт, салбараар, 2025 оны 3-р улирал



Эх сурвалж: J.P. Morgan Asset Management

✓ Эрэлтийн мөчлөгийн эхний үе шат

Cloud (клауд технологи буюу үүлэн технологи) үйлчилгээ үзүүлэгчдийн захиалга 2025 оны 3-р улирлын байдлаар 1,202 тэрбум ам.долларт хүрсэн байна. Тухайлбал, Amazon компанийн AWS (Amazon Web Services) буюу үүлэн тооцооллын үйлчилгээ 2022 оноос хойших хамгийн хурдацтай өсөлтөө үзүүлж байгаа нь хиймэл оюун ухааны технологид суурилсан дэд бүтцийн эрэлт тогтвортой байгааг илтгэж байна.

⁶ Dotcom bubble (Дотком хөөс) гэдэг нь 1990-д оны сүүлээс 2000 оны эхэн үед үргэлжилсэн, интернетийн салбарын компаниудын үнэлгээ бодит ашигт ажиллагаанаас хэт давж, таамаглалд суурилан хийсвэрээр өссөн хөрөнгийн зах зээлийн хөөсрөлтийн үе юм.

⁷ Компанийн нэгж хувьцаанд ногдох цэвэр ашгийг илтгэх үзүүлэлт.



2026-07-20


Санхүүгийн эрүүл бүтэц

БҮРТГЭВ-03

AI технологитой холбоотой компанийн томоохон хөрөнгө оруулалтууд нь өрийн санхүүжилтээр бус, компаниудын өөрийн чөлөөт мөнгөн урсгалаар (Free Cash Flow) хийгдэж байна.

- **Бэлэн мөнгөний нөөц:** Hyperscaler⁸-ууд 188 тэрбум ам.долларын бэлэн мөнгөтэй байна.
- **Өрийн харьцаа:** Компанийн цэвэр өр төлбөрийг ХТЭХӨА⁹-т харьцуулсан харьцаа үзүүлэлт 0.8х байгаа нь S&P 500 индексийн дундаж (1.0х)-аас бага байгаа нь эрсдэл багатай байгааг илтгэнэ.

Зураг 14: S&P500 индекс дэх компаниудын цэвэр хөрөнгө болон ХТЭХӨА-ийн харьцааны түүхэн үзүүлэлт




Эх сурвалж: FactSet, Стандарт энд Пүүрс агентлаг, J.P. Morgan Asset Management

✓ Нийлүүлэлт ба эрэлтийн тэнцвэр

Интернэтийн хямралын үед WorldCom, Global Crossing зэрэг компаниуд бодит эрэлтээс давсан хөрөнгө оруулалтыг зээлийн санхүүжилтээр хийж, нийлүүлэлтийн илүүдэл үүсгэснээс үүдэн дампуурсан гэж шинжээчид үзэж байна. AI технологийн хувьд чип үйлдвэрлэгчид болон үүлэн технологийн үйлчилгээ үзүүлэгчдийн "сүлжээ" нь баталгаажсан захиалга болон бодит хэрэглээнд тулгуурлаж байгаагаараа ялгаатай байна.

Томоохон технологийн компаниуд AI технологийн загвар хөгжүүлэлт, хурдтай нэмэгдэж буй тооцооллын эрэлтийг хангахын тулд чип, дата төв, цахилгаан хангамжийг их хэмжээгээр худалдан авч байна. Одоогийн энэхүү өсөлт нь түүхэн дундажтай өндөр түвшинд хүрсэн бөгөөд зөвхөн дата төвийн хөрөнгө оруулалт АНУ-ын ДНБ-ий 1.2%–1.3%-тай тэнцэж байна. Цаашид ч энэ хөрөнгө оруулалтын өсөлт үргэлжилнэ гэж хүлээгдэж байна.

Зураг 15: Хиймэл оюун ухааны технологитой холбоотой зардал, тэрбум ам.доллар



Эх сурвалж: J.P. Morgan Asset Management

⁸ Hyperscalers гэдэг нь асар их хэмжээний тооцооллын нөөц, өгөгдөл хадгалах багтаамж, сүлжээний дэд бүтцийг бий болгон үүлэн байдлаар дата төвийн хэрэгцээг хангадаг компаниудыг ойлгоно. Жишээлбэл үүнд Amazon (AWS), Microsoft (Azure), Google (Google Cloud) зэрэг компаниуд багтаж байна.

⁹ Компанийн хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг.

2025-03-20

МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хорооноос эрхлэн гаргадаг "Санхүүгийн салбарын тойм"-ын 2025 оны 3-р улирлын тайланд 2025.03.20-ны байдлыг үндэслэн дурдсаны дагуу Монгол Улсын ҮЦЗЗ-ийн ерөнхий үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

CSX
2025.03.20
БҮРТГЭВ

Зураг 16: Үнэт цаасны зах зээлийн голлох үзүүлэлтүүд, 2025 оны 3-р улирал

Зах зээлийн үзүүлэлтүүд



Мэргэжлийн оролцогчид



Эх сурвалж: Хороо, "Санхүүгийн салбарын тойм", 2025 оны 3-р улирал

2.2.3. ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Технологийн салбарын түүхэн хөгжил, сүүлийн үеийн томоохон технологийн дэвшлүүд, тэр дундаа хиймэл оюун ухааны салбарын түүх, өнөөгийн нөхцөл байдал болон ирээдүйн чиг хандлага дараах байдалтай байна.

■ Технологийн хөгжлийн түүхэн үе шат

Хүн төрөлхтний технологийн хөгжил нь гал хэрэглэснээс эхлээд хиймэл оюун ухаан хүртэл зургаан үндсэн хувьслын мөчлөгөөр дамжин өргөжиж, нийгмийн бүтцийг өөрчилж, эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэлийн бүтээмжийг тасралтгүй шинэ түвшинд гаргаж ирсэн билээ. Өнөөгийн хиймэл оюуны хувьсгал нь зөвхөн технологийн дэвшил төдийгүй үндэсний аюулгүй байдал, үйлдвэрлэлийн үр ашиг, бизнесийн стратегийн гол хөдөлгүүр болж байна.



2026-07-20

Хүснэгт 7: Хиймэл оюун ухааны хөгжлийн үе шат, түүний мэдээлэл¹⁰

БҮРТГЭВ-03

Үе шат

Он цаг

Гол онцлог ба нээлтүүд

Үзэл санааны үе	1950 оноос өмнөх	• Үндэс суурь: "Машин сэтгэж чадах уу?" гэсэн гүн ухааны асуулт. • Алан Тюринг (1950): "Тюрингийн шалгалт"-ыг (Turing Test) нэвтрүүлж, хиймэл оюуны салбарын суурийг тавьсан.
"Алтан үе"	1950–1960-аад он	• Дартмутын семинар (1956): "Artificial Intelligence" (Хиймэл Оюун Ухаан) нэр томъёог Жон МакКарти анх гаргасан. • Хэт өөдрөг үзэл: Судлаачид 20 жилийн дотор хүнтэй дүйцэхүйц оюун ухаантай машин бүтээх боломжтой гэж үзэж байв.
Анхны "хиймэл оюун ухааны Өвөл"	1970–1980-аад оны дунд	• Хүндрэл: Машинууд бодит ертөнцийн "нийтлэг ойлголт" (common sense)-ыг эзэмших, хүний хэл ярианы олон утгыг ойлгох зэрэгт бүдэрсэн. • Үр дүн: Хүлээлт биелээгүй тул санхүүжилт огцом танагдаж, "хиймэл оюун ухааны өвөл" эхэлсэн.
Мэргэжлийн системүүд	1980-аад он	• Гол анхаарал: Ерөнхий оюун ухаан биш, явцуу хүрээний асуудлыг шийдвэрлэх. • "Expert Systems": Мэргэжилтний мэдлэгийг "IF... THEN..." дүрэмд оруулж, эмнэлгийн оношилгоо зэрэг тодорхой салбарт амжилттай ашиглаж эхэлсэн.
Дахин суурь тавигдсан нь	1990–2000-аад он	• Бэлгэдлийн ялалт: 1997 онд IBM-ийн Deep Blue компьютер дэлхийн шатрын аваргыг ялсан. • Хиймэл оюун ухааны нэр хүнд унасан ч, судлаачид "мэдрэлийн сүлжээ" (neural networks)-ийн загварыг сайжруулж байв.
Орчин үеийн хувьсгал	2010 оноос өнөөг хүртэл	Гурван тэсрэлт: • Их Өгөгдөл (Big Data): Асар их хэмжээний өгөгдөл хуримтлагдсан. • Тооцоолох Хүчин Чадал: GPU-г ашигласнаар тооцооллыг хурдасгасан. • "Гүн Сургалт" (Deep Learning): Мэдрэлийн сүлжээний загварыг олон давхаргатай болгосноор, гайхалтай үр дүн үзүүлж эхэлсэн.

• Хиймэл оюун ухааны технологийн дэд бүтэц

Хиймэл оюуны чадварлаг системийг бий болгох, сургах, ажиллуулахын тулд хиймэл оюун ухааны технологийн дэд бүтэц буюу техник хангамжаас программ хангамж хүртэлх цогц технологийн бүтэц шаардлагатай. Энэхүү дэд бүтэц нь одоогийн байдлаар дараах гурван үндсэн давхаргаас бүрдэж байна.

Хүснэгт 8: Хиймэл оюун ухааны технологийн дэд бүтцийн ерөнхий түвшний энгийн тайлбар

Түвшин	Үүрэг	Энгийнээр тайлбарлав
Hardware Layer (Техник хангамж)	Тооцооллын суурь	Хиймэл оюун ухаанд хэрэгтэй хүнд тооцооллыг хийдэг машин, тоног төхөөрөмж. CPU нь удирддаг, GPU/TPU нь их ажлыг гүйцэтгэдэг.
Software Layer (Программ хангамж)	Загвар бүтээх хэрэгсэл	Техник хангамжийг ашиглан хиймэл оюуныг бүтээж, сургах программууд. Загварыг амархан хийх, сайжруулах боломж олгодог.
Operational Layer (Үйл ажиллагаа)	Бодит ашиглалт	Хиймэл оюуныг өдөр тутам тогтвортой, аюулгүй, тасралтгүй ажиллуулах удирдлага, хяналт.

¹⁰ <https://www.ibm.com/think/topics/history-of-artificial-intelligence>



2026-07-20

1. Hardware Layer (Техник хангамжийн түвшин)

БҮРТГЭВ-03

СХ
2026.07.09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Энэ нь хиймэл оюун ухааны загваруудыг боловсруулах, сургах болон бодит орчинд ажиллуулахад шаардлагатай өндөр хүчин чадалтай тооцооллын биет дэд бүтэц юм.

- **Тооцоолол (Compute):** Хиймэл оюун ухааны загваруудыг сургах болон ажиллуулахад матрицын болон векторын их хэмжээний тооцоолол шаардагддаг ба тус тооцоололд компьютерын процессорууд дараах байдлаар өөр өөр үүрэгтэйгээр хамтран ажилладаг байна.
 - ✓ **Төв процессор (CPU)** нь системийн ерөнхий удирдлагыг хариуцна. Тухайлбал, өгөгдөл бэлтгэх, тооцооллын дарааллыг зохион байгуулах, ямар загвар ямар нөөц ашиглахыг шийдэх зэрэг удирдлагын шинжтэй үйл ажиллагааг гүйцэтгэдэг.
 - ✓ **График процессор (GPU)** болон **Тензор процессор (TPU)** нь хиймэл оюуны загваруудын үндсэн тооцоолол болох олон давтагдах матрицын үйлдлийг нэгэн зэрэг гүйцэтгэхэд зориулагдсан байна. Ийм төрлийн тооцооллыг өндөр хурд, үр ашигтайгаар боловсруулах чадвартай тул гүн сургалтын загваруудын гүйцэтгэлийн үндэс болдог.

Иймд орчин үеийн хиймэл оюуны системүүд нь CPU болон GPU/TPU-г хослуулан ашигладаг хосолсон бүтэцтэй (hybrid architecture) бөгөөд энэ нь системийн удирдлага болон өндөр хүчин чадалтай тооцооллыг оновчтой хослуулах боломжийг бүрдүүлдэг байна.

- **Хадгалалт (Storage):** Хиймэл оюуны загваруудыг сургах явцад асар их хэмжээний өгөгдөл ашиглагддаг тул эдгээр өгөгдөлд хурдан, тасралтгүй хандах боломжтой хадгалалтын систем зайлшгүй шаардлагатай. Иймээс өндөр нэвтрүүлэх чадвартай, тархмал хадгалалтын шийдлүүд (жишээлбэл HDFS, Amazon S3 зэрэг) өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь сургалтын хурд, тогтвортой ажиллагаанд шүүд нөлөөлдөг байна.
- **Сүлжээ (Networking):** Тооцооллын төхөөрөмжүүд болон хадгалалтын системүүдийг бага хоцрогдолтой, өндөр хурдны сүлжээгээр холбох нь том хэмжээний хиймэл оюуны загваруудыг үр ашигтай сургах үндсэн нөхцөл болдог. Сүлжээний хурд, тогтвортой байдал нь өгөгдөл дамжуулах саатлыг бууруулж, нийт сургалтын хугацааг багасгахад чухал ач холбогдолтой.

2. Software Layer (Программ хангамжийн түвшин)

Программ хангамжийн түвшин нь дээрх техник хангамжийн тооцооллын хүчин чадлыг ашиглан хиймэл оюуны загварыг зохион бүтээх, сургах, турших үйл ажиллагааг гүйцэтгэхэд зориулагдсан программ, хэрэгслүүдээс бүрдэнэ.

- Хиймэл оюуны framework болон сангууд: Хиймэл оюуны загвар бүтээх, сургах үйл явцыг хялбаршуулдаг үндсэн хэрэгслүүд (TensorFlow, PyTorch, Scikit-learn).
- MLOps, Orchestration хэрэгслүүд: Хиймэл оюуны загваруудыг хөгжүүлэх, хэрэглэгчдэд хүргэх үйл явцыг удирдах хэрэгслүүд
 - ✓ **Kubernetes:** Хиймэл оюунд суурилсан системийг олон сервер дээр зэрэг ажиллуулахад зориулагдсан удирдлагын хэрэгсэл юм. Хэрэглээ эсвэл ачаалал нэмэгдэх үед шаардлагатай тооцооллын нөөцийг автоматаар нэмэгдүүлж, системийг тасралтгүй, найдвартай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлдэг.
 - ✓ **MLflow:** Хиймэл оюуны загваруудыг хөгжүүлэх явцад гарч буй туршилт, үр дүн, хувилбаруудыг эмх цэгцтэйгээр бүртгэж, харьцуулах боломж олгодог хэрэгсэл юм. Ингэснээр хамгийн сайн гүйцэтгэлтэй загварыг сонгон бодит хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.



Хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал

2022 оны төгсгөл нь дэлхийн технологийн хөгжлийн түүхэнд чухал эргэлтийн цэг болж, энэхүү үеийг "Generative AI Era" (Бүтээгч хиймэл оюун ухааны эрин үе) хэмээн тодорхойлох болсон. Хиймэл оюун ухаантай холбоотой мэдээлэл, таамаглал, байр суурь олноор түгж, ихэнх нь бодит агуулга багатай noise (ач холбогдол багатай мэдээлэл) болон хувирч буй өнөө үед салбарыг бодитоор үнэлэхэд хүндрэл үүсгэж байна.

Ийм нөхцөлд энэхүү мэдээллийн эмх замбараагүй байдлыг цэгцэлж, өгөгдөлд суурилсан, бодит дүр зургийг харуулах зорилгоор Стэнфордын Их Сургуулийн Human-Centered Artificial Intelligence (HAI) институтээс жил бүр эрхлэн гаргадаг "AI Index 2025" тайлан нь таамаг төдий яриаг бодит үзүүлэлтээс ялган салгаж, хиймэл оюун ухааны хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлыг илүү тодорхой, бодитойгоор ойлгоход чухал эх сурвалж болдог.

"AI Index 2025" тайлан нь дараах үндсэн 6 сэдвийн хүрээнд хиймэл оюун ухааны хөгжлийг хамарсан дүн шинжилгээг багтаасан байна. Үүнд:

Хүснэгт 9: Стэнфордын Их Сургуулийн "AI Index 2025" тайлангийн хураангуй мэдээлэл


Дэд сэдэв	Хураангуй агуулга
Судалгаа, Хөгжүүлэлт (R&D)	■ Инновацийн хос хөдөлгөөр: ✓ Аж Үйлдвэр: 2024 онд гарсан онцлох хиймэл оюун ухааны моделуудын 90%-ийг аж үйлдвэр (корпорацийн лабораториуд) бүтээж, хөгжүүлэлтэд давамгайлж байна. Энэ нь тэргүүлэх зэргийн загваруудыг сургахад шаардлагатай асар их нөөц хувийн хэвшилд төвлөрснийг харуулна. ✓ Академи: Харин академик байгууллагууд сүүлийн гурван жилд хамгийн их ишлэл авсан шилдэг 100 хиймэл оюун ухааны нийтлэлд эзлэх хувийн жингээрээ хамгийн их, урт хугацааны суурь судалгааны гол эх үүсвэр хэвээр байна.
	■ Геополитикийн Өрсөлдөөн: ✓ Патентын тоо: Дэлхий даяар олгогдсон хиймэл оюун ухааны патентын дийлэнх нь БНХАУ (69.7%) болон АНУ (14.2%)-аас гаралтай байна. ✓ Судалгааны Нөлөөлөл: АНУ судалгааны нөлөөлөл болон моделийн хөгжүүлэлтээрээ манлайлсаар байна. 2024 оны хамгийн шилдэг 100 нийтлэлээс 40 нь АНУ-аас гаргасан нь БНХАУ-ын 15 моделтой харьцуулахад өндөр үзүүлэлт байна.
Чадамжийн Үнэлгээ (Technical Performance)	■ Чадамжийн Огцом Өсөлт: ✓ Кодчиллын асуудлыг шийдвэрлэх чадварыг шалгадаг SWE-bench¹¹ үнэлгээнд хиймэл оюун ухааны системүүд 2023 онд асуудлын дөнгөж 4.4%-ийг шийдэж байсан бол 2024 он гэхэд энэ үзүүлэлт 71.7% болж огцом өссөн байна. ✓ Хиймэл оюун ухааны системүүд MMLU¹² GSM8K¹³ зэрэг тогтсон жишиг үнэлгээнүүд дээр хүний түвшнээс давсан гүйцэтгэл үзүүлж байна. Харин FrontierMath¹⁴ зэрэгт шилдэг хиймэл оюун ухааны системүүд дунджаар дөнгөж 2%-ийг шийдэж байгаа нь цаашдын орон зайг харуулж байна.
Эдийн Засаг (Economy)	■ Хөрөнгө Оруулалтын Чиг Хадлага: ✓ Дэлхийн хиймэл оюун ухааны байгууллагын нийт хөрөнгө оруулалт 2024 онд дээд амжилт буюу \$252.3 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнд бүтээгч хиймэл оюун ухаан (Generative AI) дахь хөрөнгө оруулалт 44.5%-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

¹¹ GitHub-ийн бодит төслүүдийн issue/bug-ийг өгөөд, загвар нь кодын засвар (patch) үүсгэн unit test-үүдийг давуулах чадварыг шалгадаг.

¹² 57 төрлийн хичээл/сэдвийг хамарсан олон сонголттой асуултын багц. Математик, түүх, хууль, компьютерийн шинжлэх ухаан, анагаах ухаан гэх мэт өргөн хүрээний ерөнхий мэдлэг, дүгнэлт хийх чадварыг шалгана.

¹³ 1,319 ширхэг бага ангийн өгүүлбэртэй бодлогоор олон алхамт математик логик/тооцооллын боловсруулалтыг хэмждэг.


¹⁴ Epoch AI баг олон улсын мэргэжлийн математикчдын хамтран боловсруулсан, нийт хэдэн зуун (ойролцоогоор ~300 орчим) өмнө нь нийтлэгдээгүй, маш хэцүү бодлогоос бүрдэх тест.



2025-07-20

БҮРТГЭВ-03

✓ 2024 онд АНУ-ын хувийн хиймэл оюун ухааны хөрөнгө оруулалт \$109.1 тэрбум ам.долларт хүрсэн нь БНХАУ-ын \$9.3 тэрбум ам.доллараас бараг 12 дахин их байна.




Зураг: Хиймэл оюун ухааны д чиглэсэн хөрөнгө оруулалт, тэрбум ам.доллар


Хариуцлагатай хиймэл оюун (Responsible AI)	- Байгууллагын Нэвтрүүлэлт: ✓ Бизнесийнхээ дор хаяж нэг функцэд хиймэл оюун ухаан ашиглаж буй байгууллагуудын хувь 2023 онд 55% байсан бол 2024 онд 78% болж өссөн. ✓ Хөдөлмөрийн Зах Зээлийн Нөлөө: ✓ Судалгаагаар хиймэл оюун ухаан нь бүтээмжийг нэмэгдүүлж, ялангуяа бага болон өндөр ур чадвартай ажилчдын хоорондох гүйцэтгэлийн зөрүүг багасгаж байна. ✓ Ажилчдын дийлэнх (60%) нь хиймэл оюун ухаан ажлаа хийх арга барилыг өөрчилнө гэж хүлээж байгаа ч, зөвхөн 36% нь ажлын байраа шууд алдана гэж үзэж байна.
	- Засаглалын Сорилт: ✓ Байгууллагууд хиймэл оюун ухааны аюулгүй, найдвартай байдлын эрсдэлийг хүлээн зөвшөөрч байгаа ч тэдгээрийг бууруулах хүчин чармайлт нь хоцрогдолтой байна. - Өгөгдлийн Орон Зайн Хумигдал: ✓ Вэбсайтууд өөрсдийн өгөгдлийг хиймэл оюун ухааны сургалтад ашиглахыг идэвхтэй хязгаарлаж байгаа нь хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн ирээдүйд сорилт үүсгэж болзошгүй.
	- Шинжлэх Ухаан: ✓ 2024 онд биологийн шинжлэх ухааны салбарт хийгдсэн уурагт суурилсан, хиймэл оюун ухаан ашигласан (AI-driven) судалгаанд уургийн функц таамаглах (8.4%) сэдэв хамгийн ихээр судлагдсан байна. - Нобелийн Шагнал: ✓ 2024 онд AlphaFold-ийг ашиглан уургийн нугаралтыг тайлбарласан ажилд Химийн Нобелийн шагнал, нейрон сүлжээний суурь шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийнхээ төлөө Физикийн Нобелийн шагнал олгосон нь хиймэл оюун ухааны шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмрийг тодотгож байна. - Эрүүл Мэнд: ✓ Эмнэлгүүд эрүүл мэндийн бүртгэл системдээ (EHR) хиймэл оюун ухааныг нэгтгэх нь захиргааны ажлыг хөнгөвчлөх, клиникийн шийдвэр гаргалтыг сайжруулах зэргээр тусламж үйлчилгээний ачааллыг бууруулах боломжтойг онцолсон.
Бодлого ба Засаглалын Хүрээ (Policy)	- Хууль Тогтоомжийн Өсөлт: ✓ Хиймэл оюун ухаантай холбоотой хууль тогтоох үйл ажиллагаанд хиймэл оюун ухааны талаар дурдсан тохиолдол нийт 75 улс оронд 2024 онд 21.3%-аар өссөн байна. - Дэлхийн Хамтын Ажиллагаа: ✓ Аюулгүй Байдлын Зохицуулалт: АНУ, Их Британи, Япон, Канад, Европын холбоо зэрэг гол улс орнуудад хиймэл оюун ухааны аюулгүй байдлын хүрээлэнгүүд байгуулагдаж, зохицуулалтаа албан ёсны болгож байна. ✓ Стратегийн Хөрөнгө Оруулалт: Засгийн газрууд дотоодын хиймэл оюун ухааны экосистемийг бий болгохын тулд их хэмжээний хөрөнгө зарцуулж байна (жишээлбэл, БНХАУ-ын хагас дамжуулагчийн \$47.5 тэрбум долларын сан, Саудын Арабын \$100 тэрбум долларын "Project Transcendence" санаачилга).

Хиймэл оюуны ирээдүйн чиг хандлага

Одоогийн байдлаар хиймэл оюуны технологи нь материал, эрүүл мэндийн шинжлэх ухаан, аж үйлдвэр зэрэг олон салбарт шинэ нээлтүүдийг нээж, хүн төрөлхтний амьдралын чанар, улс орны эдийн засагт чухал байр суурь эзлэх боломжтой гэж шинжээчид үзэж байна. Тиймээс хиймэл оюун ухааны талбар дахь дэлхийн өрсөлдөөн нь улс орнуудын хувьд үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч болоод байна. Улмаар, 2025 оны 7-р сард АНУ дэлхийн хиймэл оюун ухааны өрсөлдөөний талбарт өөрсдийн баримтлах бодлогын баримт бичиг болох "America's AI action plan" нэртэй төлөвлөгөөг баталсан билээ. Энэхүү төлөвлөгөө нь гурван үндсэн бөгөөд харилцан уялдаатай хэрэгжих 3 тулгуур дээр суурилсан байна. Үүнд:



2023.07.26
БҮРТГЭВ-03



Тулгуур I: Хиймэл Оюун Ухааны Инновацыг Хурдасгах

Энэ нь хувийн хэвшлээр түүхээлсэн инновацыг дэмжих, засгийн газрын хүнд суртлыг арилгах зорилготой.

- ✓ Хувийн Хэвшлийн Хөгжлийг Дэмжих
- ✓ Өргөн Хүрээний Нэвтрүүлэлт
- ✓ Дараагийн Үеийн Үйлдвэрлэл

Тулгуур II: Дэд Бүтцийг Бүтээн Байгуулах

Энэ хэсэг нь хиймэл оюун ухааны хөгжилд шаардлагатай тооцоолох болон эрчим хүчний суурийг бэхжүүлэхэд чиглэсэн.

- ✓ Дата Төвүүдийн Бүтээн Байгуулалт
- ✓ Эрчим Хүчний Бодлого: Хиймэл оюун ухааны дата төвүүдийн өсөн нэмэгдэж буй эрэлтээс үүдсэн эрчим хүчний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор одоогийн сүлжээг тогтворжуулах, одоо байгаа нөөцийг оновчлох, цөмийн болон байгалийн хий зэрэг эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглах замаар сүлжээг өргөжүүлэх.
- ✓ Хагас Дамжуулагч: Хиймэл оюун ухааны суурь технологи болох дэвшилтэт хагас дамжуулагчийн гадаадын нийлүүлэлтийн хамаарлыг бууруулах.

Тулгуур III: Хиймэл оюун ухааны хүрээнд олон улсын дипломат харилцаа ба аюулгүй байдлыг бий болгох

Энэ нь АНУ-ын хиймэл оюун ухааны технологийн хүрээнд улс орнуудтай холбоо үүсгэх, бусад улс орнуудад хүрэх боломжийг хязгаарлах зорилготой.

- ✓ Хиймэл Оюун Ухааны Хүрээнд Холбоотон Тогтоох
- ✓ Экспортын Хяналтыг Бэхжүүлэх

Ирээдүйн орлогын өсөлт

Суурь их хэлний загварууд (Large Language Models буюу LLMs)-ыг сургах үйл явц нь бүтээгч хиймэл оюун ухааны орлогын өсөлтийн гол хөдөлгөгч хүчин хэвээр байна. Үүний зэрэгцээ GitHub Copilot-ын хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, хэрэглэгчийн хайлтад чиглэсэн Perplexity, промптот суурилсан видео үүсгэгч Sora зэрэг шинэ аппликейшнуудийн эрэлт огцом өсөж буй нь зорилтот зах зээлийн хэмжээг цаашид тэлэх бодит хандлагыг харуулж байна. Ингэснээр Generative AI нь зөвхөн суурь загварын сургалтаас хальж, бодит хэрэглээний олон талт шийдлүүдээр дамжин тогтвортой, өргөжих боломжтой орлогын экосистем бүрэлдэх төлөв ажиглагдаж байна.

Зураг 18: Бүтээгч хиймэл оюун ухаан (Generative AI)-ны зах зээлийн орлогын өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Bloomberg Consensus



2026-07-20

БҮРТГЭВЭС

СЗХ

2026-07-20

өдөр

УХААНЫ ЗЭХ

Блүүмбэргээс зах зээлийн хэмжээг тооцоолсон загварын дагуу, бүтээгч хиймэл оюун ухааны зах зээл нь техник хангамж, программ хангамж, үйлчилгээ, сурталчилгаа, тоглоомын сегментүүдийн борлуулалтыг нэмэгдүүлснээр 2032 он гэхэд 1.8 их наяд ам.долларын зах зээл болж, жилийн дундаж нийлмэл өсөлт (CAGR) нь ойролцоогоор 30% байхаар таамаглаж байна. Энэ хувьсгалт технологи бизнесүүдийн үйл ажиллагаа явуулах арга барил, бүтээгдэхүүн ба үйлчилгээг сайжруулах, хэлбэрийг өөрчилж буй тул, бүтээгч хиймэл оюун ухаанд ногдох мэдээллийн технологийн нийт зардлын эзлэх хувь 2%-аас доош түвшнээс 14%–16%-д хүрч тэлэхээр байна.

Дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчдийн орлогын өсөлт 13%-50% хүртэлх хувиар өснө гэж шинжээчид таамаглаж байна. Хамгийн өндөр өсөлтийг суурь LLM загварын патент эзэмшигчдийн лицензийн орлого үзүүлэхээр байгаа бол үүний дараагаар сүлжээ болон дата төвийн орлогын өсөлт байна.

Хүснэгт 10: Хиймэл оюун ухааны технологийн дэд бүтцэд оролцогчдын орлогын өсөлтийн таамаглал

Орлогын таамаглал	2023	2024	2028E	2032E	2024–2032E CAGR
Дэд бүтэц	75,519	150,179	325,585	579,526	18%
Дата төв	56,642	119,325	190,373	317,419	13%
Хиймэл оюун ухааны хадгалалт	10,893	14,916	34,267	59,055	19%
Загвар сургах тооцооллын хүчин чадал (Үүлэн орчин дахь ажлын ачаалал)	3,050	4,972	22,845	44,291	31%
Сүлжээ	3,268	5,966	19,037	36,909	26%
LLM Лицензийн орлого	1,667	5,000	59,063	121,852	49%

Эх сурвалж: Bloomberg Consensus

2.2.4. ЗЭС, ТҮҮНД СУУРИЛСАН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ¹⁵


Зэсийн зах зээлийн ерөнхий төлөв

2025 оны байдлаар 28 сая тонн байгаа дэлхийн зэсийн эрэлт 2040 он гэхэд 42 сая тоннд хүрч, 50%-аар өсөх төлөвтэй байна. Нөгөөтгээгүүр, нийлүүлэлт талаас хэрэв зэсийн олборлолт мэдэгдэхүйц нэмэгдэхгүй бол 2040 он гэхэд 10 сая тоннын хомсдол үүсэх бөгөөд энэ нь нийт эрэлтийн 25%-тай тэнцэхүйц хэмжээ юм.

Зураг 19: Дэлхийн зэсийн эрэлтийн салбарын задаргаа, 2025-2040 он



¹⁵ Эх сурвалж: S&P Global Energy & Market Intelligence, "Copper in the Age of AI, Challenges of Electrification" January 2026




2026-07-20

Зураг 20: Дэлхийн зэсийн эрэлт болон нийлүүлэлт, 2025-2040 он

БҮРТГЭВ-03

СХ
2026.07.09
БҮРТГЭВ
№ 01



Зэсийн эрэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс болон нийлүүлэлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийн талаар шинжээчдийн дүгнэлттэй холбоотой мэдээллийг дараах хэсгээс авна уу.

Хүснэгт 11: Зэсийн эрэлт болон нийлүүлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс

Зэсийн эрэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс


Эдийн засгийн суурь эрэлт	Зэсийн хэрэглээний гол цөм нь дараах үндсэн эдийн засгийн эрэлт хэвээр байна гэж шинжээчид үзэж байна.
	✓ Барилга: Цахилгаан сантехник болон утас, кабель. ✓ Машин механизм: Мотор, генератор болон үйлдвэрлэлийн цахилгаан утас. ✓ Хөргүүр: Дулаан дамжуулалтыг оновчтой болгох зориулалттай дулаан солилцуур болон ороомог. ✓ Цахилгаан хэрэгсэл: Гэр ахуйн хэрэгслүүд (хөргөгч, угаалгын машин, зурагт болон гэрэлтүүлэг) дэх цахилгаан утас, холбогч хэрэгслүүд. ✓ Тээвэр: Төмөр зам, нисэх онгоц болон дотоод шаталтат хөдөлгүүртэй уламжлалт тээврийн хэрэгслүүд. ✓ Чулуужсан түлшний эрчим хүч үйлдвэрлэл: Хоолой, хөргөлтийн систем, генераторын ороомог болон цахилгаан кабель.
Эрчим хүчний шилжилт	Сэргээгдэх эрчим хүчний систем (нар, салхи) нь уламжлалт цахилгаан станцаас хавьгүй их зэс шаарддаг бол цахилгаан автомашин (EV) нь ердийн машинаас 2.9 дахин их зэс хэрэглэдэг байна. Түүнчлэн, 2040 он хүртэл хийгдэх төлөвлөгөө бүхий 7.5 их наяд ам.долларын эрчим хүчний сүлжээний шинэчлэл нь зэсийн эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.
Хиймэл оюун ухаан (AI) ба Дата төвүүд	АНУ-ын цахилгаан эрчим хүчний хэрэглээнд дата төвүүдийн эзлэх хувь 2030 он гэхэд 5%-аас 14% болж өснө гэж шинжээчид таамаглаж байна. Зэс нь дулаан дамжуулалт болон хөргөлтийн системд ашиглагддаг тул AI кластеруудын хувьд чухал түүхий эд юм. Нэг мегаватт (MW) хүчин чадалд ногдох зэсийн хэрэглээ 21-47 тонн байдаг нь AI кластеруудад зэсийг зайлшгүй шаардлагатай түүхий эд болгож байна.

Зураг: Хиймэл оюуны технологитой холбоотой зэсийн эрэлтийн чиг хандлага, 2025-2040 он



2026-07-20
БҮРТГЭВ-03

СЗХ
2026.07.20 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Батлан хамгаалах салбар Дэлхийн геополитикийн хурцадмал байдал зэсийг үндэсний аюулгүй байдлын хувьд чухал түүхий эд болгож байна. Дрон, пуужин, холбооны систем зэрэг цэргийн техникийн цахилгаанжуулалт нь зэсийн хэрэглээг 2040 он гэхэд 3 дахин нэмэгдүүлэх төлөвтэй байна гэж шинжээчид үзэж байна.

Зэсийн нийлүүлэлтийг хязгаарлаж буй хүчин зүйлс

Хүдрийн агуулга буурах	Өмнөд Америк дахь гол ордуудын хүдрийн агуулга нь 2000 оноос хойш 44%-аар (1.3%-аас 0.7% хүртэл) буурсан нь ижил хэмжээний зэс гаргаж авах зардал болон эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх нөлөө үзүүлж байна.
Урт хугацааны хүлээлт	Шинэ орд нээгдсэнээс олборлолт эхлэх хүртэл дунджаар 17 жил зарцуулдаг байна. Зөвшөөрөл олгох, байгаль орчны үнэлгээ, шүүхийн маргаан зэрэг нь эрэлтийн өөрчлөлтөд нийлүүлэлтийн зүгээс шуурхай хариу үйлдэл үзүүлэхэд саад болж байна.
Улс төрийн эрсдэл	Уул уурхайн төслүүд "Хуучирсан тохиролцоо" (Obsolescing Bargain) хэмээх үзэгдэлд өртөмтгий. Хөрөнгө оруулалт хийгдсэний дараа хүлээн авагч улсууд татвар, роялтиг нэмэх замаар гэрээгээ эргэж харах тохиолдол их байна (Жишээ нь: Панам дахь Кобрэ уурхай хаагдсан явдал).
Дахин боловсруулалтын хязгаар	Дахин боловсруулалт нэмэгдэж байгаа боловч энэ нь 2040 он гэхэд нийт нийлүүлэлтийн зөвхөн гуравны нэгийг бүрдүүлэх боломжтой гэж шинжээчид үзэж байна.

Эрэлт нь өсөж буй зэсийн нийлүүлэлтэд дээрх асуудлууд бодитоор нөлөөлж байгаа нь зэсийн үнэ өсөх суурь нөхцөл болоод байна. Түүнчлэн, дэлхийн улс орнуудын геополитикийн эрсдэл нь зэсийн нийлүүлэлтийг улам бүр бууруулах эрсдэлтэй байна. Тухайлбал, БНХАУ нь зэс боловсруулах хүчин чадлын 40-50%, хүдрийн импортын 66%-ийг хянаж байгаа ба АНУ 2025 онд зэсийг албан ёсоор улсын нэн чухал ашигт малтмалын нэгээр зарласан билээ. Улмаар, дээрх эрэлт болон нийлүүлэлтийн хүчин зүйлсээс үүдэн зэс, түүнийг олборлогч компаниудад суурилсан хөрөнгө оруулалт нь ирээдүйд чухал ач холбогдолтой байна.

2.2.5. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ¹⁶

Ойрхи Дорнодын дайнаас үүдэн 2026 он дэлхийн эрчим хүчний түүхэнд нийлүүлэлтийн хамгийн том тасалдал нүүрлэсэн жил болж байна. Дэлхийн газрын тосны тээврийн хамгийн чухал ложистикийн цэг болох Ормузын хоолой хэсэгчлэн хаагдсанаар өдөрт 20 сая баррель газрын тос, нефтийн бүтээгдэхүүний урсгал боогдож, зах зээлд үнийн огцом савлагаа үүсгээд байна. Энэхүү хямрал нь улс орнуудыг зөвхөн уламжлалт түлш бус, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч болон чухал ашигт малтмалын аюулгүй байдалд онцгой анхаарах шаардлагатайг сануулсан үйл явдал боллоо гэж шинжээчид үзэж байна.

¹⁶ Эх сурвалж: International Energy Agency, "World Energy Outlook Special Report".

2026-07-20

Хүснэгт 12: Эрчим хүчний салбарын дэд ангилал ба тэдгээрийн төлөв байдал

БҮРТГЭВ-03

Дэд салбарын ангилал

Гол бүрэлдэхүүн хэсгүүд

2026 оны төлөв байдал


Уламжлалт түлш (Fossil Fuels)	Газрын Байгалийн Нүүрс тос, хий, Нүүрс	Дэлхийн нийт хэрэглээний 80 орчим хувийг газрын тос хангаж байгаа хэдий ч Ойрхи Дорнодын мөргөлдөөнөөс үүдэн нийлүүлэлт буурах өндөр эрсдэлтэй байна. Улмаар, шинжээчдийн үзэж буйгаар урт хугацаанд уламжлалт түлшний эрэлт нь 2030 оны орчимд 102 сая баррель/өдөр хүрч оргилдоо хүрэх эсвэл 2050 он хүртэл өсөлтөө үргэлжлүүлэх төлөвтэй байна.
Сэргээгдэх эрчим хүч (Renewables)	Нар, Салхи, Ус, Био-эрчим хүч, Геотермаль	АНУ болон Катар зэрэг улс орнууд 2030 он гэхэд байгалийн хийн экспортын хүчин чадлыг 50%-аар нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Гэсэн хэдий ч 2035 оноос эрэлт тогтворжих ерөнхий хандлага ажиглагдаж байна. Түүнчлэн, 2030 он гэхэд дэлхийн нүүрсний хэрэглээ оргилдоо хүрч, дараа нь эрчимтэй буурах ба энэ нь голчлон Хятадын эрчим хүчний шилжилтээс хамаарна гэж шинжээчид таамаглаж байна.
Цөмийн эрчим хүч (Nuclear Energy)	Уламжлалт станцууд, Жижиг модуль реакторууд (SMR)	Нар болон салхины эрчим хүч дэлхийн цахилгаан үйлдвэрлэлийн өсөлтийн дийлэнх хэсгийг хангаж байна. 2035 он гэхэд сэргээгдэх эрчим хүч дэлхийн нийт цахилгаан үйлдвэрлэлийн талаас илүү хувийг хангана гэж шинжээчид тооцоолж байна.
Цахилгаан ба Дэд бүтэц (Electricity & Grids)	Цахилгаан дамжуулах сүлжээ, Батарей хадгалалт	Эрчим хүчний аюулгүй байдал болон дата төвүүдийн хэрэгцээг хангах зорилгоор цөмийн эрчим хүчний шийдлүүд 40 гаруй улс оронд дахин сэргэж, тэдгээрт чиглэсэн хөрөнгө оруулалт мөн нэмэгдэж байна. Цөмийн хүчин чадал 2035 он гэхэд дор хаяж одоогийн түвшнээс гуравны нэгээр нэмэгдэх хүлээлттэй байна.
Бага нүүрс хүчлийн хийн ялгаралтай түлш (Low-emissions fuels)	Устөрөгч (Hydrogen), Аммиак, Био-метан	Дата төв, хиймэл оюун ухаан (AI) болон цахилгаан автомашины өсөлтөөс үүдэн дэд бүтцийн хөрөнгө оруулалт огцом нэмэгдэх хүлээлттэй байна.
Нэн чухал ашигт малтмал (Critical Minerals)	Зэс, Лити, Никель, Кобальт, Ховор элементүүд	Нүүрс хүчлийн хий ихээр ялгаруулдаг хүнд үйлдвэр, агаарын тээвэр, усан тээврээс ялгарч буй нүүрс хүчлийн хийг бууруулах гол шийдэл нь эдгээр бага нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг түлшний шийдлүүд гэж шинжээчид үзэж байна.
		Эдгээр нэн чухал ашигт малтмал нь эрчим хүчний аюулгүй байдлын шинэ хэмжүүр болж байгаа ба тэдгээрийн нийлүүлэлт хэт төвлөрсөн байгаа нь тус салбарын гол асуудал болж байна.

Цахилгаан эрчим хүчний эрэлт нь нийт эрчим хүчний хэрэглээний өсөлтөөс хоёр дахин илүү хурдацтай нэмэгдэж байгаа нь эрчим хүчний салбар "Цахилгаан эрчим хүчний эрин үе" (Age of Electricity)-д шилжиж байгааг илэрхийлж байна. Дэлхийн эрчим хүчний хэрэглээний хэв маягт бүтцийн өөрчлөлт авчирч буй цахилгаан эрчим хүчний эрэлтийн гол хүчин зүйлсийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 13: Цахилгаан эрчим хүчний эрэлтийн гол хүчин зүйлс

Эрчим хүчний эрэлтэд нөлөөлж буй гол хүчин зүйлс

Агааржуулалт ба хөргөлтийн систем	✓	Хүн амын орлого нэмэгдэхийн хэрээр агааржуулагчийн хэрэглээ өсөж, дэлхийн дулааралтай холбоотойгоор ачаалал дээд цэгтээ хүрч байна. 2035 он гэхэд хөргөлтийн системүүд дэлхийн эрчим хүчний оргил ачааллыг 330 ГВт-аар нэмэгдүүлэх төлөвтэй байгаа бөгөөд агаарын хэмийн өсөлт үүн дээр нэмж 170 ГВт-ын ачаалал үүсгэх төлөвтэй байна. Энэ нь ялангуяа Энэтхэг, Ойрхи Дорнод зэрэг хөгжиж буй орнуудын хувьд эрүүл мэндийн зайлшгүй хэрэгцээ болж байна.
Дата төвүүд ба Хиймэл оюун ухаан	✓	Дижитал дэд бүтэц болон хиймэл оюун ухааны огцом тэлэлт нь эрчим хүчний хэрэглээний шинэ тэсрэлтийг бий болгож байна. 2035 он гэхэд дэлхийн дата төвүүдийн цахилгаан зарцуулалт 3 дахин өсөх төлөвтэй. Жишээлбэл, АНУ-д 2030 он хүртэлх нийт эрчим хүчний эрэлтийн өсөлтийн тал орчим хувийг зөвхөн дата төвүүд дангаараа бүрдүүлнэ гэж шинжээчид тооцожээ.



2026-07-20

Цахилгаан

тээвэр (EVs)

БҮТЭГ-03

СЗХ

2026.07.09 өдөр

БҮТЭГ-03

2035 он гэхэд дэлхийн хэмжээнд борлуулагдаж буй шинэ автомашинуудын 50-аас дээш хувийг цахилгаан автомашин эзлэхээр байна. Энэхүү шилжилт нь газрын тосны хэрэглээг өдөрт 10 сая баррелиар бууруулах боловч дэд бүтцэд хөрөнгө оруулалт нэмж байна.

Хиймэл оюун ухаан нь дэлхийн эдийн засагт цахилгаан болон уурын хөдөлгүүртэй дүйцэхүйц хэмжээний өөрчлөлт авчирч байна. Сүүлийн хоёр жилд AI-тай холбоотой компаниудын зах зээлийн үнэлгээ 12 их наяд ам.доллараар өссөн нь энэхүү технологийн ирээдүйг зах зээл хэдийнээ хүлээн зөвшөөрсний илрэл юм. Гэвч AI-ийн бодит түлш нь тооцоолох хүчин чадал, түүнийг ажиллуулах тасралтгүй эрчим хүч юм. Иймд эрчим хүчний салбар нь зөвхөн уламжлалт хэрэглээний салбар бус, харин өндөр технологийн өсөлтийг хангах стратегийн чухал хөрөнгө болон хувирч байна.

Хиймэл оюун ухааны модел сургах болон ажиллуулах бүх процесс дата төвүүдэд байрлах өндөр хүчин чадалтай серверүүд дээр явагддаг тул салбарын хөгжил хурдсахын хэрээр дата төвүүдийн эрэлт ихсэх холбоо хамааралтай байна.

Зураг 21: Дата төвүүдийн цахилгааны хэрэглээтэй холбоотой мэдээлэл


Орчин үеийн hyperscalers болон томоохон дата төвүүд нь хэдэн зуун мянгаас сая өрхийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний цахилгаан зарцуулж байна.

Дата төвүүдийн цахилгаан хэрэглээний ихэнхийг серверүүд эзэлдэг бөгөөд hyperscalers нарын дата төвүүд хамгийн өндөр үр ашигтай ажиллан, цахилгааны дийлэнх хэсгийг IT тоног төхөөрөмжид (ялангуяа серверүүдэд) зарцуулдгийг харуулж байна.


Зураг: Дата төвүүдийн эрчим хүчний хэрэглээг өрхийн хэрэглээтэй харьцуулсан дүн



Зураг: Дата төвүүдийн цахилгааны хэрэглээний задаргаа



Зураг: Дата төвийн эрчим хүчний хэрэглээний задаргаа



Хиймэл оюун ухаан нь зөвхөн эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхээс гадна тухайн салбарын үйл ажиллагааг илүү үр ашигтай болгож байна. Доорх хүснэгтэд хиймэл оюун ухааныг хэрэглэснээр эрчим хүчний төрөл бүрты ямар дэвшил ирэх боломжтойг харууллаа.



2026-07-20

Хүснэгт 14: Эрчим хүчний оновчлолд ашиглагдах хиймэл оюун ухааны хэрэглээ болон тэдгээрийн салбар бүр дэх хэрэглэх боломж

БҮРТГЭВ-03

СЭХ

2026.07.20 өдөр

ЭВ

№ 01

Нөөцийн менежмент	●	●	●	n/a	●	n/a	n/a
Зураг төсөл ба хөгжүүлэлт	●	●	●	●	●	●	●
Үйл ажиллагааны оновчлол	●	●	●	●	●	●	●
Автоматжуулалт ба автономи	●	●	●	●	●	●	n/a

n.a. – хамаарахгүй; ● - хязгаарлагдмал хамаарал; ● - дунд зэргийн хамаарал; ● - өндөр хамаарал

Хиймэл оюун ухаан ба эрчим хүчний салбар нь улам бүр бие биенээсээ хамааралтай болж байна. Нэг талаас, хиймэл оюун ухааны салбарын асар их эрчим хүчний хэрэглээ нь сорилт мэт боловч нөгөө талаас, энэ нь эрчим хүчний системийг ухаалаг, үр ашигтай, уян хатан болгох гол түлхүүр гэж шинжээчид үзэж байна.

2.2.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.2.6.1. Олон улсын хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийн төлөв байдал


Хөрөнгө оруулалтын сангийн тухай ойлголт

Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд хөрөнгө төвлөрүүлж, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэн, нэгж эрхийн үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулагч нарт өгөөж бий болгох үндсэн зорилготой билээ.

Түүхэн үүсэл: Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгийн зах зээлийн чухал оролцогчдын нэг бөгөөд энэхүү ойлголт анх олон улсын хэмжээнд 1774 онд бий болсон гэж үздэг. 1774 онд анх Голланд улсын худалдаачин хөрөнгөө нэгтгэн хөрөнгө оруулалт хийх санааг бий болгосон бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын хэлбэр нь XIX зууны үед Европт тархаж улмаар Англи улсын хөрөнгө оруулагчид АНУ-д аж үйлдвэрийн жилүүдэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх болсон байна. Ийнхүү АНУ-д хөрөнгө оруулалтын итгэмжит байгууллагын бүтцийг бий болгон үйл ажиллагааг явуулж эхэлсэн ба 1893 онд анхны “Хувийн өмчит итгэмжит сан” үүсгэн байгуулсан нь анхны хаалттай сан байжээ. Үүнээс хойш XX зуунд хөрөнгө оруулалтын сангийн, тэр дундаа хамтын сангийн эхлэл тавигдсан гэж үздэг. 1924 оны 3-р сарын 21-ний өдөр Массачусетсийн хөрөнгө оруулагчийн сан болох “Trust Boston” санг байгуулсан нь анхны нээлттэй хамтын сан юм.

Хөрөнгө оруулалтын сангийн онцлог: Хөрөнгө оруулалтын сан нь илүү өргөн хүрээний хөрөнгө оруулалтын боломжийг олгох, мэргэжлийн хөрөнгө оруулалтын менежерийн туршлагыг ашиглахын зэрэгцээ бие дааж хөрөнгө оруулахтай харьцуулахад хямд өртгөөр хөрөнгө оруулах боломжийг нэгж эрх эзэмшигч буюу сангийн гишүүдэд олгодгоороо онцлогтой байдаг.

Олон улсын практикт хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хэлбэрээр нь хамтын, хувийн, биржээр арилжаалагддаг сан /ETF/, тэтгэврийн гэсэн үндсэн 4 төрөлд хуваадаг бөгөөд тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын зорилго, чиглэл, эрсдэлийн түвшин, хэрэгжүүлж буй стратегиас нь хамааран олон төрөлд ангилж болдог. Тухайлбал, хувьцааны сан, тогтмол орлогын сан (бонд, ХБҮЦ зэрэг тогтмол орлого бий болгодог хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулдаг сан), холимог багцын сан, мөнгөний захын сан зэрэг нь хамтын сангийн түгээмэл төрөл бол хедж сан, хаалттай компанийн хувьцаанд хөрөнгө оруулдаг сан (private equity), гарааны бизнесийн сан (venture capital) зэрэг нь мэргэжлийн хүрээнийхэнд зориулсан хувийн хөрөнгө оруулалтын сан байх нь түгээмэл байдаг.



2025-07-20

БҮРТГЭВ

СХА
2025-07-08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хөрөнгө оруулалтын сангийн нийтлэг төрлүүд, өнөөгийн нөхцөл байдал


2024 оны байдлаар дэлхийн даяарх хөрөнгө оруулалтын сангийн удирдаж буй нийт хөрөнгө нь 135 их наяд ам.долларт хүрсэн ба хөрөнгө оруулалтын сангийн төрөл тус бүрээр удирдаж буй хөрөнгийн хэмжээ, өнөөгийн нөхцөл байдал дараах байдалтай байна (McKinsey, 2025 он).

Хамтын сан (Mutual Fund)

Хамтын сан гэж нэгж эрх нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэг хэлбэр бөгөөд хамтын сангийн танилцуулгад тодорхойлсон стратегийн дагуу хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийг багцалж, сонгосон хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулагчдад өгөөж хүртээдэг. Хөрөнгө оруулагчдын өгөөжийн хүлээлт, эрсдэлийн түвшинд нийцүүлэн тохируулсан өөр өөр төрлийн хамтын сангууд байдаг ба хамгийн түгээмэл нь хувьцааны сан юм.

Дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй хамтын сангийн тоо 2013 онд ойролцоогоор 97,939 байсан бол 2022 онд ойролцоогоор 137,892 болж нэмэгдсэн байна. Хамтын сангийн цэвэр хөрөнгийн хэмжээ 10 жилийн өмнө 27.4 их наяд ам.доллар байсан бол 2022 онд ойролцоогоор 46.3 их наяд ам.доллар болж өссөн байна. Үүнээс хөрөнгө удирдлагын хэмжээгээрээ тэргүүлэгч улс болох АНУ-ын хамтын нээлттэй сангийн нийт удирдаж буй хөрөнгө 2025 оны 12-р сарын байдлаар 22.8 их наяд ам доллар байгаа бол хамтын хаалттай сангийн хувьд 387 тэрбум ам.долларт хүрээд байна. (Bloomberg, 2025)

Зураг 22: Нийт үйл ажиллагаа явуулж буй хамтын сангийн тоо, удирдаж буй хөрөнгийн хэмжээ (AUM), их наяд ам.доллар



Эх сурвалж: Bloomberg

2024 оны байдлаар дэлхийн нийт хамтын сангуудын нийт хөрөнгийн 53% нь АНУ-д төвлөрсөн бөгөөд Европын орнууд 31%, Ази номхон далайн орнууд 11%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 23: Нийт үйл ажиллагаа явуулж буй хамтын сангуудын хөрөнгө оруулалтын хуваарилалт, бүс нутгаар



Эх сурвалж: The Investment Company Institute, 2025 он

Биржээр арилжаалагдаг сан /ETF/



2026-07-20

БҮРТГЭЛЭГ


2026-07-09

АДАС


1990-ээд оны эхэн үеэс санхүүгийн зах зээл дээр биржээр арилжаалагддаг сан (ETF)-ийн төрөл гарч ирсэн байна. Биржээр арилжаалагддаг сан нь бусад хөрөнгө оруулалтын сангаас ялгарах гол онцлог нь нэгж эрхээ зохицуулалттай этгээдийн эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгслээр солих замаар ХОС-ийн активаа бүрдүүлдэг, нэгж эрхээ хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалах боломжтой хөрөнгө оруулалтын сангийн нэг төрөл юм.

Сүүлийн 20 жилд ETF нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж, хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийн хамгийн хурдацтай өсөж буй хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр болсон байна. 2024 онд дэлхий даяарх ETF-үүдийн удирдаж буй нийт хөрөнгийн хэмжээ 14.8 их наяд ам.долларт хүрсэн ба энэ нь хоёр жилийн өмнөх хөрөнгийн хэмжээ болох 10 их наяд ам.долларын босгыг давсан үзүүлэлт боллоо. (Ernst & Young Global Limited, 2025).

Зураг 24: Дэлхий дээр үйл ажиллагаа явуулж буй ETF-ийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ, тэрбум ам.доллар




Зураг 25: АНУ-ын хамтын ХОС болон ETF-ийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ



Эх сурвалж: J.P.Morgan asset management, 2025 он

ETF-үүд бүтээгдэхүүн болон стратегийн хувьд улам бүр төрөлжин өргөжиж байна. Эхэндээ өргөн зах зээлийн индекс дагадаг энгийн пассив ETF зардал бага, ил тод байдгаараа давуу тал болж байсан бол сүүлийн жилүүдэд идэвхтэй удирдлагатай ETF, тодорхой сэдэвчилсэн индекс дагадаг ETF-үүд олноор байгуулагдаж байна. 2024 оны байдлаар АНУ-д идэвхтэй менежменттэй ETF-үүд нь нийт ETF хөрөнгийн 8%-ийг эзэлж байгаа ч тухайн төрлийн үйл ажиллагаа явуулж буй сангийн тоо ширхгийн хувьд талыг нь бүрдүүлж байна.

Зураг 26: АНУ дахь хамтын ХОС болон ETF-ийн тоо ширхэг, хувиар



ФЦЮЧЕР ТЕХНИК ЭЗЭМН
ХАМТЫН БИРЖЭЭР АРИЛЖААЛДДАГ
ХОС-ЫН АТВИЛ
УЛААНБААТАР ХОТ
725003 АТ/БНН
902606003

2026-07-20

БҮРТГЭВ

Эх сурвалж: J.P.Morgan asset management, 2025 он

2026.07.20 өдөр

БҮРТГЭВ

Энэ нь хөрөнгө оруулагчид идэвхтэйгээр удирддаг, зах зээлийн боломжийг ашиглахыг зорьсон ETF-үүдэд хөрөнгө оруулах сонирхол өндөр байгаагийн илрэл гэж үзэж болно. Түүнчлэн, сэдэвчилсэн ETF буюу тодорхой салбар, чиг хандлагад (технологи, эрчим хүч, дэд бүтэц гэх мэт) чиглэсэн сангуудад хөрөнгө оруулах урсгал дэлхий дахинд нэмэгдэж байна.

Сэдэвчилсэн сангуудаас сүүлийн үед хамгийн их хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж буй нь хиймэл оюун ухаан болон өндөр технологийн чиглэлийн ETF-үүд юм. Генератив хиймэл оюун ухааны технологийн дэвшил, түүний компанийн өгөөжид үзүүлэх нөлөө нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж, 2023 оноос хиймэл оюун ухаантай холбоотой ETF-үүдэд өндөр хэмжээний мөнгөний урсгал орж эхэлжээ. 2025 оны эхний хоёр сард гэхэд глобал сэдэвчилсэн ETF-үүд рүү чиглэсэн 2.4 тэрбум ам.долларын цэвэр мөнгөн урсгалын талаас илүү нь роботикс ба хиймэл оюун ухааны чиглэлийн ETF-үүдэд ногдсон нь энэхүү хандлагыг бататган харуулж байна. Өөрөөр хэлбэл, технологийн хувьсал, инновацийн өгөөжийг авах гэсэн хөрөнгө оруулагчид ETF хэлбэрээр эдгээр сэдэвт хөрөнгө оруулалт хийх нь түгээмэл болж, цаашид ч хиймэл оюун ухааны чиглэлээр улам олон шинэ сэдэвчилсэн сангууд байгуулагдах төлөвтэй байна (The ETF Impact Report 2024-2025, State street, 2025)

Хүснэгт 15: Эдийн засгийн сектор болон сэдэвчилсэн ETF рүү орсон, гарсан мөнгөн урсгал

Эдийн засгийн сектор, сая доллар	2020	2021	2022	2023	2024	2025
Мэдээллийн технологи (Information Technology)	27,024	22,487	19,454	38,519	40,769	72,959
Санхүү (Financial)	14,480	31,098	-13,990	-3,202	13,149	28,423
Аж үйлдвэрлэл (Industrials)	9,924	1,480	-3,908	1,362	8,890	24,623
Харилцаа холбоо (Communications)	8,476	6,560	503	4,458	-1,207	13,789
Материал, уул уурхай (Materials)	8,502	9,187	96	-1,102	997	12,253
Дэд бүтэц / Нийтийн үйлчилгээ (Utilities)	1,293	3,111	5,634	-1,199	2,497	9,114
Эрүүл мэнд (Health)	11,388	13,880	19,474	-2,849	-4,478	7,066
Өргөн хэрэглээ (Consumer Staples)	-1,523	-1,790	11,151	-3,979	173	1,822
Тансаг хэрэглээ (Consumer Discretionary)	5,691	6,648	-8,715	5,688	-2,007	955
Түлш, эрчим хүчний салбар (Energy)	19,025	20,491	3,274	-10,130	-12,057	-4,418
Сэдэвчилсэн (Thematic)	22,832	35,084	7,868	295	1,933	23,372

Эх сурвалж: Bloomberg


Хедж сан

Хедж сангууд нь зах зээлээс өндөр өгөөж хүртэхийн тулд хувьцаа, бондын хөрөнгө оруулалтаас бусад уламжлалт бус стратегийг түгээмэл ашигладаг хөрөнгө оруулалтын сангийн нэг төрөл юм. Уламжлалт бус стратеги нь өндөр эрсдэл бүхий үүсмэл санхүүгийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, уран зураг, таваарын гэх мэт зах зээлд хөрөнгө оруулах замаар үнэмлэхүй өгөөж хүртэхийг зорьдог стратеги юм.


1990-ээд онд дэлхий даяар хедж сангийн салбар эрчимтэй хөгжиж, дэлхийн хэмжээнд хедж сангуудын удирддаг цэвэр хөрөнгийн хэмжээ 2007 он хүртэл тогтвортой өссөн байна. 2008 оны санхүүгийн хямралын улмаас энэхүү төрлийн хөрөнгө оруулалтын сангийн удирдаж буй хөрөнгө буурсан ба 2013 оноос эхлэн эргэн сэргэсэн байна. 2024 оны байдлаар дэлхий дэх хедж сангийн хөрөнгийн үнэлгээ 5 их наяд ам.долларт хүрсэн бөгөөд хөрөнгийн дийлэнх хувийг АНУ дахь хедж

2026-07-20

сангийн менежерүүд удирдаж байна. Хедж сангуудын хөрөнгийн хэмжээ нь аргачлалуудаас шалтгаалж 4.7-5.5 их наяд ам долларын хооронд байна.



Зураг 27: Нийт үйл ажиллагаа явуулж буй хедж сангуудын удирдаж буй хөрөнгө (AUM), их наяд ам.доллар




Эх сурвалж: With Intelligence, 2025 он

Тэтгэврийн сан

Тэтгэврийн сан нь тухайн хөрөнгө оруулагчийг тэтгэвэрт гарах үед нь орлогын эх үүсвэрээр хангах зорилготой сан юм. Тэтгэврийн санг хувийн тэтгэврийн сан болон улсын тэтгэврийн сан гэж хувааж авч үздэг. Улсын тэтгэврийн сан гэдэг нь хуваарилалтын систем бүхий, иргэдийн амьжиргааны баталгаат түвшин алдагдах эрсдэлийг улсаас тэтгэвэр олгох замаар нөхөх зорилготой санг хэлнэ. Харин хувийн тэтгэврийн сан гэдэг нь хуримтлалын систем бүхий, тэтгэвэрт гарсны дараа улсын тэтгэврийн сангаас гадна нэмэлт тэтгэвэр авах бололцоог олгодог сан юм.

Сүүлийн 15 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд тэтгэврийн сангийн нийт хөрөнгийн хэмжээ тогтвортой өссөн байна. 2009 онд 30.6 их наяд ам.доллар байсан бол 2024 онд 70 их наяд ам.доллар болж жилд дунджаар 10%-аар өсжээ. 2024 оны байдлаар дэлхийн хамгийн том тэтгэврийн сан Норвегийн засгийн засгийн газрын тэтгэврийн сан байсан бөгөөд нийт хөрөнгө нь 1.77 их наяд ам.долларт хүрсэн байна.

Зураг 28: Дэлхий дээр үйл ажиллагаа явуулж буй тэтгэврийн сангийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ, их наяд ам.доллар



Эх сурвалж: Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (OECD), Global Pension Statistics, 2025 он

2024 оны байдлаар дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй бүх хөрөнгө оруулалтын сангийн үнэлгээ ойролцоогоор 163.7 их наяд ам.доллар бөгөөд нийт хөрөнгөд эзлэх хувийг хөрөнгө оруулалтын сангийн төрлөөр харвал тэтгэврийн сан болон хамтын сангийн хөрөнгө дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд нийт хөрөнгийн 45.1% /73.9 их наяд ам доллар/, 42.7%-ийг /7046 их наяд ам доллар/ тус тус бүрдүүлж байна.



46

2026-07-20

БҮРТГЭВ-03

Зураг 29: Нийт үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын сангийн бүрэлдэхүүн, ХОС-ийн хэлбэрээр, 2024 оны байдлаар

СЗХ
2026.07.09 өдөр
БҮРТГЭВ



Эх сурвалж: ХОМК-ийн тооцоолол

2.2.6.2. Монгол Улсын хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийн төлөв байдал

Хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын орчин


Монгол Улсад 2013 оны 10-р сарын 03-ны өдөр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдаж, дотоодын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна. Тус хуулиар хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллагаас зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Мөн хуульд нийцүүлэн Хороо, Хөрөнгийн бирж болон бусад эрх бүхий байгууллагаас хөрөнгө оруулалтын сантай холбоотой дагаж мөрдөх шаардлагатай дүрэм, журам, зааврыг баталж, хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах боломжтой болсон.

Ийнхүү хөрөнгө оруулалтын сангийн хууль эрх зүйн орчин хөгжиж эхэлснээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн зах зээлд шинээр нэвтрэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчид нэмэгдэх, нөгөөтээгүүр хөрөнгө оруулагчид эрсдэлийг оновчтойгоор тараан байршуулах, хөрөнгө оруулалтын зардлаа бууруулах, туршлагатай хөрөнгө оруулалтын зөвлөхийн цаг үеийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх ур чадвар, хөрөнгө оруулалтын техник ур чадварыг ашиглах зэрэг олон давуу талууд бий болж байна.

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны үндсэн ойлголтууд

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасны дагуу хөрөнгө оруулалтын сан гэж хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд хөрөнгө төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах санг хэлэх ба дараах онцлогтой байна. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байна.
- ✓ Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллаж, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой байна.
- ✓ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр үүсгэн байгуулах ажиллагааг гүйцэтгэнэ.
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн өдөр тутмын үйл ажиллагаа, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.



2026-07-20

БҮРТГЭВ

СХХ

2026-07-09 өдөр

№ 01

- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн хаяг нь хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хаяг байна.
- ✓ Хөрөнгө оруулалтын сан нь түүний нэгж эрх эзэмшигч хуулийн этгээдээс хараат бус байх ба Компанийн тухай хуульд заасан хараат, охин, толгой компани хоорондын эрх, үүрэг, хариуцлага хүлээхгүй.
- ✓ Хөрөнгө оруулалтын санд иргэн, хуулийн этгээд хөрөнгө оруулж болно.


Хүснэгт 16: Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр, төрлийн ангилал

Хэлбэр	Төрөл	Жишээ
	Нээлттэй сан – Нэгж эрхээ олон нийтэд байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр нэгж эрхээ нэмж гаргадаг ба нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг хөрөнгө оруулалтын сангийн төрөл юм. Нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь бирж дээр арилжаалагдахгүйгээр тусдаа арилжааны системээр дамжуулан тогтоосон арилжааны цагт худалдах, буцаан худалдан авах замаар нэгж эрх нь арилжаалагддаг.	✓ “Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын ХОС” ХХК ✓ “Мандал Хуримтлал хамтын ХОС” ХХК
	Хаалттай сан – Үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр нэгж эрх нэмж гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй хөрөнгө оруулалтын сан юм. Дээрх хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь бирж дээр бүртгэгдэж, олон нийтэд арилжаалагддаг онцлогтой.	✓ “Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС” ХХК ✓ “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК
	Биржээр арилжаалагддаг сан - Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэн хоёрдогч зах зээлд хувьцаа мэт арилжаалагддаг хамтын сангийн онцгой төрөл юм. ETF нь үндсэндээ нээлттэй сангийн нэг хэлбэр боловч бирж дээр тасралтгүй арилжаа нь явагддагаараа онцлогтой.	✓ “Инвескор Глобал Кью хамтын биржээр арилжаалагддаг ХОС” ХХК (INQ ETF)
	Хувийн хөрөнгө оруулалтын сан	Зөвхөн хаалттай хүрээнд буюу мэргэжлийн хөрөнгө оруулагч хэмээн тодорхойлохуйц хөрөнгө оруулагчдад санал болгон гэрээний үндсэн дээр хөрөнгө татан төвлөрүүлдэг хөрөнгө оруулалтын сан юм. Хамтын хөрөнгө оруулалтын сантай харьцуулахад хөрөнгө оруулах боломжит хэрэгслүүд нь олон.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хорооноос баталсан холбогдох журмын дагуу хөрөнгө оруулалтын сантай холбоотой үндсэн ойлголтуудыг дараах байдлаар тайлбарлав.

Хүснэгт 17: Хөрөнгө оруулалтын сангийн үндсэн ойлголт

Үндсэн ойлголт	Тайлбар
	Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг
	Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд баримтлах, хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргалтад мөрдөх үндсэн баримт бичгүүдийн нэг юм. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу тус баримт бичигт дараах агуулгыг тусгана. Үүнд: ✓ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо; ✓ Хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтын хэрэгслийн жагсаалт, хязгаарлалт, хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрд хөрөнгө оруулсантай холбогдон үүсч болох эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын арга, хэрэгслийн тухай; ✓ Хөрөнгө оруулалтын сангийн активын бүтцэд тавигдах шаардлага; ✓ Хөрөнгө оруулалтын сангийн орлогоос гишүүдэд орлого хуваарилах бодлого.



2026-07-20

БҮРТГЭВ-03



Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь дараах онцлог шинж чанартай байна. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөнөөс өмчлөх хувь хэмжээг гэрчлэх бөгөөд нэгж эрхийн өмчлөгчийн зүгээс хөрөнгө оруулалтын менежментийн компаниас хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг дүрэм болон хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд мэргэжлийн түвшинд зохих ёсоор удирдахыг шаардах, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд нэгж эрх тус бүрээр саналын нэг эрхтэйгээр оролцох, хөрөнгө оруулалтын санг татан буулгах үед өөрт ногдох хөрөнгийн хүлээн авах эрхийг гэрчилнэ.
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох боловч хөрөнгө оруулалтын сангийн тодорхой хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх тус бүр адил тэгш хэмжээний хөрөнгийг гэрчилнэ.



Хөрөнгө оруулалтын сангийн орлого

- ✓ Хөрөнгө оруулалтын сан зөвхөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилготой байх ба орлого нь үйл ажиллагааны хүрээнд бий болгосон орлогоос бүрдэнэ.
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 12-р зүйлийн 12.1-т заасны дагуу хөрөнгө оруулалтын сан нь үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа хөрөнгө оруулалтын сангийн орлогоор ногдол ашиг тараахгүй байж болно.



Хөрөнгө оруулалтын сангийн зардал

- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн зардал гэж хөрөнгө оруулалтын санд бусдаас үзүүлэх хөрөнгө итгэмжлэн удирдах, кастодиан, брокер, нягтлан бодох бүртгэлийн зэрэг үйлчилгээний нийт төлбөрийг ойлгоно.
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 28-р зүйлийн 28.1-т заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компани болон кастодианы үйлчилгээний зардлыг тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөнөөс төлөх бөгөөд уг зардлын жилийн нийлбэр дүн нь хөрөнгө оруулалтын сангийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн 3%-аас хэтрэхгүй байна.
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19-р зүйлийн 19.11.4, 28-р зүйлийн 28.3-т тус тус заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэлээс шалтгаалан түүнд хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс гүйцэтгэлийн урамшуулал олгох боломжтой байна.

■ Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын сангууд

2025 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 7 хамтын хөрөнгө оруулалтын сан, 46 хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна (Санхүүгийн салбарын тойм, Хороо, 2025). Монгол Улсад хөрөнгө оруулалтын сангуудын зах зээл дөнгөж эхэлж буй ч цаашид хурдтай өсөх боломжтой бөгөөд хувь хүмүүс банкны хадгаламжаас илүү өгөөж хайж, мэргэжлийн багт итгэн мөнгөө удирдуулж эхлэх соёл төлөвшиж байна.

Хүснэгт 18: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй зарим хамтын хөрөнгө оруулалтын сангуудын ерөнхий мэдээлэл

Нэр	Төрөл	Гол хөрөнгө оруулалтын төрөл	Өгөөж	Хөрөнгө итгэмжлэн удирдлагын төлбөрийн бүтэц ¹⁷	Үйл ажиллагаа явуулж буй хугацаа	Активын хэмжээ
Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС	Хамтын хаалттай ХОС	Хувьцаа, тогтмол	-20.1%	1.0% / 10.0%	4 жил	45.9 тэрбум

¹⁷ Менежментийн төлбөр /Гүйцэтгэлийн урамшууллын төлбөр гэсэн бүтцээр тус мэдээллийг оруулав.



2026 07.09
Дээрх тулгамдаж буй асуудлуудад үндэслэн дотоодын хөрөнгийн зах зээлд АНУ-н суурилсан хамтын биржээр арилжаалагддаг сан (ETF)-г бий болгох нь дараах үндсэн сайжруулалтыг дотоодын зах зээлд бий болгох боломжтой гэж үзэж байна.

✓ **Зах зээлийн хөрвөх чадвар ба нэгж эрхийн үнэ**

Хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээлд ETF-ийн нэгж эрхийг бирж дээр ажлын өдөр бүр арилжаалах боломжтойгоос гадна мэргэжлийн оролцогч болон/эсхүл зах зээл үүсгэгч нь нэгж эрхийн зах зээлийг үүсгэх замаар нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлж ажиллана. Улмаар, ETF-ийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэ цэн болон нэгж эрхийн зах зээлийн үнэ хоорондоо харьцангуй ойролцоо тогтох боломж бүрдэнэ гэж үзэж байна.

✓ **Хөрөнгө оруулагчдын бүтэц, бүтээгдэхүүний сонголтод гарах өөрчлөлт**

ETF нь хөрөнгө оруулагчдад шинэ төрлийн бүтээгдэхүүний сонголт өгөх тул зах зээлийн оролцогчдын бүтцэд тодорхой өөрчлөлт авчирна гэж үзэж болохуйц байна. Нэн түрүүнд, жижиглэн хөрөнгө оруулагчид (иргэд) хувьцаа тус бүрийг судалж, сонгон авах шаардлагагүйгээр индексийн багцыг бүхэлд нь нэгж эрхээр худалдаж авах боломж бүрдэх нь том давуу тал юм. Тийнхүү өмнө нь хувьцаанд шууд хөрөнгө оруулахдаа эргэлздэг байсан, мэдлэг мэдээлэл дутмаг байсан хөрөнгө оруулагчид мэргэжлийн хөрөнгө оруулалтын шинжээчдийн бүрдүүлсэн багцад суурилсан ETF-ийг сонирхох хандлага ажиглагдах боломжтой. Олон улсын жишээнээс харахад ETF нь иргэдийн дунд урсгал зардал багатай, хялбар хөрөнгө оруулалт гэж тодорхойлогддог тул санхүүгийн зах зээлийг олон нийтэд хүртээмжтэй хүргэхэд эерэг нөлөөтэй байдаг.

Хөрөнгө оруулалтын сангийн зах зээл нь эдийн засгийн өгөөжийг олон нийтэд хүргэх, хөрөнгийн зах зээлийг өргөжүүлэх, тэлэх чухал хэрэгсэл юм. Дэлхийн чиг хандлагаас хоцрохгүйгээр, Монгол Улс хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх нь санхүүгийн зуучлалыг сайжруулж, хөрөнгө капиталын оновчтой хуваарилалт, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжих стратегийн ач холбогдолтой. ETF зэрэг шинэлэг бүтээгдэхүүнийг мэргэжлийн түвшинд нэвтрүүлж чадсанаар хөрөнгө оруулагчдын итгэлийг татах, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэх, санхүүгийн салбарыг олон тулгууртай болгох зорилтуудад хүрэх нэг алхам болно гэж үзэж байна. Олон улсын сайн туршлагыг өөрсдийн дотоод нөхцөл, боломжуудтай хослуулан хэрэгжүүлж чадвал Монгол Улсын хөрөнгө оруулалтын сангийн зах зээл цаашид эрчимтэй өсөж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн шинэ үеийг эхлүүлэх бүрэн боломжтой байна.



2026-07-20

2.3. ХУУЛЬ-ЭРХЗҮЙН ОРЧИН

БҮРТГЭВ-03

2.3.1.

ХОС-ИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ДАГАЖ МӨРДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ

ДҮРЭМ ЖУРАМ

2026-07-09

өдөр

БҮРТГЭВ

01

ХОС нь үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд энэхүү Танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах голлох хууль тогтоомж, Хороо болон Хөрөнгийн биржийн холбогдох журмыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллана. Үүнд:

Хүснэгт 19: ХОС-ийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх зарим эрх зүйн актын мэдээлэл

Эрх зүйн актын нэр	Эрх зүйн актын төрөл	Батлагдсан огноо	Тайлбар
Иргэний хууль	Хууль	2002.01.10	ХОС нь эрх зүйн этгээд болохын хувьд үндсэн үйл ажиллагааны хүрээнд аливаа баримт бичиг, хэлцэл хийх, гэрээ байгуулах зэргээр иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо Иргэний хуулийн ерөнхий зарчим, нийтлэг үндэслэл, гэрээний эрх зүйн ерөнхий болон тухайлсан зохицуулалтуудыг баримталж ажиллана.
Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	Хууль	2013.05.24	Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.12-т хамтын хөрөнгө оруулалтын сан ҮЦ33-д зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээд тул ХОС нь үйл ажиллагаандаа тус хуулийг баримтлан байна.
Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль	Хууль	2013.10.03	Мөн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т заасны дагуу тус хуулиар хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллагаас зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна гэж заасан тул ХОМК нь ХОС-г үүсгэн байгуулах, ХОС-ийн үйл ажиллагааг явуулах, холбогдох тайлан мэдээг тайлагнах зэргээр ХОС-ийн бүхий л үйл ажиллагаанд тус хуулийг дагаж мөрдөнө.
Компанийн тухай хууль	Хууль	2011.10.06	ХОС нь мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасны дагуу хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байх тул Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг үйл ажиллагаандаа мөрдөнө.
Зөвшөөрлийн тухай хууль	Хууль	2022.06.17	Мөн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2.31-т зааснаар хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээд тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлнэ гэж заасан тул ХОС-г үүсгэн байгуулах, Хорооноос тусгай зөвшөөрөл авахтай холбоотой ажиллагаанд тус хуулийг баримтална.
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	Хууль	2013.05.31	Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т зааснаар ХОС нь мэдээлэх үүрэгтэй этгээд байх тул харилцагчийг таньж мэдэх ажиллагааг хэрэгжүүлэх, харилцагч, гүйлгээнд хяналт тавих, эрсдэлтэй харилцагч, гүйлгээг мэдээлэх зэрэг ажиллагааг хэрэгжүүлж ажиллах байна. Дээрх ажиллагаанд тус хуулийг баримталж ажиллана. ХОС нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр мөн хуулиас гадна холбогдох олон улсын гэрээ, конвенц, ФАТФ-ын зөвлөмжийг баримтална.
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	Хууль	2019.03.22	Тус хуульд заасны дагуу Монгол Улсын бүртгэлд бүртгэгдэж, үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд тус хуульд заасны дагуу ААНӨАТ-ын тайланг тайлагнах, холбогдох татварыг төсөвт шилжүүлэх байна. Иймд ХОС нь үйл ажиллагаанд тус хуулийн мөрдөж ажиллах байна. Мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15-т зааснаар хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026-07-20

БҮРТГЭВ-03



ОЗ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА



[Handwritten signature]


2026.07.09

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

БҮРТГЭВ-03

ХОС-ийн талаарх ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 20: Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга



ХОС-ийн хуулийн этгээдийн бүртгэл

ХОС-ийн оноосон нэр	▪ "Фьючер Тек Инновэйшн хамтын биржээр арилжаалагддаг ХОС" ХХК
ХОС-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар	▪ 9011894544
ХОС-ийн регистрийн дугаар	▪ 7295945
Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	▪ 2026 оны 06-р сарын 17-ны өдөр
Үйл ажиллагааны чиглэл	▪ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа
ХОС-ийн хэлбэр	▪ Хамтын ХОС
ХОС-ийн төрөл	▪ Нэгж эрхээ зохицуулалттай этгээдийн эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын багцаар солих замаар сангийн активаа бүрдүүлдэг, бирж дээр нэгж эрх нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан (Биржээр арилжаалагддаг сан буюу Exchange traded fund)
ХОС-ийн стратегийн төрөл ²⁰	▪ Үнэт цаасны индексийн сан буюу арилжаа эрхлэх байгууллагаас тооцон гаргадаг индексийн багцад багтдаг үнэт цаасанд хөрөнгө оруулах сан.
ХОС-ийн үйл ажиллагаа явуулах хугацаа	▪ 10 жил (Энэхүү хугацааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу нэг удаа сунгаж болно)
ХОС-ийн Гүйцэтгэх захирал ²¹	▪ Д.Одмаа

ХОС-тай холбоо барих утас, хаяг байршил


ХОС-ийн утасны дугаар	▪ (976) 7775-2050
ХОС-ийн мэдээлэл авах цахим хуудас	▪ www.etf.mn
ХОС-ийн оршин байх хаяг (шуудангийн хаяг)	▪ Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Цэнтрал Тауэр, 4 давхар, 409 тоот

ХОС-ийн Хөрөнгө оруулалтын удирдлага

ХОС-ийн баримтлах индекс	▪ Фьючер Тек Инновэйшн Индекс
Индекс тооцогч	▪ "Монголын хөрөнгийн бирж" ХК
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зорилго	▪ ХОС нь үйл ажиллагааны зардлыг тооцохоос өмнөх өгөөжийн гүйцэтгэлийг Хөрөнгийн биржийн тооцон гаргадаг Фьючер Тек Инновэйшн Индекс (Future Tech Innovation Index)-ийн гүйцэтгэлтэй ойролцоо байлгахыг зорьж ажиллана. ▪ ХОС нь Индексийг дагахдаа бүрэн хуулбарлах (Full replication) замаар идэвхгүй буюу пассив хөрөнгө оруулалтын удирдлагын стратегийг хэрэгжүүлнэ.
Хөрөнгө оруулалтын стратеги	Идэвхгүй хөрөнгө оруулалтын удирдлага гэдэг нь ХОС өөрийн үйл ажиллагаандаа баримтлахаар сонгосон индексийн багцын бүтэцтэй нийцүүлэн хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлж, тухайн индексийн гүйцэтгэлтэй ойролцоо өгөөж хүртэхийг зорьдог стратеги юм.
ХОС-ийн хөрөнгө оруулах боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгсэл	▪ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх; ▪ Ашигт малтмалын бүтээгдэхүүнд суурилсан хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;

²⁰ Хорооны 2025 оны 02-р сарын 25-ны өдрийн 64 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам"-ын 16 дугаар зүйлийн 16.1-т хамтын ХОС-г хөрөнгө оруулалтын стратегиас хамааруулан ангилахаар заасан болно.

²¹ ХОС-ийн гүйцэтгэх удирдлагыг Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр ХОМК нь хэрэгжүүлэх ба ХОМК-ийн Гүйцэтгэх захирал нь ХОС-ийн Гүйцэтгэх захирал гэж хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдэнэ.



2026-07-20

БҮРТГЭВ-03

2026.07.09 өдөр

БҮРТГЭВ

- Мөнгөн хөрөнгө, 12 сараас ихгүй хугацаатай банкны хадгаламж, гадаад улсын Засгийн газраас гаргасан богино хугацаатай үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан богино хугацаатай үнэт цаас болон Монгол Улсын Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас;
- Холбогдох хууль, тогтоомж болон Хорооны холбогдох журам, тогтоол, шийдвэрийн дагуу зөвшөөрөгдсөн бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүд.

ХОМК "Балансэд Грөүт Менежмент" ХХК

ХОС-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх Ж.Номин
Б.Анхбаяр

ХОС-ийн үйл ажиллагаандаа баримтлах баримт бичиг

ХОС-ийн үйл ажиллагаандаа мөрдөх дотоод дүрэм, журмууд	■ ХОС-ийн Дүрэм; ■ Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг; ■ Хөрөнгө итгэмжлэн удирдах журам; ■ Нэгж эрхийг солилцох, буцаан авах, үнийг тодорхойлох журам; ■ Эрсдэлийн удирдлагын журам; ■ Хяналтын үйл ажиллагааны журам; ■ Орлогыг сангийн активт бүртгэх журам; ■ Зардлын зүйл, дээд хэмжээг тогтоох журам; ■ Орлого хуваарилах журам; ■ Мэдээллийн үйл ажиллагааны журам; ■ Нэгж эрх эзэмшигчийг бүртгэх журам; ■ Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын үйл ажиллагааны журам; ■ ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; ■ Ёс зүйн дүрэм; ■ Татан буулгах үйл ажиллагааны журам.
ХОС-ийн үйл ажиллагаанд оролцогч талуудтай байгуулах гэрээ, хэлцлүүд	■ Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ; ■ Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ; ■ Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ; ■ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг хөрөнгө оруулалтын багцаар солилцох гэрээ; ■ Индексийн үйлчилгээний гэрээ.
ХОС-ийн Дүрэм, журамд өөрчлөлт оруулах	■ ХОС нь Хорооны зөвшөөрөлгүйгээр ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, Танилцуулга болон Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох эрхгүй болно.

ХОС-ийн орлого

ХОС нь Дүрэм, Бодлогын баримт бичгийн хүрээнд эрхэлсэн үйл ажиллагаанаас дараах төрлийн орлого бий болгох боломжтой	■ Хөрөнгө оруулсан хөрөнгө оруулалтын хэрэгслээс олсон хүү, өгөөжийн орлого; ■ Хөрөнгө оруулсан санхүүгийн болон хөрөнгө оруулалтын хэрэгслийг борлуулсан, шилжүүлсний орлого; ■ Хөрөнгийн үнэ цэний өсөлтөөс бий болсон орлого, олз; ■ Ногдол ашгийн орлого; ■ Хөрөнгө оруулалтын хэрэгслийн өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хийсэн хэлцлээс олсон орлого, олз; ■ Нэгж эрх нэмж гаргах эсхүл буцаан авах үйл ажиллагаатай холбоотойгоор Мэргэжлийн оролцогчоос хүлээн авсан шимтгэлийн орлого; ■ ХОС-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой олсон бусад орлого, олз; ■ Үндсэн үйл ажиллагааны бус бусад орлого, олз. ■ Бусад орлого, олз.
---	---

ХОС-ийн хөрөнгөөс гарах боломжтой зардлын төрөл

ХОС-ийн хөрөнгөөс дараах зардал гарах боломжтой	■ ХОС-г үүсгэн байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Хороо, Хөрөнгийн бирж, Үнэт цаасны
---	---



56

2026-07-20

Тусгай зөвшөөрөл, авсан
огноо

БҮТЭГЭЭ-03

2026-07-20

өдөр

БҮТЭГЭЭ

№ 01

- Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх (2022 оны 7-р сарын 06-ны өдөр)
- Үнэт цаас итгэмжлэн удирдах (2025 оны 3-р сарын 20-ны өдөр)
- Хөрөнгө оруулалтын зөвлөх (2025 оны 9-р сарын 25 -ны өдөр)

Гүйцэтгэх захирал

Д.Одмаа

Хөрөнгө оруулалтын зөвлөх

Ж.Номин
Б.Анхбаяр

Кастодиан

Оноосон нэр

"Голомт банк" ХК

Регистрийн дугаар

2075377

Тусгай зөвшөөрөл авсан огноо

2024 оны 8-р сарын 28-ны өдөр

Гүйцэтгэх захирал

А.Одонбаатар

Хөндлөнгийн аудитын байгууллага

Оноосон нэр

"Мэжикконсалтинг аудит" ХХК

Регистрийн дугаар

5354595

Тусгай зөвшөөрөл авсан огноо

2013 оны 01-р сарын 26-ны өдөр болон 2017 оны 12 сарын 15

Гүйцэтгэх захирал

С.Мөнхбаяр

3.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН УДИРДЛАГА

3.2.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ

ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хорооны Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд үндэслэн ХОС-ийн удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх үүргийг дараах байдлаар тогтоосон болно.

Зураг 30: ХОС-ийн удирдлагын бүтэц

ХОС-ийн нэгж эрх
эзэмшигч гишүүдийн
хурал

ХОС-ийн эрх барих дээд байгууллага нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал байна.

Төлөөлөн удирдах
зөвлөл

ХОС нь ТУЗ-тэй байх ба ТУЗ нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын чөлөөт цагт ХОС-ийн эрх барих дээд байгууллага байна.

Гүйцэтгэх
удирдлага /ХОМК/

ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг ХОМК нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд ХОМК-ийн Гүйцэтгэх захирал эсхүл түүний сонгосон эрх бүхий этгээдийг ТУЗ-ийн шийдвэрээр ХОС-ийн Гүйцэтгэх захирлаар томилно.



2026-07-20

3.2.2

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧ ГИШҮҮДИЙН ХУРАЛ

БҮРТГЭВ-03

2026-07-09

БҮРТГЭВ

№ 01

ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал, түүний үйл ажиллагаатай холбоотой харилцааг ХОС-ийн Дүрэм, Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын үйл ажиллагааны журам болон холбогдох бусад дотоод журмын хүрээнд зохицуулна.

ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал

ХОС-ийн Дүрэмд заасны дагуу, ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна. Түүнчлэн, ХОМК нь ХОС-ийн Дүрэм болон холбогдох дотоод журамд заасны дагуу ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг холбогдох зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Хүснэгт 21: ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын мэдээлэл

	Ээлжит хурал	Ээлжит бус хурал
Хурал хуралдуулах шаардлага	Хууль тогтоомж болон ХОС-ийн Дүрэмд заасан тохиолдол буюу ээлжит хурлыг жилд 1-ээс доошгүй удаа заавал хуралдуулна	- ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон; - ХОС-ийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30%-аас хэтэрсэн; - ХОС-ийн үйл ажиллагааны явцад ХОС-ийн цэвэр активын хэмжээ нь дараалсан хуанлийн 10 хоногийн туршид ХОС үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40%, эсхүл түүнээс илүү хэмжээгээр буурсан; - ХОМК татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө оруулалтын менежментийн компанид Хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн; - Кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө хадгалах гэрээний эрхийг өөр кастодианд шилжүүлэх шаардлага үүссэн; - ХОС-ийн бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг нь ХОС-ийн цэвэр активыг нь дараалсан хуанлийн 10 хоногийн туршид ХОС үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40%, эсхүл түүнээс илүү хэмжээгээр бууруулах нөхцөл байдал үүссэн; - ХОС татан буулгах нөхцөл бүрдсэн, эсхүл ХОС-г нэгтгэх, нийлүүлэх нөхцөл үүссэн; - Холбогдох хууль тогтоомж, ХОС-ийн Дүрэм, холбогдох дотоод журамд заасан бусад
Хурал хуралдуулах шаардлага гаргах этгээд		(ХОС-ийн Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын үйл ажиллагааны журамд ээлжит бус хурал хуралдуулах шаардлага гаргах эрхтэй этгээд, шаардлагын үндэслэл болон бусад харилцааг нарийвчлан зохицуулсан тул үүнтэй холбоотойгоор журамтай танилцана уу) - ТУЗ-ийн санал, шаардлагаар; - ХОМК-ийн санал, шаардлагаар; - ХОС-ийн нийт гаргасан нэгж эрхийн 1 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй нэгж эрх эзэмшигчийн санал, шаардлагаар; - ХОС-ийн Дүрэм, ХОС-ийн бусад дотоод журам болон холбогдох хууль тогтоомжид ээлжит бус хурал хуралдуулахаар заасан бусад тохиолдол
Хурал хуралдуулах шийдвэр гаргах этгээд	ТУЗ-ийн шийдвэрээр ээлжит хурлыг зарлан хуралдуулна.	- ХОМК-ийн санал, шаардлагаар хуралдуулах тохиолдолд ХОМК нь ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гаргана; - Бусад тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг зарлан хуралдуулна.



2026.07.09
Хурал
хуралдуулах
хугацаа
БҮРТГЭВ-03

2026.07.09 өдөр
БҮРТГЭВ

Хурал хуралдуулах хугацаа	Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулах буюу ТУЗ- өөс ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн 40-өөс доошгүй өдрийн дараа хуралдуулна.	1. ХОМК-ийн шийдвэрээр хуралдуулах тохиолдолд ээлжит бус хурал хуралдуулах шаардлага үүссэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор; 2. ТУЗ-ийн шийдвэрээр хуралдуулах тохиолдолд ээлжит бус хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн 45 өдрийн дотор хуралдуулна.
Хурлын зарыг хүргэх суваг	ХОМК болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар хүргэх ба Мэргэжлийн оролцогчид хурлын зарыг нэгж эрх эзэмшигчдэд хүргэх ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.	

ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын бүрэн эрх

ХОС-ийн Дүрэмд заасны дагуу дараах асуудлыг ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ба Хорооноос зайлшгүй зөвшөөрөл авах шаардлагатай шийдвэрүүд нь Хорооны шийдвэр гарснаар хүчинтэйд тооцогдож, эрх бүхий байгууллагад бүртгэгдэнэ. Үүнд,

- ✓ ХОС-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- ✓ Нэгж эрх нэмж зарлах;
- ✓ ХОС-г өөрчлөн байгуулах;
- ✓ ХОС-г татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- ✓ ТУЗ-ийн гишүүнийг сонгох, томилох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- ✓ ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- ✓ ХОС-ийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн, батлах;
- ✓ ТУЗ-ийн шийдвэрээр ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад.

3.2.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХОС-ийн ТУЗ, түүний үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг ХОС-ийн Дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон холбогдох бусад дотоод журмын хүрээнд зохицуулна.

ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтын хэлбэр нь хурал байх бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. ТУЗ нь хурлын дэгээ өөрөө тогтоох ба ТУЗ-ийн хурлыг хагас жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулна. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүн эсхүл ХОМК-ийн санаачилга, шаардлагаар хуралдуулж болно.

ХОС-ийн ТУЗ нь ХОМК-тай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, нэгж эрх эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, ХОС-ийн үйл ажиллагаанд сонирхлын зөрчил болон онцгой нөхцөл байдал үүсгэхээс сэргийлж ажиллана.

ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

ТУЗ нь Дүрэмд заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ ХОС-ийн үйл ажиллагааны болон засаглалын дараах баримт бичгийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах:
 - Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;
 - Нэгж эрхийн танилцуулга;
 - Хяналтын үйл ажиллагааны журам;



2026-07-29
БҮРТГЭВ

2026.07.29
БҮРТГЭВ
№ 01

- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
- Нэгж эрхийг солилцох, буцаан авах, үнийг тодорхойлох журам;
- Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын үйл ажиллагааны журам;
- Нэгж эрх эзэмшигчийг бүртгэх журам;
 - Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
 - Орлого хуваарилах журам;
 - Орлогыг сангийн активт бүртгэх журам;
 - ХОС-г татан буулгах үйл ажиллагааны журам;
 - Зардлын зүйл, дээд хэмжээг тогтоох журам;
 - Мэдээллийн үйл ажиллагааны журам;
 - Эрсдэлийн удирдлагын журам;
 - Ёс зүйн дүрэм;
 - Хууль тогтоомжид заасан бусад.
- ✓ Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - ✓ Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - ✓ ХОС-г өөрчлөн байгуулах, татан буулгах тухай нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - ✓ ХОС-ийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ХОМК-ийн тайланг хэлэлцэн баталж, дүгнэлт гаргах;
 - ✓ ХОМК-д олгох үйлчилгээний төлбөрийн хэмжээг тодорхойлох, түүнтэй Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулах;
 - ✓ Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагуудаас ХОС-д хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдийг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, ХОС-г төлөөлөн гэрээ байгуулах, шаардлагатай гэж үзвэл уг эрхийг ХОМК-д шилжүүлэх;
 - ✓ ХОС-д кастодианы үйлчилгээ үзүүлэх этгээдийг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, тухайн кастодиантай ХОС-г төлөөлөн гэрээ байгуулах, шаардлагатай гэж үзвэл уг эрхийг ХОМК-д шилжүүлэх;
 - ✓ Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг олгох;
 - ✓ Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг олгох;
 - ✓ Ногдол ашиг хуваарилах эсэх, хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд түүний хэмжээ, түүнийг төлөх нөхцөлийг тодорхойлох;
 - ✓ ХОС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих;
 - ✓ ХОС-ийн Гүйцэтгэх захирлаар ХОМК-ийн Гүйцэтгэх захирлыг, эсхүл түүний санал болгосон этгээдийг томилох;
 - ✓ ХОМК-ийн шийдвэрээр ТУЗ-өөр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
 - ✓ Хууль тогтоомж, ХОС-ийн холбогдох дотоод журамд заасан бусад.

ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

ХОС-ийн 2026 оны 6 сарын 12-ны өдрийн Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг томилсон ба ХОС-ийн ТУЗ нь дотоодын болон олон улсын хөрөнгө оруулалт, үнэт цаас, банк, санхүүгийн салбарт ажиллаж байсан ҮЦЗЗ-ийн мэдлэг, туршлагатай гишүүдээс бүрдэж байна.

Энэхүү Танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар ХОС-ийн ТУЗ-ийн гишүүд нь ХОС-д хувь эзэмшилгүй байна.





Г.Маргад

ТУЗ-ийн дарга

10 жилийн туршлага

Ажлын туршлага:

- 2023 он - одоо: "Балансэд Грөүт Менежмент" ХХК, Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал;
- 2022 он - 2023 он: "Ти Ди Би Ассет Менежмент" ХХК, Хөрөнгө оруулалтын зөвлөх;
- 2017 он - 2022 он: "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК, Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хэлтсийн захирал;
- 2016 он - 2017 он: "Худалдаа Хөгжлийн Банк" ХК, Мэргэжилтэн.

Боловсрол:

- Монгол Улс, СЭЗИС, Санхүүгийн удирдлага, Бакалавр.

ТУЗ-ийн гишүүн

22 жилийн туршлага

Ажлын туршлага:

- 2024 он – одоо: "Актив Финкрафт" ХХК, Гүйцэтгэх захирал
- 2022 он – 2024 он: "Инвескор Ассет Менежмент ҮЦК" ХХК, Багцын менежер;
- 2021 он – 2022 он: "Зайон Ассет Менежмент" ХХК, Хөрөнгө оруулалтын зөвлөх;
- 2020 он – 2021 он: "Номин Холдинг" ХХК, Эдийн засагч;
- 2010 он – 2018 он: "Макс Импекс" ХХК, Санхүүгийн албаны дарга;
- 2004 он – 2009 он: "Анод банк" ХХК, Зээлийн мэргэжилтэн.

Боловсрол:

- CFA Institution, CFA цол эзэмшигч;
- Монгол Улс, МУИС, Эдийн засаг, Бакалавр.



Б.Жүгдэррагчаа, CFA

ТУЗ-ийн хараат бус гишүүн

12 жилийн туршлага

Ажлын туршлага:

- 2024 он – одоо: "Вайт Крест Партнерс энд Ассосиатс" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2019 он – 2023 он: "Goldman Sachs", Хөрөнгө оруулалтын банкны ахлах шинжээч;
- 2015 он – 2017 он: "Schulze Global Investment", Ахлах шинжээч;
- 2014 он – 2015 он: "Монгол Улсын Хөгжлийн Банк" ХХК, Мэргэжилтэн.

Боловсрол:

- CFA Institution, CFA цол эзэмшигч;
- АНУ, Колумбын Их Сургууль, Бизнесийн удирдлага, Магистр;
- БНХАУ, Бээжингийн Их Сургууль, Хиймэл оюун ухаан, Бакалавр.



Г.Мөнх-Ариун, CFA

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

7 жилийн ажлын туршлага

Ажлын туршлага:

- 2025 он – одоо: "Балансэд Грөүт Менежмент" ХХК, Ахлах хуульч;
- 2022 он – 2025 он: "Инвескор Ассет Менежмент ҮЦК" ХХК, Комплайнсын мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
- 2019 он – 2020 он: "Койот Трейд" ХХК, Гэрээний мэргэжилтэн.

Боловсрол:

- Монгол Улс, МУИС, Эрх зүй, Магистрант;
- Монгол Улс, МУИС, Бизнесийн удирдлага, Бакалавр;
- Монгол Улс, МУИС, Эрх зүй, Бакалавр.



М.Энхцацрал



2026-07-20
3.2.4.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ

2026.07.20 9 өдөр
БҮРТГЭВ

ХОС-ийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий "Балансэд Грөүт Менежмент" ХХК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журам, ХОС-ийн Дүрэм, дотоод журам болон ХОС-тай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд ХОС-ийн гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана.

ХОМК нь дараах эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийг үйл ажиллагаандаа баримталж ажилладаг.

Зураг 31: ХОМК-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл



3.2.4.1. ХОМК-ийн хуулийн этгээдийн бүртгэл

ХОМК нь 2022 оны 2-р сарын 11-ний өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн ба мөн оны 7-р сарын 06-ны өдөр Хорооны 381 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ 309/44 дугаар бүхий тусгай зөвшөөрлөө авсан. Энэхүү тусгай зөвшөөрлийн хүрээнд, ХОМК-ийн үндсэн үйл ажиллагаа болох ХОС-г үүсгэн байгуулах, ХОС-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлэх, түүнийг төлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХОМК нь ХОС-д тус үйлчилгээг үзүүлэхдээ ХОС-ийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулна. Энэхүү Танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар ХОМК-ийн хуулийн этгээдийн бүртгэл, албан ёсны хаяг болон хөрөнгийн хэмжээ дараах байдалтай байна.

Хүснэгт 23: ХОМК-ийн хуулийн этгээдийн бүртгэл

ХОМК-ийн хуулийн этгээдийн бүртгэл

Хуулийн этгээдийн нэр	■ "Балансэд Грөүт Менежмент" ХХК
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	■ 2022 оны 2-р сарын 11-ний өдөр
Улсын бүртгэлийн дугаар	■ 9011836055
Регистрийн дугаар	■ 6819532
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	■ Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа ■ Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа ■ Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа ■ Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх (2022 оны 7-р сарын 06-ны өдөр)
Эзэмшиж буй тусгай зөвшөөрөл, түүнийг авсан огноо	■ Үнэт цаас итгэмжлэн удирдах (2025 оны 3-р сарын 20-ны өдөр)



Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний
дугаар
Гүйцэтгэх захирал

- Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх (2025 оны 9-р сарын 25-ны өдөр)
- ТЗ 309/44
- Д.Одмаа

ХОМК-ийн хаяг байршил

Хаяг	■ Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Цэнтрал Тауэр, 4 давхар, 409 тоот
Цахим хуудас	■ www.balancedgrowth.mn
Цахим шуудан	■ Info@balancedgrowth.mn
Холбоо барих утас	■ (976) 7775-2050

ХОМК-ийн хөрөнгийн мэдээлэл, 2025 он

Хувьцаа эзэмшигчийн оноосон нэр	■ "Скай парк плаза" ХХК
	■ "Домог импекс" ХХК
	■ Сайнбуянгийн Батбаяр

3.2.4.2. ХОМК-ийн бүтэц зохион байгуулалт, компанийн засаглал

Энэхүү Танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар ХОМК-ийн бүтэц, зохион байгуулалт дараах байдалтай байна.

Зураг 32: ХОМК-ийн бүтэц, зохион байгуулалт



Стратеги, бизнес
хөгжлийн газар

Хөрөнгийн
удирдлагын газар

Санхүүгийн удирдлага,
хяналтын газар

Эрсдэлийн
удирдлагын газар

ХОМК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал

ХОМК-ийн Дүрэмд заасны дагуу эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба ХОМК-ийн Дүрэм болон холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын хүрээнд холбогдох эрх эдэлж, үүрэг хүлээнэ.



Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ХОМК-ийн ТУЗ байх ба ХОМК-ийн ТУЗ нь компанийн бүх үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, хяналт тавих үүрэгтэй билээ. ХОМК-ийн Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу ХОМК-ийн ТУЗ нь 3 гишүүнээс бүрдсэн байх бөгөөд түүний гуравны хоёр хүртэлх нь хараат бус гишүүн байна.

Үүний хүрээнд, ХОМК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 6-р сарын 29-ний өдрийн №04 тоот шийдвэрээр С.Болорыг ХОМК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр, 2023 оны 11-р сарын 01-ний өдрийн №06 тоот шийдвэрээр З.Оюунцацралыг хараат бус гишүүнээр, 2025 оны 1-р сарын 06-ны өдрийн №01 тоот тогтоолоор Т.Бат-Эрдэнийг хараат бус гишүүнээр тус тус томилсон байна. 2022 оны 6-р сарын 29-ний өдрийн №03 тоот ХОМК-ийн ТУЗ-ийн тогтоолоор С.Болорыг ХОМК-ийн ТУЗ-ийн даргаар сонгосон. Түүнчлэн, ХОМК нь Хорооны "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилладаг.

Хүснэгт 24: ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга

Нэр, албан тушаал	Мэдээлэл
С.Болор ХОМК-ийн ТУЗ-ийн дарга 10 жилийн туршлага	Ажлын туршлага: 2019 он - одоо: "Тэсо" ХХК-ийн Гүйцэтгэх захирал; 2018 он - 2019 он: "Тэсо" ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичиг, Хуулийн зөвлөх; 2017 он - 2018 он: "Тэсо Пропертис" ХХК, Хуулийн зөвлөх; 2016 он - 2017 он: "Өмгөөллийн "Легал Полиси" ХХН, Хуулийн мэргэжилтэн. Боловсрол: - Монгол Улс, СЭЗИС, Санхүүгийн удирдлага, Магистр; - Монгол Улс, МУИС, Эрх зүйч, Бакалавр.
Т.Бат-Эрдэнэ ХОМК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн 23 жилийн туршлага	Ажлын туршлага: 2023 он – одоо: "Текафай" ХХК, Гүйцэтгэх захирал; 2006 он – 2023 он: "Худалдаа, хөгжлийн банк" ХК, Ахлах программ зохиогч, Төслийн удирдлагын захирал, Стратеги, хөгжил, инновацийн газрын захирал; 2003 он – 2005 он: Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Холбоо Мэдээллийн Технологийн сургууль, Багш. Боловсрол: - Монгол Улс, ШУТИС, Мэдээллийн технологи, Магистр. - Монгол Улс, ШУТИС, Мэдээллийн технологи, Бакалавр;
З.Оюунцацрал ХОМК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн 30 жилийн туршлага	Ажлын туршлага: 2023 он - одоо: "Балансэд Грөүт Менежмент" ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн; 2022 он - одоо: "Ньюфонд ББСБ" ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн; 2019 он - одоо: "До Би Чи Консалтинг" ХХК, Гүйцэтгэх захирал; 2013 он - одоо: "Компанийн засаглалын хөгжлийн төв" НҮТББ, Сургагч багш; 2012 он - одоо: "Банк санхүүгийн академи" ГҮТББ, Сургагч багш; 2007 он - 2008 он: ADB, German Technical Cooperation, OD Consulting, "Agricultural and Rural Development Project", Үндэсний зөвлөх; 2003 он - 2005 он: Germany Development Cooperation, Ministry of Industry and Trade, Royal Netherland Emnassy Beijing, "Private Sector Development Project", Ерөнхий зөвлөх, Ахлах зөвлөх; 1996 он - Одоо: "Санхүү Эдийн Засгийн Их Сургууль" НҮТББ, Багш, ахлах багш, Дэд профессор, Профессор, Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгч. Боловсрол: - Монгол Улс, СЭЗИС, Бизнесийн удирдлага, Доктор.



2026-07-20

БҮРТГЭВ-03

Монгол Улсын СЭЗИС болон БНСУ-ын Хандонг Глобал Их Сургуулийн хамтарсан хөтөлбөр, Санхүүгийн удирдлагаар мэргэшсэн бизнесийн удирдлага, Магистр;
Монгол Улс, Эдийн засгийн коллеж, Бизнесийн удирдлага, Бакалавр.

СЗХ

2026-07-09

БҮРТГЭВ

№ 01

Ажлын туршлага:

- 2018 он – одоо: “Тэсо” ХХК, Хүний нөөцийн газар, Бодлогын менежер, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
- 2012 он - 2018 он: “ХаанБанк” ХК, Өмчийн харилцааны газар, Мэргэжилтэн;
- 2012 он - 2012 он: “Тэсо” ХХК, Захиргааны ажилтан;

Т.Солонго

ХОМК-ийн ТУЗ-ийн
нарийн бичгийн дарга

Боловсрол:

- “Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль”, Банк санхүү, бизнесийн удирдлага;
- “Хилийн Цэргийн Дээд Сургууль”, Эрх зүй, Бакалавр.

ХОМК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх үндсэн суурь нөхцөл нь ТУЗ-ийн дэргэдэх мэргэжлийн хороод бөгөөд тус хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Иймд, ХОМК нь Хорооны “Компанийн засаглалын кодекс”-ыг мөрдлөг болгон, ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороог байгуулан ажиллаж байна.

ХОМК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг

ХОС-тай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр ХОС-ийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх ХОМК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг нь Монгол Улсын ҮЦЗЗ-д мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй, банк санхүү, хөрөнгө оруулалтын салбарын туршлагатай байна. Түүнчлэн, ХОМК-ийн хөрөнгө оруулалтын зөвлөхүүд, эрсдэлийн удирдлага хариуцсан менежер нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6-т заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байна.

Хүснэгт 25: ХОМК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг болон хүний нөөцийн мэдээлэл

Нэр

Мэдээлэл



Д.Одмаа

Гүйцэтгэх захирал

21 жилийн туршлага

Ажлын туршлага:

- 2023 он - Одоо: “Балансэд Грөүт Менежмент” ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2011 он - 2023 он: “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК, Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал;
- 2005 он - 2011 он: “Худалдаа Хөгжлийн Банк” ХК, Данс хариуцсан ажилтан.

Боловсрол:

- Монгол Улс, МУИС, Банк санхүү, Бакалавр.



Г.Маргад

Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал

10 жилийн туршлага

Ажлын туршлага:

- 2023 он - Одоо: “Балансэд Грөүт Менежмент” ХХК, Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал;
- 2022 он - 2023 он: “Ти Ди Би Ассет Менежмент” ХХК, Хөрөнгө оруулалтын зөвлөх;
- 2017 он - 2022 он: “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК, Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хэлтсийн захирал;
- 2016 он - 2017 он: “Худалдаа Хөгжлийн Банк” ХК, Мэргэжилтэн.

Боловсрол:

- Монгол Улс, СЭЗИС, Санхүүгийн удирдлага, Бакалавр.



2026-07-28

БҮРТГЭВ.03



Э.Мөнхзул


Хөрөнгийн удирдлагын хэлтсийн захирал
7 жилийн ажлын туршлага

Ажлын туршлага:

- 2024 он – Одоо: "Балансэд Грөүт Менежмент" ХХК, Хөрөнгийн удирдлагын хэлтсийн захирал;
- 2022 он - 2024 он: "Инвескор Ассет Менежмент ҮЦК" ХХК, Сангийн менежер;
- 2021 он - 2022 он: "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК, Хөрөнгө оруулалтын менежер;
- 2019 он - 2021 он: "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, Санхүүгийн менежер
Гадаад арилжааны брокер.

Боловсрол:

- Унгар Улс, University of Szeged, Бизнесийн удирдлага, Бакалавр.



Э.Анхбаяр

Ахлах трейдэр буюу хөрөнгө оруулалтын зөвлөх
7 жилийн ажлын туршлага

Ажлын туршлага:

- 2025 он - Одоо: "Балансэд Грөүт Менежмент" ХХК, Ахлах трейдер;
- 2019 он – 2025 он: "Голомт Банк" ХК, Ахлах дилер;

Боловсрол:

- Монгол Улс, СЭЗИС, Санхүүгийн удирдлага, Бакалавр.



Ж.Номин, CFA

Хөрөнгийн удирдлагын ахлах менежер буюу хөрөнгө оруулалтын зөвлөх
4 жилийн ажлын туршлага

Ажлын туршлага:

- 2025 он - Одоо: "Балансэд Грөүт Менежмент" ХХК, Хөрөнгийн удирдлагын ахлах менежер;
- 2023 он – 2025 он: "Капитал Грөүт Партнерс" ХХК, Баялгийн удирдлагын ахлах менежер;
- 2022 он – 2023 он: "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК, Хөрөнгө оруулалтын шинжээч.

Боловсрол:

- CFA Institution, CFA цол эзэмшигч;
- Монгол Улс, СЭЗИС, Санхүүгийн удирдлага, Бакалавр.



Ч.Баярцэцэг

Хөрөнгийн удирдлагын менежер
12 жилийн ажлын туршлага

Ажлын туршлага:

- 2025 он - Одоо: "Балансэд Грөүт Менежмент" ХХК, Хөрөнгийн удирдлагын менежер;
- 2020 он - 2024 он: "Санхүү Эдийн Засгийн Их Сургууль", Санхүүгийн Удирдлагын Тэнхимийн багш;
- 2018 он - 2020 он: "Юнител" ХХК, Хөрөнгө зохицуулалтын ахлах мэргэжилтэн;
- 2014 он - 2018 он: "Юнивишн" ХХК, Санхүүгийн шинжээч.

Боловсрол:

- Монгол улс, СЭЗИС, Санхүүгийн удирдлага, Магистр;
- Монгол улс, СЭЗИС, Санхүүгийн удирдлага, Бакалавр.



2026-07-20

БҮГД



М.Энхцацрал

Ахлах хуульч


7 жилийн ажлын туршлага

Ажлын туршлага:

- 2025 он – Одоо: “Балансэд Грөүт Менежмент” ХХК, Ахлах хуульч;
- 2022 он – 2025 он: “Инвекор Ассет Менежмент ҮЦК” ХХК, Комплайнсын мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
- 2019 он – 2020 он: “Койот Трейд” ХХК, Гэрээний мэргэжилтэн.

Боловсрол:

- Монгол Улс, МУИС, Эрх зүй, Магистрант.
- Монгол Улс, МУИС, Бизнесийн удирдлага, Бакалавр;
- Монгол Улс, МУИС, Эрх зүй, Бакалавр;



М.Цэрэнтунгалаг

Хуулийн зөвлөх, комплайнсын мэргэжилтэн

5 жилийн ажлын туршлага

Ажлын туршлага:

- 2024 он – Одоо: “Балансэд Грөүт Менежмент” ХХК, Хуулийн зөвлөх, комплайнсын мэргэжилтэн;
- 2024 он: “Капитал грөүт партнерс” ХХК, Хуулийн зөвлөх;
- 2021 он – 2024 он: “Үйзэн ивээлт ББСБ” ХХК, Хуульч.

Боловсрол:

- Монгол Улс, СЭЗИС, Эрх зүй, Бакалавр;
- Монгол Улс, МУИС, Эрх зүй, Магистр.



2025-07-09

3.2.4.3. ХОМК-ийн үйлчилгээ үзүүлж буй бусад хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэл

БҮРТГЭВ № 01

2025.07.09 өдөр

БҮРТГЭВ № 01

ХОМК нь Танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар "Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС" ХХК болон "Би Жи Эм үл хөдлөх хөрөнгийн багц хувийн ХОС" ХХК-д хөрөнгийн оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлж байгаа ба ХОМК нь 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар дээрх хөрөнгө оруулалтын сангийн нийт 32.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг удирдаж байна.

■ "Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС" ХХК

ХОС-д үйлчилгээ үзүүлж буй ХОМК нь Хорооны 2024 оны 3-р сарын 04-ний өдрийн №70 тоот зөвшөөрлийн дагуу "Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС" ХХК-ийг үүсгэн байгуулсан ба 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар тус хувийн хөрөнгө оруулалтын сангийн нийт 26.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг удирдаж байна.

Хүснэгт 26: ХОМК-ийн үйлчилгээ үзүүлж буй "Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС" ХХК-ийн мэдээлэл

"Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС" ХХК	
Оноосон нэр	■ "Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС" ХХК
Регистрийн дугаар	■ 7000649
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	■ 2024 оны 3-р сарын 11-ний өдөр
Хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр, төрөл	■ Хувийн, хаалттай хөрөнгө оруулалтын сан
Үйл ажиллагааны чиглэл	■ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа
Үйл ажиллагаа явуулах хугацаа	■ 10 жил
Зорилго	■ Тус сангийн зорилго нь тогтмол орлого бүхий хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх замаар тогтмол орлого олох, хөрөнгийн үнэ цэнийг өсөлтийг бий болгох, урт хугацаанд сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.
Хөрөнгө оруулалтын стратеги	■ ХОМК нь ХОС-ийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэлээр жигнэсэн өгөөж (risk-adjusted return)-ийн түвшнийг нэмэгдүүлэхийг зорин ажиллах бөгөөд хөрөнгө оруулалтын олон төрлийн стратегийг үйл ажиллагаандаа баримтална.
Хөрөнгө оруулалтын менежментийн компани	■ "Балансэд Грөүт Менежмент" ХХК
Кастодиан	■ "Худалдаа, Хөгжлийн Банк" ХК

Нэгж эрхийн ЦХҮ-ний түүхэн мэдээлэл, мянган төгрөг



БҮРТГЭВ № 01

2026-07-28

“Би Жи Эм үл хөдлөх хөрөнгийн багц хувийн ХОС” ХХК

2026-07-09 өдөр

БҮРТГЭВ

№-01

ХОС-д үйлчилгээ үзүүлж буй ХОМК нь Хорооны 2025 оны 6-р сарын 26-ны өдрийн №257 тоот зөвшөөрлийн дагуу “Би Жи Эм үл хөдлөх хөрөнгийн багц хувийн ХОС” ХХК-ийг үүсгэн байгуулсан ба 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар тус хувийн хөрөнгө оруулалтын сангийн нийт 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг удирдаж байна.

Хүснэгт 27: ХОМК-ийн үйлчилгээ үзүүлж буй “Би Жи Эм үл хөдлөх хөрөнгийн багц хувийн ХОС” ХХК-ийн мэдээлэл

“Би Жи Эм үл хөдлөх хөрөнгийн багц хувийн ХОС” ХХК	
Оноосон нэр	“Би Жи Эм үл хөдлөх хөрөнгийн багц хувийн ХОС” ХХК
Регистрийн дугаар	7172617
Хуулийн этгээдэд бүртгүүлсэн огноо	2025 оны 7-р сарын 01-ний өдөр
Хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр, төрөл	Хувийн, хаалттай хөрөнгө оруулалтын сан
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа
Үйл ажиллагаа явуулах хугацаа	10 жил
Зорилго	ХОС-ийн зорилго нь үл хөдлөх эд хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших эрх болон бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх замаар тогтмол орлого олох, хөрөнгийн үнэ цэний өсөлтийг бий болгох, урт хугацаанд ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.
Хөрөнгө оруулалтын стратеги	ХОС нь хөрөнгө оруулалтын зорилгоо биелүүлэх хүрээнд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэл, өгөөжийн оновчтой харьцааг хангаж, зорилтот өгөөжийн түвшинд хамгийн бага эрсдэлийн түвшин бүхий хөрөнгө оруулалт хийхийг зорьж ажиллах бөгөөд хөрөнгө оруулалтын олон төрлийн стратегийг үйл ажиллагаандаа баримтална.
Хөрөнгө оруулалтын менежментийн компани	“Балансэд Грөүт Менежмент” ХХК
Кастодиан	“Худалдаа, Хөгжлийн Банк” ХК

Нэгж эрхийн ЦХУ-ний түүхэн мэдээлэл, мянган төгрөг



3.2.4.4. ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагаа



ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хорооны журамд заасны дагуу ХОС-д Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлнэ. ХОМК нь дээрх үйлчилгээг үзүүлэхдээ ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх, гуравдагч этгээдийн өмнө итгэмжлэлгүйгээр төлөөлөх зэрэг үйл ажиллагааг явуулна.

Хөрөнгө итгэмжлэн удирдах журам

ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааны хүрээнд ХОС нь Хөрөнгө итгэмжлэн удирдах журамтай байх бөгөөд ХОМК нь түүний хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагаандаа тус журмыг мөрдөж ажиллана. Тухайн журмаар дараах харилцааг зохицуулсан. Үүнд:

- ХОМК-ийн ерөнхий мэдээлэл, түүнтэй байгуулах Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн нөхцөлүүд;
- ХОМК-д төлөх менежментийн үйлчилгээний төлбөрийг тооцох, бүртгэх, төлөх зарчим;
- ХОМК-ийн итгэмжлэн удирдах хөрөнгө, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа;
- ХОС-ийн орлого, зардал;
- ХОС-ийн хөрөнгийг ХОМК-ийн хөрөнгөөс тусгаарлан Кастодианд хадгалах үйл ажиллагаа;
- ХОС-ийн нягтлан бодох бүртгэл;
- ХОС-ийн хяналтын үйл ажиллагаа;
- Тус журамтай холбоотой хариуцлагын зохицуулалт.

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ

ХОМК нь ХОС-тай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаар түүнийг төлөөлөх эрх үүсэх бөгөөд ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотойгоор ХОС-ийн Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг тус гэрээгээр тодорхойлно.

Гэрээний зорилго: Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр ХОМК-ийн зүгээс ХОС-ийн үйл ажиллагааг удирдах нөхцөл, журмыг тогтоох, ХОС-ийн хөрөнгийг тус гэрээ болон ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, холбогдох дотоод журамд заасны дагуу удирдах, ХОС нь ХОМК-д холбогдох төлбөрийг төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага зэрэг харилцааг зохицуулна.

Гэрээний хугацаа: ХОС-ийн Дүрэмд заасан ХОС-ийн үйл ажиллагаа явуулах хугацаатай адил байна. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу ХОС-ийн үйл ажиллагаа явуулах хугацааг нэг удаа сунгах боломжтой бөгөөд тийнхүү сунгасан тохиолдолд тус гэрээ мөн адил хугацаагаар сунгагдана.

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу ХОМК нь дараах үйлчилгээг ХОС-д үзүүлнэ.

- ✓ ХОС-г үүсгэн байгуулахтай холбоотойгоор Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын холбогдох журамд заасан баримт бичгийн бүрдлийг хангах, ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх;
- ✓ ХОС-г үүсгэн байгуулах, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх;
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн арилжааг зохион байгуулахтай холбоотойгоор Хөрөнгийн биржийн холбогдох журам, эрх бүхий байгууллагын журам, холбогдох бусад хууль тогтоомжид үндэслэн ХОС-ийн нэгж эрхийг Хөрөнгийн биржид бүртгүүлэх, арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах;
- ✓ ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, нэгж эрх эзэмшигч гишүүдийн болон ТУЗ-ийн хурлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлтийг хариуцах;
- ✓ Нэгж эрх эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;



2026

БҮРТҮҮСЭГ

2026.09.09 өдөр

БҮРТҮҮСЭГ

№ 01


- ✓ ХОС-ийн хөрөнгийг ХОМК-ийн хөрөнгөөс тусгаарлан, Кастодианд хадгалуулах ажиллагааг зохион байгуулах;
- ✓ ХОС-ийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой санхүүгийн анхан шатны бүх баримтыг үйлдсэн болон хүлээн авсан даруйдаа хувийг нь хадгалах болон Кастодианд хүргүүлэх;
- ✓ ХОС-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд нийцүүлэн ХОМК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлээс тусад нь хөтлөх;
- ✓ Холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, ХОС-ийн Дүрэм болон холбогдох дотоод журмын хүрээнд ХОС-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээг гаргаж, тогтоосон хугацаанд холбогдох этгээдэд хүргүүлэх;
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн арилжааг тасралтгүй, тогтвортой явуулах үүднээс зарласан нэгж эрхийн хүрээнд нэгж эрх нэмж гаргах, буцаан авах шийдвэрийг гаргах;
- ✓ ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах, буцаан авах үйл ажиллагааны цагийн хуваарийг батлах;
- ✓ Кастодианы үйл ажиллагаанд тус гэрээний хүрээнд хяналт тавих, ХОС-д үйлчилгээ үзүүлж буй Кастодианыг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд уг үйл ажиллагааг эрсдэлгүй зохион байгуулах, удирдлагаар хангах;
- ✓ ХОС-ийн ТУЗ болон нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг эрх бүхий этгээдийн шийдвэрээр зарлан хуралдуулах тохиолдолд тухайн хурлыг зохион байгуулалтаар хангах;
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Хорооны журам, ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ болон ХОС-ийн холбогдох дотоод журамд заасан эрх хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах;
- ✓ ХОС-ийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн бүх гүйлгээнд тухай бүр эргэн хяналт хийх, эрсдэлийг удирдах;
- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц нь ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг болон Хорооноос тогтоосон нөхцөл шалгуурыг хангаж байгаа эсэх талаар байнгын хяналтыг хэрэгжүүлж ажиллах;
- ✓ Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд ХОС-г гуравдагч этгээдийн өмнө итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
- ✓ ХОС-г шүүх, арбитрын ажиллагаанд төлөөлөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;
- ✓ Нэгж эрх эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;
- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх;
- ✓ Үнэт цаасны төлбөрийг зохих журмын дагуу шилжүүлэх;
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, ХОС-ийн Дүрэм, Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, болон тус Гэрээнд заасан ХОМК-ийн бусад эрх, үүргийг хариуцан хэрэгжүүлэх.

ХОМК нь дээрх үйлчилгээг үзүүлэхдээ ХОС-ийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах ба Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нөхцөл шаардлагыг ханган ажиллана

• **Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд ХОС нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:**

ХОС-ийн эдлэх эрх:

- ✓ ХОМК-ийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам болон ХОС-ийн Дүрэм, Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, Бодлогын баримт бичгийг баримтлан ажиллахыг шаардах;
- ✓ ХОМК-ийг тус гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- ✓ Тус гэрээ болон хуульд заасан тохиолдолд нэг талын санаачилгаар эсхүл ХОМК-тай харилцан тохиролцож гэрээг цуцлах;
- ✓ Хууль тогтоомж болон холбогдох бусад дүрэм, журамд заасан эрх.



2026-07-20

ХОС-ийн хүлээх үүрэг:

БҮРТГЭЛЭХ

ХОМК-ийн эрх хэмжээнд хамаарах шийдвэр, үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр нөлөөлөх, нөлөөлөхийг оролдохгүй байх;

- ✓ ХОС-ийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотойгоор ХОМК-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллах, үйл ажиллагаатай холбоотойгоор гарах зардлыг бодитоор тогтоох, түүнийг олгох;
- ✓ ХОМК-д төлөх менежментийн үйлчилгээний төлбөрийг олгох;
- ✓ Тус гэрээ болон хуульд зайлшгүй зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахгүй байх;
- ✓ Тус гэрээ болон ХОС-ийн Дүрэм, журамд заасан үүргээ биелүүлэх;
- ✓ Хууль тогтоомж болон холбогдох бусад дүрэм, журамд заасан үүрэг.

■ **Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд ХОМК нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:**

ХОМК-ийн эдлэх эрх:

- ✓ ХОС-г Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам болон ХОС-ийн Дүрэм, Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, Бодлогын баримт бичгийг баримтлан ажиллахыг шаардах;
- ✓ ХОС-г тус гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- ✓ ХОС-ийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотойгоор ХОМК-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллах мөн үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг бодитоор тогтоох, түүнийг олгохыг ХОС-аас шаардах;
- ✓ ХОС-аас ХОМК-д төлөх менежментийн үйлчилгээний төлбөрийн хувь хэмжээг тогтоох;
- ✓ Тус гэрээ болон хуульд заасан тохиолдолд нэг талын санаачилгаар эсхүл ХОС-тай харилцан тохиролцож гэрээг цуцлах;
- ✓ Хууль тогтоомж болон холбогдох бусад дүрэм, журамд заасан эрх.


ХОМК-ийн хүлээх үүрэг:

- ✓ Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцтай холбоотой санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хууль болон холбогдох дүрэм журамд нийцүүлэн өөрийн хөрөнгийн бүртгэлээс тусад нь хөтлөх;
- ✓ Хөрөнгө оруулагчид шаардлагатай тайлан мэдээг гаргаж өгөх;
- ✓ ХОС-ийн үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай тайлан мэдээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн цаг тухай бүрд нь гаргах;
- ✓ Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд үүнтэй холбоотойгоор эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
- ✓ ХОМК нь ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, Хөрөнгө итгэмжлэн удирдах журам болон тус гэрээнд заасан үүргээ зөрчсөний улмаас ХОС-д учруулсан бодит хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцах;
- ✓ Тус гэрээ болон ХОС-ийн Дүрэм, журамд заасан үүргээ биелүүлэх;
- ✓ Тус гэрээ болон хуульд зайлшгүй зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахгүй байх;
- ✓ Хууль тогтоомж болон холбогдох бусад дүрэм, журамд заасан үүрэг.



3.3
2026-07-20
3.3


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ТҮҮНИЙ
АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ ДҮРЭМ, ЖУРМЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ



3.3.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХОС-ийн үйл ажиллагаанд оролцогч голлох талууд болон үйл ажиллагааны ерөнхий зураглал дараах байдалтай байна.

Зураг 33: ХОС-ийн үйл ажиллагааны ерөнхий схем



• ХОС-ийн үйл ажиллагаа

ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журам, болон ХОС-тай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, холбогдох бусад ХОС-ийн дотоод журмын дагуу ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэж, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.


Энэхүү Танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар ХОС нь хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл байхгүй байна.

3.3.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаандаа баримтлах баримт болох Бодлогын баримт бичгийн товч агуулга нь дараах байдалтай байна.

Хүснэгт 28: ХОС-ийн Бодлогын баримт бичгийн хураангуй агуулга

Агуулга	Тайлбар
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зорилго	ХОС нь үйл ажиллагааны зардлыг тооцохоос өмнөх өгөөжийн гүйцэтгэлийг Хөрөнгийн биржийн тооцон гаргадаг Фьючер Тек Инновэйшн Индекс (Future Tech Innovation Index)-ийн гүйцэтгэлтэй ойролцоо байлгахыг зорьж ажиллана.
Хөрөнгө оруулалтын стратеги	ХОС нь Индексийг дагахдаа бүрэн хуулбарлах (Full replication) замаар идэвхгүй буюу пассив хөрөнгө оруулалтын удирдлагын стратегийг хэрэгжүүлнэ.



2026-07-20

БҮРТГЭВ-03

2026-07-20

ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц

- ХОС нь хөрөнгө оруулалтын зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжтой. Үүнд:
 - ✓ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;
 - ✓ Ашигт малтмалын бүтээгдэхүүнд суурилсан хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;
 - ✓ Мөнгөн хөрөнгө, 12 (арван хоёр) сараас ихгүй хугацаатай банкны хадгаламж, гадаад улсын Засгийн газраас гаргасан богино хугацаатай үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан богино хугацаатай үнэт цаас болон Монгол Улсын Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас;
 - ✓ Холбогдох хууль, тогтоомж болон Хорооны журам, тогтоол, шийдвэрийн дагуу зөвшөөрөгдсөн бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүд.
- ХОС нь үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор хөрөнгө оруулалтын багцын 10 (арав) хүртэлх хувийг мөнгөн хөрөнгө, 12 (арван хоёр) сараас ихгүй хугацаатай банкны хадгаламж, үнэт цаасанд²² хөрөнгө оруулах боломжтой.
- ХОС-ийн үйл ажиллагааны явцад зайлшгүй үүсэх бэлэн мөнгөний урсгал, төлбөр тооцооны хугацааны зөрүү болон бусад үйл ажиллагааны хүчин зүйлсээс үүдэн ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц нь Индексийн багцаас тодорхой хэмжээний зөрүүтэй байж болох ба ХОС нь уг зөрүүг боломжит хэмжээнд бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- ХОС нь Индексийн холбогдох аргачлалд заасан хугацааны давтамжтайгаар хөрөнгө оруулалтын багцаа шинэчлэх (Reconstitution) болон/эсхүл дахин тэнцвэржүүлэх (Rebalance) үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Тус шинэчилсэн болон/эсхүл дахин тэнцвэржүүлсэн хөрөнгө оруулалтын багц нь Индексийн багцтай ижил бүрэлдэхүүн болон хувийн жинтэй байхыг зорьж ажиллана.
- Индексийн багцад хуваарьт бус өөрчлөлт орсон тохиолдолд ХОС нь тухайн өөрчлөлттэй нийцүүлэн хөрөнгө оруулалтын багцыг өөрчилнө.
- ХОС-ийн хөрөнгө оруулалтын зорилготой нийцүүлэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь ХОМК байна.

ХОС-ийн орлогоос гишүүдэд хуваарилах бодлого:

- ХОС нь хөрөнгө оруулалтаас бий болох өгөөжийг хуримтлуулах, дахин хөрөнгө оруулалт хийх замаар ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцыг өсгөн нэмэгдүүлж, нийлмэл өгөөжийн үр нөлөөг бий болгох зарчмыг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаандаа баримтлах ба үүнтэй холбоотойгоор үйл ажиллагаа явуулах хугацаанд ногдол ашиг зарлахгүй байж болно.
- ХОС-г татан буулгах үед түүний Дүрэм, ХОС-ийн Орлого хуваарилах журам, Татан буулгах үйл ажиллагааны журам болон холбогдох бусад дотоод журмын дагуу ХОС-ийн хөрөнгийг хуваарилна.
- ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдэд орлого хуваарилах бодлого, нөхцөлийг тогтоох, хөрөнгө хуваарилахтай холбогдох харилцааг ХОС-ийн Дүрэм, Орлого хуваарилах журам болон бусад холбогдох дотоод журмаар нарийвчлан зохицуулна.

ХОС-ийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа:

- ХОС-ийн эрсдэлийн удирдлагатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Танилцуулгын 81-р хуудаснаас харна уу.
- Дараах тохиолдолд ХОС-ийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхийг ХОМК-д хориглоно. Үүнд:

Хязгаарлах нөхцөл:

- ✓ ХОС-ийн эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр сонирхлын зөрчилтэй хэлцэл эсхүл/болон их хэмжээний хэлцэл хийх;
- ✓ Бодлогын баримт бичгийг зөрчиж хөрөнгө оруулалт хийх;
- ✓ Бодлогын баримт бичигт тусгагдаагүй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;

²² ХОС-ийн Бодлогын баримт бичгийн 4.2-т заасны дагуу ХОС нь үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор хөрөнгө оруулалтын багцын 10 (арав) хүртэлх хувийг Бодлогын баримт бичгийн 4.1.3-т заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл буюу мөнгөн хөрөнгө, 12 (арван хоёр) сараас ихгүй хугацаатай банкны хадгаламж, гадаад улсын Засгийн газраас гаргасан богино хугацаатай үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан богино хугацаатай үнэт цаас болон Монгол Улсын Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасанд хөрөнгө оруулах боломжтой.

2026-07-20

БҮРТГЭЛЭГ-03
Хариуцлага:

✓ Холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журмыг зөрчин хөрөнгө оруулалт хийх.

ХОС-ийн Бодлогын баримт бичгийг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллага болон ХОС-ийн Дүрэм, холбогдох дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.3.3. ИНДЕКСИЙН ТУХАЙ

3.3.3.1. ХОС-ийн дагах Фьючер Тек Инновэйшн Индекс

Индексийн тухай ерөнхий мэдээлэл

ХОС-ийн дагаж буй Фьючер Тек Инновэйшн Индекс нь АНУ-ын хөрөнгийн биржид бүртгэлтэй 17 (арван долоо) хамтын биржээр арилжаалагддаг сан буюу ETF (Exchange Traded Fund)-ээс бүрдэх бөгөөд АНУ-ын хувьцааны зах зээл болон технологи, инновацын чиглэл, тэдгээрийн нийлүүлэлтийн сүлжээний чухал бүрэлдэхүүн болох түүхий эд, эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төлөөлөх зорилготой индекс байна.

Индекс нь Индексийн багц дахь ETF-үүдийн үнийн өгөөжид суурилсан индекс (Price return index) байна.

Хүснэгт 29: Индекстэй холбоотой ерөнхий мэдээлэл

Индексийн ерөнхий мэдээлэл

Индексийн нэр	▪ "Фьючер Тек Инновэйшн Индекс"
Индекс тооцогч	▪ "Монголын хөрөнгийн бирж" ХК
Индексийг бүртгүүлсэн арилжаа эрхлэх байгууллага	▪ "Монголын хөрөнгийн бирж" ХК
Индексийн суурь түвшин	▪ Индексийн суурь түвшнийг Индекс эхэлсэн өдрийн байдлаар 1,000 нэгжээр тогтоосон.
Индексийн валют	▪ Төгрөг
Индексийн түвшин, түүнийг тооцоолох давтамж	▪ Индексийн түвшнийг Индекс эхэлсэн өдрөөс хойш Тооцооллын өдөр (Calculation Day) бүр энэхүү Индексийн аргачлалд заасны дагуу тооцоолж, Индекс тооцогчийн албан ёсны хуудас (www.mse.mn) дээр Тооцооллын өдөр бүрийн өглөө 10:00 цагт мэдээлнэ.
Индекстэй холбоотой мэдээлэл	▪ Индекстэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Индекс тооцогчийн албан ёсны цахим хуудас (www.mse.mn) -аар дамжуулан авах боломжтой.

Индексийн багц

Индексийн багц	Дэд стратегийн чиглэл	Индексийн багцад эзлэх хувийн жин
	✓ АНУ-д үйл ажиллагаа явуулдаг, зах зээлийн үнэлгээний эрэмбээр эхний 500-д багтах компаниудын хувьцаанд тэнцүү хувийн жинтэйгээр хөрөнгө оруулдаг ETF	30%
	✓ Насдакийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, зах зээлийн үнэлгээний эрэмбээр эхний 100-д багтах санхүүгийн бус компанийн хувьцаанд хөрөнгө оруулдаг ETF (30%)	50%
	✓ Хиймэл оюун ухааны салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (5%)	
	✓ Чип үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (5%)	
	✓ Батлан хамгаалахын салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (5%)	



2026 07 26
БҮРТГЭВ-03

СЗХ
2026 07 26
БҮРТГЭВ
№ 03

- ✓ Роботик болон автоматжуулалтын салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (2.5%)
- ✓ Кибер аюулгүй байдлын салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (2.5%)
- ✓ Эрчим хүчний салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF 10%
- ✓ Таваарын бүтээгдэхүүнд голлон хөрөнгө оруулдаг ETF 10%

Индексийн хамрах хүрээ
(Index Universe)

Индексийн хамрах хүрээ (Index Universe): Индексийн хамрах хүрээ (Index Universe)-нд хамаарах ETF нь дараах үндсэн шалгуурыг хангасан байна.

Үүнд:

- **Үндсэн хөрөнгийн бирж:** Тухайн ETF-ийн нэгж эрх нь АНУ-ын дараах хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалагддаг байх:
 - ✓ Насдак хөрөнгийн бирж (Nasdaq exchange);
 - ✓ Нью-Йорк хөрөнгийн бирж (NYSE Arca exchange);
 - ✓ Cboe BZX хөрөнгийн бирж (Cboe BZX Exchange).
- **Хөрөнгө оруулалтын зорилго, стратеги:** Тухайн ETF-ийн хөрөнгө оруулалтын стратегийн чиглэл нь Индексийн зорилго, Индексийн стратегийн чиглэлтэй нийцэж байх;
- **Удирдаж буй хөрөнгийн хэмжээ:** Тухайн ETF-ийн активын хэмжээ нь 200.0 сая ам.доллараас доошгүй байх.
- **Хөрвөх чадвар:** Тухайн бирж дээр 6 (зургаа)-аас доошгүй сарын хугацаанд тогтмол арилжигдсан байх ба сүүлийн 3 сарын өдрийн дундаж арилжааны үнийн дүн (average daily value traded 3 months) нь 1 сая ам.доллараас доошгүй байх.

Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх (Index rebalancing) давтамж

- Хагас жилд нэг удаа

Индексийн багцыг шинэчлэх (Index reconstitution) давтамж

- Жилд нэг удаа

Бусад

Компанийн үйл ажиллагаа
(Corporate actions and events)

- Индексийн багцад багтсан хөрөнгө оруулалтын хэрэгслийг гаргасан этгээдийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон (Corporate actions and events) тохиолдолд түүний нөлөөллийг Индексийн тооцоололд оруулахдаа Индексийн тасралтгүй байдлыг хангах, эдийн засгийн утгыг алдагдуулахгүй байх зарчмыг баримтална.

- Индексийн багц дахь хөрөнгөтэй холбоотой Компанийн үйл ажиллагааг Индексийн аргачлалд заасан зарчмын дагуу зохицуулна.

- Индексийн ил тод, найдвартай ажиллагааг хангах зорилгоор Индексийн засаглал (Index Governance) -ийг бүрдүүлэх ба энэ нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

Индексийн засаглал

- ✓ Индекс тооцогч (Calculation Agent) – Арилжаа эрхлэх байгууллага буюу "Монголын хөрөнгийн бирж" ХК;
- ✓ Индекс администратор (Index Administrator) – Индексийн багцын бүрэлдэхүүн болон жинг тодорхойлогч;
- ✓ Индексийн хороо (Index Committee) – "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Үнэт цаасны индекс тооцох журам"-д заасны дагуу Индексийн аргачлалтай холбоотой санал дүгнэлт гаргах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, энэхүү аргачлалын хүрээнд Индекс тэй холбоотой шийдвэрийг гаргах чиг үүрэг бүхий хороо

- Индексийн засаглалд оролцогчдын чиг үүрэгтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг Индексийн аргачлалаас авна уу.

Бусад

- Зах зээлийн саатал, онцгой нөхцөл байдал, Индексийг зогсоох нөхцөл, аудит болон Индекс тэй холбоотой бусад харилцааг Индексийн аргачлалаар зохицуулна.



2026-07-20

Технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт

БҮРТГЭВ-03

СЭХ
2026.07.09 өдөр
БҮРТГЭВ
№ 01


Индексийн аргачлалд заасны дагуу хиймэл оюун ухааны салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (5%), чип үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (5%), батлан хамгаалахын салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (5%), роботик болон автоматжуулалтын салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (2.5%), кибер аюулгүй байдлын салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF (2.5%) болон тус эрчим хүчний салбарт голлон хөрөнгө оруулдаг ETF-үүдийг Индексийн хамрах хүрээ (Index Universe)-ний холбогдох ангиллаас дараах байдлаар тодорхойлно.

- ETF-үүдийг үнэлэх: Индексийн хамрах хүрээ (Index Universe) дэх холбогдох ангиллын ETF тус бүрийн хувьд Хүснэгт 30 дахь үзүүлэлтүүдийг тооцож, нормалчилан, холбогдох хувийн жинд үндэслэн нийлмэл оноог тодорхойлно. (Хүснэгт 30-д заасан 1-3 дугаартай үзүүлэлтүүдийг ETF тус бүрийн сүүлийн 3 жилийн түүхэн өгөгдөлд үндэслэн тооцно. Тухайн ETF нь үүсгэн байгуулагдсан, эсхүл холбогдох биржид бүртгэгдэн арилжигдаж эхэлснээс хойш 3 жил болоогүй тохиолдолд сүүлийн 1 жилээс доошгүй хугацааны түүхэн өгөгдөлд үндэслэн тооцно.)

Хүснэгт 30: Технологийн салбар болон эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтыг төлөөлөх ETF-ийг үнэлэх матриц

1	Sharpe харьцаа үзүүлэлт	$\frac{R_p - R_f}{\sigma_p}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	20.0%	Энэ нь нэгж эрсдэл (эерэг болон сөрөг ханшийн хэлбэлзэл)-д ногдох өгөөжийн хэмжээг илэрхийлнэ. Уг үзүүлэлт өндөр байх тусам тухайн ETF нь эрсдэлтэй харьцуулахад илүү үр ашигтай гүйцэтгэл үзүүлсэн гэж үнэлнэ.
2	Sortino харьцаа үзүүлэлт	$\frac{R_p - R_f}{\sigma_d}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	20.0%	Энэхүү нь ETF-ийн ханшийн зөвхөн сөрөг хэлбэлзлийг эрсдэл гэж үзэн, нэгж уналтын эрсдэлд ногдох өгөөжийг хэмжих үзүүлэлт юм. Энэ нь доош чиглэсэн эрсдэлийг илүү бодитой үнэлдэг бөгөөд тус үзүүлэлт өндөр байх тусам тухайн ETF нь уналтын үед илүү тогтвортой гүйцэтгэл үзүүлсэн гэж үзнэ.
3	Хамгийн өндөр уналтын хувь хэмжээ (Maximum Drawdown)	$\frac{Peak - Through}{Peak}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	20.0%	Энэхүү үзүүлэлт нь тухайн хугацаанд ETF-ийн ханш хамгийн өндөр түвшинд (Peak) хүрснээс хойш хамгийн доод түвшин (Trough) хүртэл хэдэн хувиар буурсныг хэмжинэ.
4	Шинжээчдийн нэгдсэн (дундаж) өсөлтийн хүлээлт (Analyst Implied Growth)	$\frac{WAP_{target} - WAP_{current}}{WAP_{current}}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	40.0%	Энэхүү үзүүлэлт нь Үнэлгээний өдрийн байдлаарх тухайн ETF-ийн багцад орсон хувьцаануудын жигнэсэн дундаж ханш (weighted average market price)-г тухайн хувьцаануудын шинжээчдийн нэгдсэн зорилтот ханш (consensus target price)-тай харьцуулж, тухайн ETF-ийн багцын түвшний өсөлтийн боломжийг тооцон илэрхийлнэ. Тус үзүүлэлт нь өндөр байх тусам тухайн ETF-ийг Үнэлгээний өдрийн байдлаар өсөлт үзүүлэх боломжтой багц эзэмшиж байна гэж үзнэ.

Эх сурвалж: Индексийн аргачлал



2026-07-20

Тайлбар:

БҮРТГЭВ

СЗА

2026-07-20

БҮРТГЭВ

№ 01

- Тухайн хугацааны дундаж өгөөж
- R_f : Эрсдэлгүй хүү. Үүнийг АНУ-ын Засгийн газрын 3 сарын хугацаатай Төрийн сангийн үнэт цаас (3-month U.S. Treasury Bill)-ны өгөөжийн дундаж үзүүлэлтээр төлөөлүүлэн тооцно.
- σ_p : Нийт стандарт хэлбэлзэл
- σ_d : Зөвхөн сөрөг өгөөжийн стандарт хэлбэлзэл
- X_i : Тухайн ETF-ийн холбогдох үзүүлэлт
- WAP_{target} : Тухайн ETF-ийн хөрөнгө оруулалтын багц дахь хувьцаа бүрийн хувьд шинжээчдийн нэгдсэн зорилтот үнийг хувийн жингээр үржүүлэн тодорхойлно
- $WAP_{current}$: Үнэлгээний өдрийн байдлаарх тухайн ETF-ийн хөрөнгө оруулалтын багцын жигнэсэн дундаж үнэлгээ
- Нийлмэл оноонд үндэслэн дэд стратегийн чиглэл бүрээс төлөөлөх ETF-ийг сонгох: Хүснэгт 30-ийн 2.2-2.6-д болон 3.1-т заасан чиглэл бүрийн хувьд хамгийн өндөр нийлмэл оноо бүхий 2 (хоёр) ETF-ийг сонгоно.
- Индексийн багцад орох ETF-ийг тодорхойлох: Индексийн багцад оруулах ETF нь тухайн стратегийн дэд чиглэлийн ангилалд багтсан нийт ETF-ийн нийлмэл онооны дундаж үзүүлэлтээс доошгүй оноотой байна.

Индексийн үнэ нь зах зээлийн ерөнхий нөхцөл, эдийн засгийн мөчлөг болон Индексийн багц дахь үнэт цаасны үнийн өөрчлөлтөөс хамааран хэлбэлзэх боломжтой. Тус Индекс нь мэдээллийн технологи болон өсөлтөд чиглэсэн компаниудад төвлөрөл ихтэй бөгөөд цөөн тооны томоохон компанийн хувьцааны үнийн хөдөлгөөн индексийн гүйцэтгэлд харьцангуй их нөлөөлөх боломжтой.

Хөрөнгө оруулагч нь Индекс тэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн албан ёсны цахим хуудас болох www.mse.mn цахим хуудаснаас авах боломжтой.

3.3.3.2. Индексийн аргачлалд хийсэн тестийн үр дүн (Back-test results)

Индексийн аргачлалын дагуу сонгогдсон Индексийн эхлэлийн багц нь дараах 17 ETF-ээс бүрдэж байна.

Хүснэгт 31: Индексийн эхлэлийн багц

№	Стратегийн чиглэл	ETF-ийн нэр	ETF-ийн симбол	Индексийн багцад эзлэх хувийн жин
1	АНУ-ын зах зээлийн үнэлгээгээр хамгийн том 500 орчим ХК-ийн хувьцааг тэнцүү хувийн жинтэйгээр агуулсан хөрөнгө оруулалт			30.0%
1.1	АНУ-ын хамгийн том 500 хувьцаат компанийн хувьцаанд суурилсан хөрөнгө оруулалт	The Goldman Sachs Equal Weight U.S. Large Cap Equity ETF	GSEW	30.0%
2	Технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт			50.0%
2.1	Ерөнхий технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт	The Invesco NASDAQ-100® ETF	QQQM	30.0%
2.2	Хиймэл оюун ухааны салбар	Global X Artificial Intelligence & Technology ETF	AIQ	2.5%
		The Roundhill Generative AI & Technology ETF	CHAT	2.5%
2.3	Чип үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн салбар	VanEck Semiconductor ETF	SMH	2.5%
		The Invesco PHLX Semiconductor ETF	SOXQ	2.5%
2.4	Батлан хамгаалахын салбар	Global X Defense Tech ETF	SHLD	2.5%



2026-07-20

БҮРТГЭВ

The Select STOXX®
Europe Aerospace &
Defense ETF

EUAD

СЗХ
2026.07.09 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2.5%

2.5 Роботик болон
автоматжуулалтын салбар

ROBO Global Robotics &
Automation ETF

ROBO

1.25%

ARK Autonomous Tech. &
Robotics ETF

ARKQ

1.25%

2.6 Кибер аюулгүй байдлын
салбар

First Trust NASDAQ
Cybersecurity ETF

CIBR

1.25%

The Amplify Cybersecurity
ETF

HACK

1.25%

3 Таваарын бүтээгдэхүүнд суурилсан хөрөнгө оруулалт

10.0%

3.1 Таваарын бүтээгдэхүүнд
суурилсан хөрөнгө оруулалт

Global X Copper Miners
ETF

COPX

10.0%

4 Эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт

10.0%

4.1 Эрчим хүчний салбарт
чиглэсэн хөрөнгө оруулалт

Range Nuclear
Renaissance Index ETF

NUKZ

2.5%

First Trust North American
Energy Infrastructure

EMLP

2.5%

VanEck Uranium and
Nuclear ETF

NLR

2.5%

State Street Energy Select
Sector SPDR ETF

XLE

2.5%

Эх сурвалж: Индексийн аргачлал

Индексийн аргачлалд заасан Индексийн эхлэлийн багцын 2024 оны 10-р сарын 22-ны өдрөөс 2026 оны 3-р сарын 04-ний өдөр хүртэлх хугацааны гүйцэтгэл, холбогдох бусад статистик мэдээллийг дараах хэсгээс харна уу.


Хүснэгт 32: Индексийн эхлэлийн багцын гүйцэтгэлтэй холбоотой ерөнхий мэдээлэл

Back-test-тэй холбоотой ерөнхий мэдээлэл	
Эхэлсэн огноо	2024/10/22
Дууссан огноо	2026/03/04
Багцыг дахин тэнцвэржүүлэх давтамж	Хагас жил тутам

№	Үзүүлэлт	Индекс ийн багц	QQQ	SPY
1	Багцын өгөөж	27.54%	14.54%	12.11%
2	Стандарт хазалт	20.12%	21.63%	17.70%
3	Сөрөг өгөөжийн стандарт хазалт	12.63%	13.76%	11.33%
4	Шарп харьцаа	1.17	0.49	0.46
5	Сортино харьцаа	1.86	0.77	0.72
6	Хамгийн өндөр уналт	-20.26%	-23.30%	-19.21%

Эх сурвалж: Индексийн back-test-ийн үр дүн

Зураг 34: Индексийн багц болон АНУ-ын хувьцааны зах зээлийн голлох индексийг дагадаг ETF-ийн үр дүн



Эх сурвалж: Индексийн back-test-ийн үр дүн

2026 оны 3-р сарын 04-ний өдрийн байдлаар Индексийн эхлэлийн багц дахь ETF-үүд нь давхардаагүй тоогоор нийт 804 тооны компанийн хувьцааг эзэмшиж байгаа эдгээрээс хамгийн их хувийн жин эзэлж буй дараах 20 компанийн хувьцаа нь нийт багцын 27.4%-ийг бүрдүүлж байна.

Хүснэгт 33: Индексийн эхлэлийн багц дахь ETF-үүдийн хамгийн өндөр дүнгээр эзэмшиж буй хувьцаа

Тикер	Компанийн нэр	Индексэд эзлэх хувийн жин	Тикер	Компанийн нэр	Индексэд эзлэх хувийн жин
NVDA	NVIDIA Corporation	3.70%	WMT	Walmart Inc.	1.03%
AAPL	Apple Inc.	2.45%	XOM	Exxon Mobil Corporation	1.01%
MSFT	Microsoft Corp	2.02%	PLTR	Palantir Technologies Inc.	0.95%
AVGO	Broadcom Inc.	1.69%	CSCO	Cisco Systems, Inc.	0.86%
AMZN	Amazon.com Inc.	1.63%	NFLX	Netflix, Inc.	0.83%
TSLA	Tesla Inc.	1.44%	AMAT	Applied Materials, Inc.	0.77%
META	Meta Platforms Inc.	1.35%	LRCX	Lam Research Corporation	0.77%
GOOGL	Alphabet CL A CMN	2.31%	CVX	Chevron Corporation	0.77%
MU	Micron Technology, Inc.	1.28%	COST	Costco Wholesale Corporation	0.77%
AMD	Advanced Micro Devices, Inc.	1.04%	INTC	Intel Corporation	0.70%

Эх сурвалж: Индексийн back-test-ийн үр дүн

Түүнчлэн, 2026 оны 3-р сарын 04-ний өдрийн байдлаар Индексийн эхлэлийн багц дахь ETF-үүдийн эзэмшиж буй компанийн хувьцаа нь дараах эдийн засгийн салбарт тараан байршсан байна.

Хүснэгт 34: Индексийн эхлэлийн багц дахь ETF-үүдийн эзэмшиж буй хувьцааны эдийн засгийн салбарын тараан байршуулалт

Салбар	Индексэд эзлэх хувийн жин
Мэдээллийн технологи	31.05%
Харилцаа холбоо	6.67%
Эрүүл мэнд	5.10%
Санхүү	4.26%
Үл хөдлөх хөрөнгө	1.93%
Тансаг хэрэглээ	7.24%
Өргөн хэрэглээ	4.66%
Аж үйлдвэрлэл	14.77%
Материал, уул уурхай	12.14%
Түлш, эрчим хүчний салбар	7.73%
Дэд бүтэц / Нийтийн үйлчилгээ	4.27%

Эх сурвалж: Индексийн back-test-ийн үр дүн

3.3.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

■ ХОС-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо

ХОС-ийн Эрсдэлийн удирдлагын журамд зааснаар ХОМК нь ХОС-ийн эрсдэлийн удирдлагын зохистой бөгөөд үр дүнтэй тогтолцоо, үйл ажиллагааны дарааллыг бүрдүүлнэ. ХОС нь эрсдэлийн



үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд дараах хамгаалалтын гурван шугамт тогтолцоог бүрдүүлж ажиллана.

БҮРТГЭВ-03

Зураг 35: ХОС-ийн эрсдэлийн удирдлагын гурван давхар хамгаалалтын шугам болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо



Нэгдүгээр шугамын хамгаалалтыг хэрэгжүүлэгч нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх байх ба эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ ХОС-ийн Бодлогын баримт бичиг, Эрсдэлийн удирдлагын журамд хөрөнгө оруулалтын зөвлөхийн бэлтгэхээр заасан судалгаа, шинжилгээ, тооцооллыг бэлтгэн, холбогдох этгээдэд тогтоосон хугацаанд, шаардлагатай тохиолдолд тухай бүр илгээх, танилцуулах, ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээдээс өгөгдсөн чиглэлийн хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- ✓ Эрсдэлийн удирдлагын хоёр болон гуравдугаар шугамыг хэрэгжүүлэгчээс өгсөн чиглэлийн дагуу холбогдох эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- ✓ ХОС-ийн Эрсдэлийн удирдлагын журамд заасан бусад эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.

Хоёрдугаар шугамын хамгаалалтыг хэрэгжүүлэгч нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээд болон ХОМК-ийн эрсдэлийн удирдлагын нэгж байх ба эдгээр нь эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь Хөрөнгө оруулалтын зөвлөхийн бэлтгэсэн судалгаа шинжилгээ, ХОМК-ийн Эрсдэлийн удирдлагын нэгжийн бэлтгэсэн эрсдэлийн үнэлгээний тайлан болон өөрсдийн бие даасан үнэлэлт дүгнэлтэд үндэслэн тухайн эрсдэлийн хүчин зүйлийн хувьд баримтлах эрсдэлийн удирдлагын стратеги, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;
- ✓ ХОМК-ийн Эрсдэлийн удирдлагын нэгж нь Хөрөнгө оруулалтын зөвлөхийн бэлтгэсэн судалгаа шинжилгээний тайлантай танилцаж, нягтлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд өөрийн бие даасан, хараат бус эрсдэлийн дүгнэлтийг тогтоосон хугацаанд болон шаардлагатай тохиолдолд тухай бүр гарган ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд хүргүүлэх, танилцуулах;
- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь Хөрөнгө оруулалтын зөвлөхийн бэлтгэсэн судалгаа шинжилгээ, ХОМК-ийн Эрсдэлийн удирдлагын нэгжийн бэлтгэсэн эрсдэлийн дүгнэлт болон өөрсдийн бие даасан үнэлэлт дүгнэлтэд үндэслэн ХОС-ийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нарийвчилсан чиглэлийг тодорхойлох;
- ✓ Хөрөнгө оруулалтын зөвлөхийн зүгээс авч хэрэгжүүлж буй эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээдээс өгөгдсөн чиглэлийн хүрээнд байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;
- ✓ ХОС-ийн Эрсдэлийн удирдлагын журамд заасан бусад эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.

2026-07-20



Гуравдугаар шугамын хамгаалалтыг хэрэгжүүлэгч нь ХОС-ийн ТУЗ байх ба эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ ХОМК-ийн зүгээс ХОС-ийн эрсдэлийн удирдлагын хүрээнд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавих, ХОС-ийн эрсдэлийн аппетитийн баримт бичиг, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
 - ✓ ХОС-ийн Эрсдэлийн удирдлагын журамд заасан бусад эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.
- **ХОС-ийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшин буюу эрсдэлийн аппетитийг тодорхойлох**

ХОС нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн аппетитийн арга хандлага (Risk appetite Framework)-ыг баримтална. ХОМК нь ХОС-ийн Эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд ХОС-ийн эрсдэлийн аппетитийн багц баримт бичгийг боловсруулан, батлах бөгөөд энэхүү баримт бичигт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах үндсэн үзүүлэлтүүдийн талаар тусгагдана.

- **Эрсдэлийн аппетит (Risk appetite)** гэж ХОС стратегийн зорилго, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд тухайлсан эрсдэл бүрийн хувьд хүлээхэд бэлэн байгаа эрсдэлийн түвшнийг тодорхойлсон ойлголт болно.
- **Эрсдэлийн аппетитийн баримт бичиг (Risk appetite statement)** гэж ХОС-ийн хүлээхэд бэлэн байгаа эрсдэлийн дээд, доод түвшин, түүнийг хэмжих үзүүлэлтийг тодорхойлсон баримт бичгийг тодорхойлсон ойлголт болно.
- **ХОС-ийн хүлээж буй эрсдэлийн түвшин (Risk exposure)** гэж эрсдэлийн үнэлгээ хийх үеийн байдлаар тухайн үзүүлэлтийн хувьд ХОС-ийн хүлээж буй эрсдэлийг тодорхойлсон ойлголт болно.
- **Эрсдэлийн үзүүлэлт (Risk Indicator)** гэж ХОС-ийн эрсдэлийн түвшин, түүний өөрчлөлтийн чиг хандлагыг хэмжих зорилгоор ашиглагдах үзүүлэлтийг тодорхойлсон ойлголт болно.

ХОМК нь ХОС-ийн тухайн хугацаанд хүлээж буй эрсдэлийн түвшнийг тодорхойлохдоо ХОС-ийн Эрсдэлийн удирдлагын журам болон холбогдох бусад дотоод журмыг баримтална.

ХОС-ийн эрсдэлийн аппетитийн түвшин ХОС-ийн хүлээж буй эрсдэлийн түвшинд үндэслэн авч хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын арга хэмжээ:

- ХОС-ийн хүлээж буй эрсдэлийн түвшин нь эрсдэлийн аппетитийн хязгаараас доогуур түвшинд байгаа тохиолдолд тухайн эрсдэлийг тохиромжтой түвшинд байна гэж үзнэ;
- ХОС-ийн хүлээж буй эрсдэлийн түвшин нь эрсдэлийн аппетитийн хязгаарт хүрсэн болон/эсхүл давсан тохиолдолд Хөрөнгө оруулалтын зөвлөх болон/эсхүл ХОМК-ийн Эрсдэлийн удирдлагын нэгж нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ХОС-ийн Эрсдэлийн удирдлагын журамд заасны дагуу ХОС-д учирч болзошгүй эрсдэлүүд, түүний тодорхойлолт, хэмжих үзүүлэлт болон ХОС-ийн эрсдэлийн удирдлагын зарчим зэрэг нь дараах байдалтай байна. Үүнд,



2026.05.09
Хүснэгт-35: ХОС-д учирч болзошгүй эрсдэл, түүний тодорхойлолт, эрсдэлийг хэмжих
эрсдэлийн удирдлагын зарчим
БҮРТГЭВ-03

Эрсдэл, түүний тодорхойлолт

Эрсдэлийн үзүүлэлт болон эрсдэлийн удирдлага

Индекс дагалтын эрсдэл (Tracking risk): ХОС нь үйл ажиллагааны явцад зайлшгүй үүсэх бэлэн мөнгөний урсгал, төлбөр тооцооны хугацааны зөрүү болон бусад үйл ажиллагааны хүчин зүйлсээс үүдэн менежментийн үйлчилгээний төлбөр болон бусад зардлыг тооцохоос өмнөх өгөөжийн гүйцэтгэлээр Индексийн гүйцэтгэлээс зөрүүтэй байх эрсдэлийг Индекс дагалтын эрсдэл гэнэ.

Индексийн буюу зах зээлийн эрсдэл гэдэг нь ХОС-ийн дагаж буй Индексийн багц буюу ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын үнэлгээ нь дэлхийн макро эдийн засаг, мөнгөний бодлогын өөрчлөлт, хөрөнгө оруулагчдын хандлага, зах зээлийн нийт уналт, системчилсэн хүчин зүйлсээс шалтгаалан буурах эрсдэлийг хэлнэ.

ХОС-ийн хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэл гэдэг нь ХОС Бодлогын баримт бичигтээ заасан хөрөнгө оруулалтын дараах хэрэгслүүдэд хөрөнгө оруулахтай холбоотойгоор үүсэх эрсдэлүүдийг хэлнэ.

- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхэд хөрөнгө оруулахтай холбоотой эрсдэл;
- ✓ Ашигт малтмалын бүтээгдэхүүнд суурилсан хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхэд хөрөнгө оруулахтай холбоотой эрсдэл;
- ✓ Гадаад улсын болон Монгол Улсын Засгийн газраас гаргасан богино хугацаатай

Эрсдэлийн үзүүлэлт: ХОС нь Индекс дагалтын эрсдэлийн түвшнийг үнэлж, хянах зорилгоор дараах эрсдэлийн үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар тооцож, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Дагалтын зөрүү (Tracking Difference, TD);
- ✓ Дагалтын хэлбэлзэл (Tracking Error, TE).

Эрсдэлийн удирдлага: ХОС нь Индекс дагалтын эрсдэлийг хянах, боломжит хэмжээнд удирдах хүрээнд дээрх эрсдэлийн үзүүлэлтүүдийн хүрээнд эрсдэлийн аппетитийн дээд түвшин буюу хязгаарыг тодорхойлж, тогтмол хяналт тавьж ажиллана.

Эрсдэлийн үзүүлэлт: ХОС нь зах зээлийн эрсдэлийн түвшнийг үнэлж, хянах зорилгоор дараах эрсдэлийн үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар тооцно. Үүнд:


- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын өгөөжийн хэлбэлзэл (Volatility): ХОС-ийн өгөөж тодорхой хугацаанд хэр зэрэг савлаж буйг хэмжих үзүүлэлт;
- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын бета буюу хувьцааны зах зээлтэй хамааралтай байдал: ХОС-ийн өгөөж зах зээлийн хөдөлгөөнд ямар хэмжээтэй хариу үзүүлж байгааг илэрхийлдэг хамаарал, мэдрэг байдлын коэффициент үзүүлэлт;
- ✓ Эрсдэлийн үнэлгээ буюу Value-at-Risk (VaR): Тодорхой хугацаанд, урьдчилан тогтоосон магадлалын түвшинд ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцад үүсэж болзошгүй хамгийн дээд алдагдлын хэмжээг тодорхойлох үзүүлэлт;
- ✓ Нөхцөлт эрсдэлийн үнэлгээ буюу Conditional Value-at-Risk (CVaR): Тодорхой хугацаанд, тогтоосон магадлалын түвшинд VaR-ээс дээш төлөвт шилжсэн үед ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцад үүсэж болзошгүй алдагдлын дундаж хэмжээг тодорхойлох эрсдэлийн үзүүлэлт.

Эрсдэлийн удирдлага: ХОС нь Индексийг дагах буюу идэвхгүй хөрөнгө оруулалтын стратеги бүхий ХОС тул энэхүү эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй боловч тус эрсдэлийн хүрээнд дээрх үзүүлэлтүүдийг тооцон, хянаж, ил тод мэдээлнэ.

Эрсдэлийн үзүүлэлт: ХОС нь хөрөнгө оруулалтын хэрэгсэлтэй холбоотой эрсдэлийн түвшнийг үнэлж, хянах зорилгоор дараах эрсдэлийн үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар тооцно. Үүнд:

- ✓ Тухайн үнэт цаасны өгөөжийн жилийн хэлбэлзэл;
- ✓ Тухайн үнэт цаасны хувьцааны зах зээлтэй хамааралтай байдал буюу бета үзүүлэлт;
- ✓ Тухайн үнэт цаасны ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц дахь бусад үнэт цаастай хамааралтай байдал;
- ✓ Тухайн үнэт цаасны ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцад үзүүлэх нөлөөлөл.

Эрсдэлийн удирдлага: ХОС нь Индексийг дагах буюу идэвхгүй хөрөнгө оруулалтын стратеги бүхий ХОС тул энэхүү эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй боловч тус эрсдэлийн хүрээнд дээрх үзүүлэлтүүдийг тооцон, хянаж, ил тод мэдээлнэ.



2026-07-20

үнэт цаас олон улсын
санхүүгийн байгууллагаас
гаргасан богино хугацаатай
үнэт цаасанд хөрөнгө
оруулахтай холбоотой эрсдэл.

СЭХ
2026-07-09
БҮРТГЭВ
№ 01

Хөрвөх чадварын эрсдэлийг
ХОС-ийн суурь үнэт цаасны багцын
хөрвөх чадварын эрсдэл болон
ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах
зээлийн хөрвөх чадварын эрсдэл
гэж ангилж үзнэ. Үүнд дараах дэд
эрсдэлүүд хамаарна.

- ✓ ХОС-ийн суурь үнэт цаасны багцын хөрвөх чадварын эрсдэл
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн хөрвөх чадварын эрсдэл

■ **Эрсдэлийн үзүүлэлт:** ХОС нь суурь үнэт цаасны багцын хөрвөх чадварын эрсдэл болон ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн хөрвөх чадварын эрсдэлийн түвшнийг үнэлж, хянах зорилгоор дараах эрсдэлийн үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар тооцно. Үүнд:

- ✓ Суурь үнэт цаасны эргэц: ХОС-ийн суурь үнэт цаасны багцын үнэт цаас бүрийн арилжигдсан үнийн дүнг нийт гаргасан үнэт цаасны тоонд харьцуулсан үзүүлэлт;
- ✓ Суурь үнэт цаасны багцын арилжааны дүн: ХОС-ийн суурь үнэт цаасны багцыг бүрдүүлж буй нийт үнэт цаасны хоёрдогч зах зээлд арилжигдсан нийт хэмжээ, үнийн дүн;
- ✓ Суурь үнэт цаасны багцын авах, зарах захиалгын үнийн зөрүү: ХОС-ийн суурь үнэт цаасны багцыг бүрдүүлж буй нийт үнэт цаасны хувьд зах зээлд оролцогчдын ирүүлсэн хамгийн их авах болон зарах захиалгын үнийн зөрүүний дундаж үзүүлэлт (Average bid-ask spread);
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн авах, зарах захиалгын үнийн зөрүү: ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд оролцогчдын ирүүлсэн хамгийн их авах болон зарах захиалгын зөрүү үзүүлэлтийг ойлгоно;
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн нээлттэй захиалгын дүн: Хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн арилжааны үеийн нээлттэй захиалгын нийт хэмжээ, үнийн дүн;
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн болон суурь үнэт цаасны багцын арилжааны үнийн дүнгийн харьцуулсан үзүүлэлт: ХОС-ийн нэгж эрхийн арилжааны дүнг суурь үнэт цаасны багцад байгаа нийт үнэт цаасны арилжааны дүнд харьцуулсан харьцаа.
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн болон суурь үнэт цаасны багцын авах, зарах захиалгын үнийн зөрүүг харьцуулсан үзүүлэлт: ХОС-ийн нэгж эрх болон суурь үнэт цаасны багцад байгаа нийт үнэт цаасны авах, зарах үнийн зөрүү.

■ **Эрсдэлийн удирдлага:** ХОС нь Индексийг дагах буюу идэвхгүй хөрөнгө оруулалтын стратеги бүхий ХОС тул энэхүү эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй боловч тус эрсдэлийн хүрээнд дээрх үзүүлэлтүүдийг тооцон, хянаж, ил тод мэдээлнэ.

■ **Эрсдэлийн үзүүлэлт:** ХОС нь валютын ханшийн эрсдэлийн түвшнийг үнэлж, хянах зорилгоор дараах эрсдэлийн үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар тооцно. Үүнд:


- ✓ Цэвэр валютын эрсдэл (Net foreign currency exposure): ХОС-ийн нийт хөрөнгө оруулалтын багцын хэдэн хувь нь гадаад валютаар илэрхийлэгдэж байгааг илэрхийлэх үзүүлэлт.

■ **Эрсдэлийн удирдлага:** ХОС нь Индексийг дагах буюу идэвхгүй хөрөнгө оруулалтын стратеги бүхий ХОС тул энэхүү эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй боловч тус эрсдэлийн хүрээнд дээрх үзүүлэлтийг тооцон, хянаж, ил тод мэдээлнэ.

Валютын ханшийн эрсдэл гэж ХОС-ийн хөрөнгө оруулалт гадаад валютаар (АНУ-ын доллар) хийгдсэн боловч нэгж эрхийн үнэлгээ төгрөгөөр илэрхийлэгдэхтэй холбоотойгоор USD/MNT ханшийн хэлбэлзлээс үүдэн ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэлгээ болон өгөөж буурах эрсдэлийг ойлгоно.

Үйл ажиллагааны эрсдэл гэж дотоод үйл ажиллагааны процессын зохион байгуулалт, хүний хүчин зүйл, технологи, загварчлалын найдвартай байдал болон хууль эрх зүйн хэрэгжилттэй холбоотойгоор

■ **Хууль эрх зүй, зохицуулалтын орчны эрсдэл** гэж ХОС-ийн үйл ажиллагаандаа мөрддөг хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, заавар, стандарт өөрчлөгдсөнөөс үүдэн ХОС-ийн үйл ажиллагаа саатах, зардал өсөх, хөрөнгө оруулалтын стратеги, өгөөж, эсхүл хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг ойлгоно. ХОМК нь энэхүү эрсдэлийг удирдах боломжгүй



85

ХОС алдагдал хүлээх эрсдэлийг
ойлгох ба дараах дэд эрсдлүүд
хамаарна

БҮРТГЭВ-03

- ✓ Хууль эрх зүй, зохицуулалтын орчны эрсдэл;
- ✓ ХОС-ийн дотоод үйл ажиллагаатай холбоотой процессын эрсдэл;
- ✓ Модел, загварчлалын эрсдэл;
- ✓ Кастодиан, түүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- ✓ Мэргэжлийн оролцогч, түүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл.

бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, заавар, стандартын хэрэгжилтийг хангах замаар хууль эрх зүй, зохицуулалтын орчны эрсдэлийн нөлөөллийг бууруулахыг зорьж ажиллана.

■ **ХОС-ийн дотоод үйл ажиллагаатай холбоотой процессын эрсдэл** гэж ХОС-ийн нэгж эрх гаргах, буцаан авах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, арилжаа, тайлагнал, мэдээллийн бүртгэл, дотоод хяналт зэрэг дотоод үйл ажиллагааны сул зохион байгуулалт, хяналтгүй байдлаас үүдэн ХОС болон хөрөнгө оруулагчдад алдагдал, хохирол учрах эрсдэлийг ойлгоно. ХОМК нь энэхүү эрсдэлийг дараах байдлаар удирдахыг зорьж ажиллана. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын зөвлөх нь ХОС-ийн дотоод үйл ажиллагаатай холбоотой процессын шинэчлэлт, сайжруулалтыг хэрэгжүүлж ажиллах;
- ✓ ХОМК-ийн Дотоод хяналтыг хэрэгжүүлэгч этгээд болон Эрсдэлийн удирдлагын нэгж болон эрх бүхий этгээдүүд нь ХОС-ийн дотоод үйл ажиллагааны процессын зохион байгуулалт, үр ашигт байдалд тогтмол хяналт тавьж ажиллах.

■ **Модел, загварчлалын эрсдэл** гэж ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр, хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн хэмжилт, өгөөжийн тооцоог тодорхойлох үйл явцад ашиглаж буй математик загвар, алгоритм, стратеги нь алдаатай үр дүн гаргасны улмаас ХОС болон хөрөнгө оруулагчийн өгөөжид сөргөөр нөлөөлөх эрсдэлийг ойлгоно. ХОМК нь энэхүү эрсдэлийг дараах байдлаар удирдахыг зорьж ажиллана. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын зөвлөх нь боловсруулсан математик загвар, моделийг тооцоолох арга аргачлал, тус загварын хязгаарлалт, тестийн үр дүн болон бусад мэдээллийг агуулсан баримт бичгийг бэлтгэн, ХОС-ийн шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд танилцуулах ба тус этгээдээс зөвшөөрсөн загварыг холбогдох хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлнэ.
- ✓ ХОМК-ийн Эрсдэлийн удирдлагын нэгж нь ХОС-ийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа аливаа модель, загварчлал нь алдааны хүлээн зөвшөөрөгдөх түвшинд үр ашигтай ажиллаж байгаа эсэхийг тогтмол хугацаанд шалган баталгаажуулна.

■ **Кастодиан, түүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл** гэж ХОС-ийн хөрөнгө хадгалалт, бүртгэл, төлбөр тооцоо, мэдээллийн дамжуулалт болон тайлагналын үйл явцад Кастодианаас үүдэлтэй системийн тасалдал, алдаа, мэдээллийн аюулгүй байдлын зөрчил үүсэх зэрэг нь ХОС болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг ойлгоно. ХОМК нь энэхүү эрсдэлийг дараах байдлаар удирдахыг зорьж ажиллана. Үүнд:

- ✓ Кастодиан нь ХОС-тай байгуулсан Хөрөнгө хадгалах гэрээний хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа эсэх, Кастодианаас илгээсэн тайлан мэдээлэл, тооцоолол нь үнэн зөв эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах;
- ✓ Хууль болон эрх бүхий байгууллагын журамд заасны дагуу Кастодианыг солих үндэслэл бий болсон тохиолдолд тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

■ **Мэргэжлийн оролцогч, түүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл:** Мэргэжлийн оролцогч нь ХОС-тай байгуулсан Мэргэжлийн оролцогчийн гэрээгээр тохиролцсон үүргээ хэрэгжүүлэхгүй байх эсхүл Хорооноос Мэргэжлийн оролцогчид тавих шаардлагыг хангахгүй болсны улмаас ХОС-ийн нэгж эрхийн хөрвөх чадвар буурах болон/эсхүл ХОС-ийн нэгж эрхийн зах

2026-07-20

БҮРТГЭВ-03

СХХ
2026.07.09 өдөр
Бүртгэв
№ 01

зээлийн үнэ буурах эрсдэлийг ойлгоно. ХОМК нь энэхүү эрсдэлийг дараах байдлаар удирдахыг зорьж ажиллана. Үүнд:

- ✓ Нэгээс дээш тооны Мэргэжлийн оролцогчтой хамтран ажиллах;
- ✓ Мэргэжлийн оролцогчийн гэрээнд заасны дагуу түүний зах зээл үүсгэх үйл ажиллагаанд холбогдох хяналтыг тавьж ажиллах;
- ✓ Мэргэжлийн оролцогчтой мэдээлэл солилцох тогтолцоог бий болгон ажиллах.

- **Аудитын байгууллага, түүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл:** Аудитын байгууллагаас бие даасан, хараат бус, мэргэжлийн түвшинд аудит хийхгүй байх, аудитын чанар хангалтгүй байх, аудитын тайлангийн хоцролт болон буруу үнэлгээ өгөхөөс үүдэн ХОС-ийн санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хөрөнгө оруулагчдын итгэл, эрх бүхий байгууллагын шаардлагын биелэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг ойлгоно. ХОМК нь энэхүү эрсдэлийг дараах байдлаар удирдахыг зорьж ажиллана. Үүнд:

- ✓ Хорооноос холбогдох зөвшөөрөл авсан, туршлагатай, олон улсын стандартад нийцэн ажилладаг аудитын байгууллага сонгох;
- ✓ Аудитын гэрээнд хугацаа, хариуцлага, чанарын шалгуурыг тодорхой тусгах;
- ✓ Жил бүр аудитын байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх, шаардлагатай бол солих шийдвэр гаргах;
- ✓ Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хянах;
- ✓ Хорооны шаардлагатай нийцсэн давхар хяналтын механизм нэвтрүүлж ажиллах.


- **ХОМК, түүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл:** ХОМК-ийн удирдлагын чадавх, мэргэжлийн түвшин, хүний нөөц, дотоод хяналт, мэдээллийн систем, эрх зүйн болон зохицуулалтын шаардлагын биелэлт, санхүүгийн тогтвортой байдлаас шалтгаалан ХОС-ийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, үйл ажиллагаа тасалдах эрсдэлийг ойлгоно. ХОМК нь энэхүү эрсдэлийг дараах байдлаар удирдахыг зорьж ажиллана. Үүнд:

- ✓ ХОМК-ийн үйл ажиллагаанд тавих дотоод болон гадаад хяналтыг тогтмол хэрэгжүүлэх;
- ✓ Удирдлагын багийн мэргэжлийн ур чадвар, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах бодлого баримтлах;
- ✓ Дотоод хяналт, эрсдэлийн менежментийн тогтолцоог бүрдүүлж ажиллах;
- ✓ Мэдээллийн технологийн системийн найдвартай ажиллагааг хангах бодлого, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

- **Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл:** ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, арилжааны мэдээлэл, хөрөнгийн бүртгэл, нэгж эрх эзэмшигчийн мэдээлэл, системийн өгөгдөл болон гуравдагч талд хадгалагдсан мэдээлэл цахим халдлага, техникийн саатлаас үүдэн алдагдах, улмаар ХОС-ийн үйл ажиллагаа доголдох, хөрөнгө оруулагчид хохирол учрах эрсдэлийг ойлгоно. Энэхүү эрсдэлийг удирдах хүрээнд ХОМК-ийн авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.

3.3.5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ОРЛОГО ХУВААРИЛАХ ЖУРАМ

ХОС-ийн хөрөнгөөс ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой харилцааг ХОС-ийн Орлого хуваарилах журмын хүрээнд зохицуулах бөгөөд тус журамд ХОС-ийн



87

87

2026-09-09
БҮРТИЗЭВ-03

2026-09-09
БҮРТИЗЭВ

баримтлах ногдол ашиг хуваарилалтын зарчим, бодлого, шийдвэр гаргалтын журам, ногдол ашиг хуваарилах хэлбэрийг тодорхойлох болон ногдол ашиг хуваарилахтай холбоотой бусад харилцааг тусгасан.

ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах зарчим: ХОС нь нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- ХОС нь хөрөнгө оруулалтаас бий болох өгөөжийг хуримтлуулах, дахин хөрөнгө оруулалт хийх замаар ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцыг нэмэгдүүлж, нийлмэл өгөөжийн үр нөлөөг бий болгох зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах бөгөөд ХОС-ийн үндсэн хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлэх хүрээнд чөлөөт мөнгөн урсгал хязгаарлагдмал байх тохиолдолд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу үйл ажиллагаа явуулах хугацаанд ногдол ашиг зарлахгүй байж болно.
- ХОС нь дор дурдсан нөхцөлүүд бүрдсэн тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
 - ✓ Ногдол ашиг төлсний дараа ХОС төлбөрийн чадвартай байх;
 - ✓ Ногдол ашиг төлсний дараа ХОС-ийн эздийн өмчийн хэмжээ нь ХОС-ийн Дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, ХОС-ийн татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
 - ✓ Ногдол ашиг хуваарилсны дараа ХОС нь холбогдох хууль, журмын дагуу тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцааг хангаж байх.
- ХОС нь нэг төрлийн нэгж эрхэд адил хэмжээний ногдол ашиг хуваарилах бодлогыг баримтална.
- ХОС нь өөрийн эргүүлэн худалдаж авсан нэгж эрхэд ногдол ашиг хуваарилахгүй.
- ХОС-ийн ногдол ашиг хуваарилах боломжтой орлого нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үр дүнд бий болсон тайлант жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан татварын дараах цэвэр ашгийн дүнгээс хөрөнгө оруулсан хөрөнгө оруулалтын хэрэгслийн үнэ цэний өсөлтөөс үүссэн, хэрэгжээгүй өгөөж, орлого, олз гэх мэт бусад хэрэгжээгүй дүнг хассан дүн байна.

ХОС-ийн ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргалт: ТУЗ нь нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш хуанлийн 50 хоногийн дотор гаргах ба үүнтэй холбоотой дараах зохицуулалтыг баримтална.

- ✓ ТУЗ нь нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ талаар түүний үндэслэлийн хамт ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд танилцуулна.
- ✓ ТУЗ нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох тогтоол, шийдвэртээ нэгж эрх бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тусгасан байна.
- ✓ ТУЗ нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашиг тараах өдрийг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор байхаар тогтооно.

Ногдол ашиг хуваарилах хэлбэр: ТУЗ нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол үндэсний мөнгөн тэмдэгт буюу төгрөг, бэлэн мөнгө эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

Уг журамд заасны дагуу, ХОС-ийн ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт заасан хугацаанд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашгийг шилжүүлнэ. Түүнчлэн, эрх бүхий этгээдийн холбогдох шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн нэгж эрх эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн ХОС ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй. Ногдол ашгаа аваагүй нэгж эрх эзэмшигчдэд анхны шаардлагаар ногдол ашгийг олгоно.



2026-07-09
БҮРТГЭЛЭГ

УЗЛ
2026-07-09 өдөр
БҮРТГЭЛЭГ

ХОС-ийн нэгж эрх эзэмшигчид ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, тогтоол гарсан өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн нэгж эрхийг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрхийг тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн шийдвэр, тогтоолд заасан бүртгэлийн өдрийн байдлаарх нэгж эрх эзэмшигч эдэлнэ.



ХОС-г татан буулгах үйл ажиллагаа нь ХОС-г Татан буулгах үйл ажиллагааны журмын дагуу явагдах ба тус журам нь Хөрөнгө оруулалтын санг татан буулгах үндэслэлийг тодорхойлох, ХОС-г татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ХОС-г татан буулгасан тохиолдолд ХОС-ийн хөрөнгийг гишүүдэд хуваарилах, татан буулгах үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулна.

ХОС-г татан буулгах үндэслэл

ХОС-г татан буулгах үйл ажиллагааны журамд заасны дагуу ХОС-г дараах тохиолдолд татан буулгана. Үүнд:

- ✓ ХОС-ийн Дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;
- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаас ХОС-г сайн дурын үндсэн дээр хугацаанаас нь өмнө татан буулгахаар шийдвэрлэсэн;
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу ХОМК нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг заавал зарлан хуралдуулах нөхцөл үүссэн бөгөөд тус нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар ХОС-г татан буулгах тухай дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргасан;
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан буюу ХОС-ийн Татан буулгах үйл ажиллагааны журамд заасны дагуу онцгой нөхцөл байдал үүссэн бөгөөд албадан татан буулгах шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;
- ✓ ХОС дампуурсан;
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо бүртгэснээс хойш 6 сар хүртэлх хугацаанд ХОС-ийн Дүрэм, Танилцуулгад заасан хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй нөхцөл бүрдсэн;
- ✓ Холбогдох хууль тогтоомж, Хороо болон бусад эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд заасан бусад.

Дээр дурдсаны дагуу ХОС-г татан буулгах үндэслэл бүрдсэн тохиолдолд ХОС-ийн Татан буулгах үйл ажиллагааны журам болон холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааврын дагуу Санг татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ХОС-ийн хөрөнгийг хуваарилах

ХОС-ийн Дүрэм болон ХОС-г татан буулгах үйл ажиллагааны журамд заасны дагуу татан буугдсан ХОС-ийн хөрөнгийг хуваарилахад дараах дарааллыг баримтална. Үүнд:

- ✓ ХОС-ийн төлөх татварын өр, төлбөр;
- ✓ ХОС-д үйлчилгээ үзүүлсэн ХОМК болон Кастодианаас бусад этгээдэд төлөх төлбөр;
- ✓ Татан буулгах үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээдэд уг ажиллагаатай холбогдох зардал буюу Хорооноос томилогдсон этгээд татан буулгах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа бол уг этгээдэд олгох ажлын хөлс;
- ✓ Хөрөнгө хадгалах гэрээний дагуу Кастодианд төлөх үйлчилгээний төлбөр;
- ✓ ХОМК-ийн үйлчилгээний төлбөр.

ХОС-ийн хөрөнгийг хуваарилсны дараа үлдсэн хөрөнгийг ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд эзэмшиж буй нэгж эрхийн хувь хэмжээтэй дүйцүүлэн олгоно.

3.3.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ БУСАД ДОТООД ЖУРАМ

ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хорооны 2025 оны 02-р сарын 25-ны өдрийн 64 дугаар бүхий тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам" болон



2026-07-20
БҮРТГЭХ

УЗХ
2026.07.09
БҮРТГЭХ

холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд нийцүүлэн ХОС-ийн Дүрэм болон холбогдох дотоод журмуудыг боловсруулсан болно.

• ХОС-ийн Дүрэм

ХОС-ийн Дүрэм нь ХОС-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагаа явуулах хугацаа болон чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага болон холбогдох бусад харилцааг тодорхойлсон үндсэн баримт бичиг болно.

ХОС нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, журам, заавар болон ХОС-ийн Дүрэм, ХОС-ийн бусад дотоод журамд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

• Нэгж эрх эзэмшигчийг бүртгэх журам

Нэгж эрх эзэмшигчийг бүртгэх журам нь Сангийн нэгж эрх эзэмшигчийг бүртгэх, бүртгэлээс хасах, нэгж эрхийн тухайлсан бүртгэл болон ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна. Тус журамд заасны дагуу, ХОС-ийн нэгж эрхийн өмчлөх эрхийн бүртгэл нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- ✓ ХОС-ийн нэгж эрхийн тухайлсан бүртгэл;
- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл.


Түүнчлэн, тус журамд дараах голлох зохицуулалтуудыг тусгасан болно. Үүнд:

- ✓ ХОС-ийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг ХОС-д үйлчилгээ үзүүлж байгаа Кастодиан хөтөлнө. Кастодиан нь ийнхүү хөтлөхдөө Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын мэдээлэлд үндэслэнэ.
- ✓ ХОМК нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн бүртгэлийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх бөгөөд энэ бүртгэл нь эцсийнх байна.
- ✓ ХОМК нь нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлийг шаардлагатай тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас гаргуулан авч болно.
- ✓ Нэгж эрх эзэмшигчийн өмчлөл дэх нэгж эрхийн тухайд номиналь эзэмшигч томилогдсон тохиолдолд тухайн нэгж эрх эзэмшигчийн бүртгэлд номиналь болон бенефициар эзэмшигчийн нэрийг давхар тусгана.
- ✓ Кастодиан нь ХОС-ийн хөрөнгө, нэгж эрхийг ХОМК болон өөрийн хөрөнгөөс тусгаарлан тусдаа дансанд бүртгэнэ.

• Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын үйл ажиллагааны журам

Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын үйл ажиллагааны журам нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг зохион байгуулах, хуралдуулах, хурлын тэмдэглэл хөтлөх, шийдвэр гаргуулах, баталгаажуулах болон нэгж эрх эзэмшигчийг мэдээллээр хангахтай холбогдсон харилцааг зохицуулна. Тус журмын голлох зохицуулалтууд дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ ХОС-ийн эрх барих дээд байгууллага болох ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.
- ✓ ТУЗ нь нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу дараа жилийн 4-р сарын 30-ны өдрийн дотор зарлан хуралдуулна. Хэрэв энэ хугацаанд нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй бол ТУЗ-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг хуралдуулахаас бусад ХОС-ийн Дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно. Түүнчлэн, ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсноос хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.



2026

ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж батална.

Үүнд:

БҮРТГЭВ-03

- ХОС-ийн жилийн үйл ажиллагааны болон аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн, батлах;
- ХОС-ийн Дүрэм, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд заасан бусад.
- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит бус хурлыг дараах тохиолдолд зарлан хуралдуулж болно. Үүнд:
 - ТУЗ-ийн санал, шаардлагаар;
 - ХОМК-ийн санал, шаардлагаар;
 - ХОС-ийн нийт гаргасан нэгж эрхийн 1 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй нэгж эрх эзэмшигчийн санал, шаардлагаар.

ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг ХОС-ийн ТУЗ, ХОС-ийн нэгж эрх эзэмшигч болон ХОМК-ийн санал, шаардлагаар хуралдуулах болон хурлын зохион байгуулалттай холбоотой нарийвчилсан харилцааг тус журмаар зохицуулна.

■ ХОС-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

ХОС-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь ХОС-ийн засаглалын дотоод баримт бичигт хамаарах бөгөөд ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт болон холбогдох бусад харилцааг зохицуулна. Тус журам дараах голлох зохицуулалтуудыг тусгасан болно. Үүнд,

- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын чөлөөт цагт ХОС-ийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байх бөгөөд түүний үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтын хэлбэр нь хурал байна.
- ✓ ТУЗ-ийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх ба ТУЗ өөрөө хурлын дэгээ тогтооно. Түүнчлэн, ТУЗ-ийн ээлжит хурлыг хагас жилд 1-ээс доошгүй удаа, ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүн болон/эсхүл ХОМК болон ХОС-ийн Дүрэмд заасан этгээдийн санал, шаардлагаар хуралдуулж болно.
- ✓ ТУЗ нь ХОС-ийн аудитын хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх үүргийн хүрээнд дэргэдээ аудитын хороотой байх бөгөөд тус хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- ✓ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг туршлага, хараат бус байдлыг зохистойгоор хангасан бүтэцтэй байна.
- ✓ ТУЗ нь дарга болон гишүүдээс бүрдэх бөгөөд хараат бус гишүүнтэй байна. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ХОС-ийн Дүрмээр тогтооно.
- ✓ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн нь холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон "Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх", "Гэмт хэрэгт холбогдох байгаагүй байх", "Бизнесийн болон ёс зүйн зөрчилгүй байх", "Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх" болон холбогдох бусад шалгуурыг хангасан байна.
- ✓ ТУЗ-ийн бүрэн эрх нь ээлжит сонгуулийн шийдвэр гарснаар эхэлж, ТУЗ-ийн дараагийн сонгуулийн өдрөөр дуусгавар болох ба түүнчлэн, ТУЗ нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй бол ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал хуралдуулахаас бусад ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болно.
- ✓ ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаатай ТУЗ-ийн даргын бүрэн эрхийн хугацаа адил байна.
- ✓ ТУЗ нь ХОС-ийн Дүрэм болон тухайн журамд заасан бүрэн эрхийг эдэлнэ.
- ✓ ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан хараат бус үйл ажиллагаа явуулах, сонирхлын зөрчил болон онцгой нөхцөл байдал үүсгэхээс сэргийлж ажиллах, өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг, ур чадвар, туршлагаа байнга дээшлүүлэх зэрэг ХОС-ийн Дүрэм, холбогдох бусад дотоод журамд заасан зарчмыг баримтлан ажиллана.
- ✓ ТУЗ-ийн дарга, гишүүн болон хараат бус гишүүн нь холбогдох хууль тогтоомж болон тус журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигч болон/эсхүл хувь хүн нь өөрийгөө ХОС-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж болох ба нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд тус журмыг баримтлан ажиллана.

ХОС-ийн ТУЗ-тэй холбогдсон бүхий л харилцааг тухайн журмаар нарийвчлан зохицуулах бөгөөд тийнхүү зохицуулагдаагүй харилцаа байх тохиолдолд холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журамд заасныг баримтална.

■ **ХОС-ийн Хяналтын үйл ажиллагааны журам**

ХОС-ийн Хяналтын үйл ажиллагааны журам нь ХОС-ийн хөндлөнгийн болон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

ХОС нь дараах зорилгын хүрээнд хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, аливаа зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх;
- ✓ Гарсан зөрчил, дутагдлыг илрүүлэх, зөвлөмж өгөх, таслан зогсоох, хариуцлага тооцох;
- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад хүргүүлж буй тайлан, мэдээлэл нь үнэн зөв, бодитой байгаа эсэхэд хяналт тавих.

Тус журамд заасны дагуу, ХОС-ийн хяналтын тогтолцоо нь дараах хяналтын төрлүүдээс бүрдэж байна. Үүнд:

- ✓ ХОМК-ийн дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээдийн хяналт;
- ✓ Кастодианы хяналт;
- ✓ Хөндлөнгийн аудитын хяналт;
- ✓ ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хяналт.

ХОС-ийн хяналтын тогтолцоо нь дараах хяналтын чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ХОС-ийн Аудитын хороо, ХОМК, Кастодиан, Аудитын байгууллагын ажилтнуудын тасралтгүй үйл ажиллагаа, түүнийг зохицуулах дүрэм, журмын цогц юм. Үүнд:

- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зорилго, стратегийг хэрэгжүүлэх хүрээнд ХОМК нь ХОС-ийн үйл ажиллагааг зохистой удирдан явуулж байгаа эсэх, Кастодиан нь ХОС-ийн хөрөнгийг хадгалах, захиран зарцуулах үйл ажиллагааны хяналтыг найдвартай, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааврын хүрээнд хэрэгжүүлж байгаа эсэхийг хянах;
- ✓ ХОС-ийн санхүүгийн тайлан, мэдээлэл нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэх, ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцад байгаа хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааврын дагуу бодитой үнэлсэн эсэхийг хянах;
- ✓ ХОС-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журмын хүрээнд тодорхойлогдсон сайн засаглалын үндсэн зарчмуудад нийцэж байгаа эсэхийг хянах;
- ✓ ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааварт нийцэж байгаа эсэхэд хяналт тавих.

ХОС-ийн хяналтын чиг үүргүүдийг хэрэгжүүлж буй этгээдүүд нь хууль дээдлэх, бие даасан, хараат бус байх, ил тод байх, шударга ёсыг хангах зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. ХОМК-ийн дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээд, Кастодиан, Хөндлөнгийн аудит болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хяналт, шалгалттай холбоотой харилцааг тус журмаар нарийвчлан зохицуулна.

■ **ХОС-ийн зардлын зүйл, түүний дээд хэмжээг тогтоох журам**



ХОС-ийн зардлын зүйл, түүний дээд хэмжээг тогтоох журмаар ХОС-ийн хөрөнгөөс гарах зардлыг ангилах, зардлын зүйлс болон тэдгээрийн дээд хэмжээг тогтоох, зардлын төсвийг батлах, түүнийг захиран зарцуулах гүйцэтгэлийг хянах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.

ХОС нь Дүрэмдээ заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарах зардал буюу тус журам болон бусад холбогдох дотоод журамд тусгагдсан зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Тус журмын голлох зохицуулалтууд дараах байдалтай байна. Үүнд,

- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т заасны дагуу ХОС-ийн ХОМК-д Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд төлөх хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний төлбөр болон Кастодианд Хөрөнгө хадгалах гэрээний дагуу төлөх холбогдох үйлчилгээний төлбөрийн жилийн нийлбэр дүн нь ХОС-ийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн 3%-аас хэтрэхгүй байна.
- ✓ ХОС нь хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр бусдад төлбөр төлөх, зардал гаргахыг хориглоно.
- ✓ Эрх бүхий этгээдээс батлагдсан ХОС-ийн зардлын дээд хэмжээнээс хэтрүүлэн зардал гаргах, мөн ХОС-ийн Дүрэм, холбогдох дотоод журмын хүрээнд тоорхойлогдсон зардлын зүйлд заагдаагүй зардал, төлбөрийг ХОС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхийг хориглоно.
- ✓ ХОС-ийн хөрөнгийг батлагдсан зардлын хязгаарлалтын хүрээнд захиран зарцуулах, түүнд хяналт тавихтай холбоотой нарийвчилсан харилцааг ХОС-ийн холбогдох дотоод журмаар зохицуулна.

■ Мэдээллийн үйл ажиллагааны журам

Мэдээллийн үйл ажиллагааны журмаар ХОС-ийн нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл болон ХОС-ийн холбогдох бусад мэдээллийг тогтоосон хугацаанд олон нийт болон эрх бүхий байгууллагад хүргэх, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулна.


ХОС нь мэдээллийн үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- ✓ Мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд байх;
- ✓ Агуулгын хувьд хоёрдмол утгагүй, ойлгомжтой, тодорхой байх;
- ✓ Мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй хүргэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх;
- ✓ Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад.

ХОС нь дараах төрлийн мэдээ, мэдээллийг цуглуулан, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журмын хүрээнд хөрөнгө оруулагч, харилцагч, олон нийтэд болон эрх бүхий байгууллагад дамжуулна. Үүнд:

- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл, танилцуулга, ТУЗ, бусад оролцогч талуудын мэдээлэл;
- ✓ ХОС-ийн нэгж эрхийн 5 ба түүнээс дээш хувийг эзэмшигчийн талаарх мэдээлэл, түүний өмчлөл дэх нэгж эрхийн нэгж эрхийн тоо, хувь;
- ✓ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журамд заасан сэжигтэй гүйлгээ, харилцагчийг мэдээлэх зорилгоор цуглуулах мэдээлэл;
- ✓ ХОС-ийн үйл ажиллагааны хүрээнд олж авсан аливаа нийтэд ил болоогүй мэдээлэл;
- ✓ ХОС-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, шийдвэр гаргалттай холбоотой мэдээлэл.

Түүнчлэн, тус журамд заасны дагуу ХОС нь шаардлагатай гэж үзвэл нэгж эрх эзэмшигчийн хүсэлтэд үндэслэн холбогдох мэдээллийг гаргаж өгч болно. Нэгж эрх эзэмшигч нь ХОС-ийн үйл ажиллагаатай холбоотой өөрт шаардлагатай мэдээллийг ХОМК-д хүсэлт гаргах, эсхүл Мэргэжлийн оролцогч, Зах зээл үүсгэгчээр дамжуулан ХОМК-аас авах боломжтой. Нэгж эрх эзэмшигч нь мэдээлэл авах хүсэлтдээ өөрийн үндсэн мэдээлэл, эзэмшиж буй нэгж эрхийн тоо, авах мэдээлэл болон авах хэлбэрийг тусган цахим шуудангаар ирүүлэх ба ХОС нь нэгж эрх эзэмшигчийн хүсэлтэд үндэслэн



2026.07.09
ХҮҮЛЬД НИЙЦСЭН, ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ЭРХИЙГ ЗӨРЧИХГҮЙ, НУУЦАД ХАМААРАХГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВСНААС ХОЙШ ХУАНЛИЙН 14 ХОНОГИЙН ДОТОР БОЛОМЖИТ ХЭЛБЭРЭЭР ОЛГОНО. МЭДЭЭЛЭЛ АЧ ХОЛБОГДЛОО АЛДАХ ЭРСДЭЛТЭЙ БОЛ БОГИНО ХУГАЦААНД ГАРГАН ӨГЧ БОЛНО. ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮҮРГИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ХАРИУЦАЖ, ТҮҮНД ХОМК-ИЙН КОМПЛАЙНСЫН АЖИЛТАН ХЯНАЛТ ТАВИНА.

ХОС-ийн мэдээллийг боловсруулах, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд заасны дагуу нээлттэй болгохоос өмнө санаатай эсхүл болгоомжгүйгээр бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэх, худал, төөрөгдүүлсэн, алдаатай эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээллийг боловсруулах, нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагч болон нийтэд мэдээлэх болон хууль тогтоомжид нээлттэй мэдээлэхээр зааснаас бусад хүний хувийн мэдээлэл болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагч болон олон нийтэд мэдээлэх, дамжуулах, ил болгох болон ХОС-ийн нэгж эрхийн үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг бэлтгэх, ил болгох, дамжуулахыг хориглоно.

■ ХОС-ийн орлогыг ХОС-ийн активт бүртгэх журам

ХОС-ийн орлогыг ХОС-ийн активт бүртгэх журмаар ХОС-ийн орлогыг хүлээн зөвшөөрөх, орлогыг сангийн активт бүртгэх журам, хугацаа, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах ба журамд дараах голлох заалтуудыг тусгасан байна. Үүнд:

- ✓ ХОС-ийн орлогыг СТОУС-д нийцүүлсэн Монгол Улсын Сангийн сайд, Хорооны даргын 2015 оны 12-р сарын 09-ний өдрийн 328/336 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар"-т үндэслэн бүртгэнэ.
- ✓ ХОС-ийн нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар хөтлөх буюу мөнгөн хөрөнгө хүлээн авсан эсхүл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон тухай бүрд нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ.
- ✓ Орлогыг хүлээн авсан мөнгө эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөгөөр бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үүссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зарлагаар хүлээн зөвшөөрнө.

■ ХОС-ийн ёс зүйн дүрэм

ХОС-ийн Ёс зүйн дүрэм нь ХОС болон түүний хөрөнгийн удирдлагыг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа ХОМК-ийн эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох ажилтнуудын ХОС-ийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож, түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

ХОС болон ХОМК-ийн эрх бүхий албан тушаалтан нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ажил, үүрэг гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, энэхүү Дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлан ажиллана. Тухайлбал,

- ✓ Холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам болон ХОС-ийн Дүрэм, холбогдох дотоод журмыг чандлан мөрдөх;
- ✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- ✓ Хувийн ашиг сонирхлоос ангид, шударга, ил тод, нээлттэй байх;
- ✓ ХОС-ийн нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэх;
- ✓ ХОС-ийн нэр хүнд, өмч хөрөнгө болон хүний хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах;
- ✓ Авлига, хээл хахууль, албан тушаалын болон аливаа гэмт хэргээс ангид байх.



2026-07-20

2026-07-20

БҮРТГЭЖ

ХОС-ийн ТУЗ-ийн дарга, гишүүн болон ХОС, ХОМК-ийн Гүйцэтгэх удирдлага, Хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь энэхүү Ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг баримтлах. ХОС-ийн ТУЗ нь энэхүү Дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн зөрчлийг шийдвэрлэх бөгөөд ТУЗ-ийн гишүүнтэй холбогдсон ёс зүйн зөрчлийг ТУЗ-ийн бусад гишүүдийн санал, шийдвэрээр шийдвэрлэнэ.

ХОС болон ХОМК-ийн эрх бүхий албан тушаалтан, ажилтны ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой харилцааг ХОС-ийн Ёс зүйн дүрмээр нарийвчлан зохицуулна.

ХОС-ийн баримт бичгийн хүчин төгөлдөр байдал

ХОС нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд баримтлах баримт бичигтээ аливаа байдлаар өөрчлөлт оруулах тохиолдолд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9-д "Хорооны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, сангийн нэгж эрхийн танилцуулгад нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгохыг хориглоно" гэж, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-т "Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан тухай бүр ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлэн ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд мэдэгдэх бөгөөд хөрөнгө итгэмжлэн удирдах журамд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Хороонд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно" гэж тус тус заасны дагуу ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, энэхүү Танилцуулга болон Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах тохиолдолд тухайн өөрчлөлтүүдийг Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр тухайн нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батална. Тийнхүү баталсан баримт бичиг нь хүчин төгөлдөр болно.



3.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮРТГЭВ 33
3.4.1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

ХОС нь үйл ажиллагаа явуулах хугацааны санхүүгийн төсөөллийг гаргахдаа дараах голлох таамаглалыг дэвшүүлсэн болно.

Хүснэгт 36: ХОС-ийн санхүүгийн төсөөллийг бэлтгэхэд ашигласан голлох таамаглал, түүний үндэслэл

Үзүүлэлт	Тооцоололд ашигласан өгөөж	Холбогдох үндэслэл
		ХОС-ийн дагах Индексийн багц нь технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтаас бүрдэж байгаа тул ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын өгөөжийг АНУ-ын технологийн голлох индекс болох Nasdaq-100 индексийн сүүлийн 10 жилийн нийлмэл өгөөж (2015-2025 CAGR)-д үндэслэн тодорхойлсон болно.
		Зураг: АНУ-ын Nasdaq-100 индексийн 10 жилийн хугацааны жилчилсэн өгөөж
Хөрөнгө оруулалтын багцын өгөөж	16.1%	 — Nasdaq-100 индексийн жилчилсэн өгөөж — Дундаж
Ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн жилийн өөрчлөлт	6.5%	2005 оноос 2025 он хүртэлх 20 жилийн хугацааны жилийн дундаж ам.долларын төгрөгтэй харьцах албан ханшийн өөрчлөлтийн статистик мэдээлэлд үндэслэв.
Үйл ажиллагаа эхлэх хугацаа	2026 оны 6 дугаар сар	ХОС нь Хороо болон Хөрөнгийн биржийн холбогдох бүртгэлд бүртгүүлж, Танилцуулгад тусгасан хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх хугацааг дараах байдлаар төлөвлөж байна.

Улмаар, ХОС-ийн орлогын тайлан болон санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл дараах байдалтай байна.

Хүснэгт 37: Үнэт цаас гаргагчийн ХОС-ийн орлогын төсөөлөл, сая төгрөг

Үзүүлэлт	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	2035	2036
Үйл ажиллагааны орлого											
Үнэт цаасны ханшийн тэгшитгэлийн олз	945	4,715	7,433	10,751	14,831	19,861	26,067	33,731	43,202	54,912	27,149
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз	402	2,210	3,484	5,039	6,952	9,309	12,218	15,811	20,250	25,739	11,969
Ногдол ашгийн орлого		213	382	588	841	1,154	1,539	2,015	2,603	3,331	4,230
Нийт үйл ажиллагааны орлого	1,347	7,138	11,298	16,378	22,625	30,324	39,824	51,557	66,055	83,981	43,348
Үйл ажиллагааны зардал											

ХОС-г үүсгэн байгуулахтай холбоотой зардал	27	-	-	-	-	-	-	-	-	-	-
Кастодианы үйлчилгээний зардал	7	30	48	71	100	135	178	231	287	378	88
Бусад үйлчилгээний зардал	9	55	73	98	124	146	170	199	231	269	94
ҮЦТХТ: Хадгалалтын үйлчилгээний зардал	1	2	2	2	2	2	2	2	2	2	1
МХБ: Жилийн үйлчилгээний хөлс	2	7	12	18	25	25	25	25	25	25	10
Индекс тооцогчид төлөх төлбөр	6	11	15	23	30	40	53	69	89	113	63
Аудитын үйлчилгээний зардал	-	3	4	5	6	7	8	10	12	14	17
Шимтгэлийн зардал	-	1	1	1	1	2	2	3	3	4	3
Маркетингийн зардал	-	30	40	50	60	70	80	90	100	110	-
Бусад зардал	-	19	23	27	33	39	47	57	68	82	71
Сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын зардал	-	10	12	14	17	21	25	30	36	43	52
ТУЗ-ийн зардал	-	9	11	13	16	19	22	27	32	39	19
Татварын зардал	-	64	114	176	252	346	462	605	781	999	1,269
ХОМК-ийн төлбөрөөс бусад нийт үйл ажиллагааны зардал	43	167	259	373	509	666	857	1,091	1,377	1,728	1,523
ХОМК-ийн менежментийн үйлчилгээний зардал	100	430	660	878	1,111	1,363	1,640	1,946	2,289	2,677	1,075
Цэвэр ашиг	1,205	6,542	10,379	15,127	21,005	28,294	37,327	48,520	62,390	79,577	40,750

Хүснэгт 38: ХОС-ийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөг

Үзүүлэлт	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	2035	2036
ХӨРӨНГӨ											
Мөнгөн хөрөнгө	17	10	10	10	10	10	10	10	10	10	461,116
Үнэт цаас	21,287	38,166	58,776	84,121	115,359	153,906	201,509	260,335	333,068	423,033	-
НИЙТ ХӨРӨНГӨ	21,305	38,176	58,786	84,131	115,369	153,916	201,519	260,345	333,078	423,043	461,116
ӨР ТӨЛБӨР											
ХОМК-д өгөх өглөг	100	430	660	878	1,111	1,363	1,640	1,946	2,289	2,677	-
Бусад өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨР	100	430	660	878	1,111	1,363	1,640	1,946	2,289	2,677	-
ЭЗДИЙН ӨМЧ											
Хувь нийлүүлсэн хөрөнгө	20,000	30,000	40,000	50,000	60,000	70,000	80,000	90,000	100,000	110,000	110,000
Хуримтлагдсан ашиг	1,205	7,747	18,126	33,253	54,258	82,552	119,879	168,400	230,789	310,366	351,116
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ /NAV/	21,205	37,747	58,126	83,253	114,258	152,552	199,879	258,400	330,789	420,366	461,116

Хүснэгт 39: ХОС-ийн мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл, сая төгрөг

Үзүүлэлт	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	2035	2036
Татварын дараах цэвэр ашиг	1,205	6,542	10,379	15,127	21,005	28,294	37,327	48,520	62,390	79,577	40,750
Ажлын капиталын өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Үнэт цаас	-21,287	-16,879	-20,610	-25,345	-31,238	-38,547	-47,604	-58,826	-72,733	-89,965	423,033
Бусад авлага	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ХОМК-д өгөх өглөг	100	330	230	218	233	252	276	306	343	388	2,677
Бусад өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-



Нийт ажлын
капиталын
өөрчлөлт

БҮРТГЭВ-03

Үйл ажиллагааны
цэвэр мөнгөн
урсгал

Шинээр татсан
хөрөнгө оруулалт

Санхүүжилтийн
цэвэр мөнгөн
урсгал

-21,188	-16,549	-20,379	-25,127	-31,005	-38,294	-47,327	-58,520	-72,390	-89,577	420,356
-19,983	-10,007	-10,000	-10,000	-10,000	-10,000	-10,000	-10,000	-10,000	-10,000	461,106
20,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	-
20,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	-

СЭХ

2026.07.09



БҮРТГЭВ

№ 11

3.4.2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨСӨӨЛӨЛ

Дээрх санхүүгийн төсөөлөлд үндэслэн тооцоолсон ХОС-ийн голлох харьцаа үзүүлэлтүүдийн төсөөлөл дараах байдалтай байна.


Хүснэгт 40: ХОС-ийн санхүүгийн тайлангийн голлох харьцаа үзүүлэлтүүдийн төсөөлөл



2026-07-20

БҮРТГЭВ-03

ХОМК болон
кастоианд төлөх
төлбөр / Дундаж
цэвэр хөрөнгө



*Жилчилсэн үзүүлэлт

ХОС-ийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ богино хугацаанд харьцангуй хэлбэлзэл өндөртэй байх магадлалтай хэдий ч хөрөнгийн зах зээл таатай байх нөхцөлд дунд болон урт хугацаанд цэвэр хөрөнгийн үнэлгээ нэмэгдэх боломжтой.



2026-09-20

БҮРТГЭВ-03

СЭХ

2026-09-20

БҮРТГЭВ

№ 1

О4

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА



101

4.2026-03-20

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

СЭХ
2026 03-20
БҮРТГЭВ

ХОС нь Дүрэмдээ заасны дагуу 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 200,000,000 ширхэг зарласан нэгж эрхтэй байх ба хөрөнгө оруулагч нарын эрэлтэд үндэслэн эргэлтэд байгаа нэгж эрхийн тоо, ширхгийг нэмэгдүүлэх эсхүл бууруулах боломжтой байна.

Хүснэгт 41: ХОС-ийн нэгж эрхийн танилцуулга

ХОС-ийн нэгж эрхийн талаарх мэдээлэл

Үнэт цаасны төрөл	■ ХОС-ийн нэгж эрх
Үнэт цаасыг санал болгох хэлбэр	■ Олон нийтэд нээлттэй хүрээнд
ХОС-ийн нэгж эрхийн нэрлэсэн үнэ	■ 1,000 төгрөг
ХОС-ийн гаргасан нэгж эрхийн тоо ширхэг	■ 1,000 ширхэг
ХОС-ийн анхдагч зах зээлд татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ ²⁹	■ 10 тэрбум төгрөг
ХОС-ийн зарласан нэгж эрхийн тоо ширхэг	■ 200,000,000 ширхэг

ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа

Нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа	■ ХОС нь нэгж эрхээ зохицуулалттай этгээд буюу Мэргэжлийн оролцогчийн эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын багцаар солих замаар хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлэх тул ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа нь зөвхөн ХОС болон Мэргэжлийн оролцогч нарын хооронд явагдана. ■ ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа нь Мэргэжлийн оролцогчтой байгуулсан Мэргэжлийн оролцогчийн гэрээний дагуу явагдана.
---	--

ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа

Нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа	■ ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа нь Хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулагдах ба ХОС-ийн нэгж эрх нь Хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалагдана. ■ Мэргэжлийн оролцогч нь хоёрдогч зах зээл дээр нэгж эрхийг эцсийн хөрөнгө оруулагчдад санал болгох ба эцсийн хөрөнгө оруулагч нь нэгж эрхийг зөвхөн мөнгөн хөрөнгөөр худалдан авна.
Нэгж эрх арилжаалагдах бирж	■ "Монголын Хөрөнгийн Бирж" ХК
Нэгж эрхийн симбол	■ FTI
Нэгж эрхийн нэр	■ Фьючер Тек Инновэйшн
Нэгж эрхийн үнэ илэрхийлэгдэх валют	■ Монгол төгрөг буюу MNT
Нэгж эрхийн хөрвөх чадвар	■ ХОС-ийн нэгж эрх нь арилжаа эрхлэх байгууллага дээр чөлөөтэй арилжаалагдана. ■ ХОС-тай Мэргэжлийн оролцогчийн гэрээг байгуулсан Мэргэжлийн оролцогч нар нь ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийг үүсгэх буюу хөрвөх чадварыг хангаж ажиллана.

²⁹ ХОС-ийн анхдагч зах зээл дээрээс татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ нь 5.0 тэрбум төгрөг байна.



ХОС нэгж эрх нэмж гаргах, буцаан авах

БҮРТГЭВ-03

ХОС нэгж эрх нэмж гаргах,
буцаан авах

- ХОС нь зөвхөн Мэргэжлийн оролцогчийн хүсэлтэд үндэслэн нэгж эрх нэмж гаргах эсхүл буцаан авах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- Мэргэжлийн оролцогч нь ХОС-ийн нэгж эрхийн эрэлт өссөн үед эрэлтийн хэмжээгээр нэгж эрхийг нэмж гаргуулах тухай хүсэлтийг, эрэлт буурсан үед буцаах хүсэлтийг хөрөнгө оруулалтын зөвлөхөд гаргана.

ХОС-ийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ

ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэлгээ

- ХОС-ийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хасаад үлдсэн хөрөнгийн дүнг ойлгоно.

ХОС-ийн нэгж эрхийн цэвэр
хөрөнгийн үнэлгээ

- ХОС-ийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ гэж тухайн өдрийн ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэлгээг ХОС-ийн эргэлтэд байгаа нэгж эрхийн тоо ширхэгт хувааж тооцсон үзүүлэлт байна.

ХОС — ийн цэвэр хөрөнгийн үнэлгээ
Эргэлтэд байгаа нэгж эрхийн тоо ширхэг

ХОС-ийн нэгж эрхийн цэвэр
хөрөнгийн үнэлгээг тооцож,
мэдээлэх хугацаа, түүний
давтамж

- ХОМК нь ХОС-ийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээг тооцоолж, ажлын өдөр бүрийн өглөөний 10 цагийн дотор ХОМК-ийн цахим хуудас болон Хөрөнгийн биржийн системээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Энэхүү үнэлгээ нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын хамгийн сүүлийн хаалтын ханшинд үндэслэнэ.

ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэлгээ
илэрхийлэгдэх валют

- Монгол төгрөг буюу MNT

4.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлд нэгж эрхийг хөрөнгө оруулалтын багцаар солилцон авсан Мэргэжлийн оролцогч болон хоёрдогч зах зээл буюу Хөрөнгийн бирж дээрээс шууд худалдан авч, нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлд бүртгүүлэн өөрийн хууль ёсны эзэмшилд шилжүүлсэн иргэн, хуулийн этгээдийг нэгж эрх эзэмшигч гэнэ. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

Хүснэгт 42: ХОС-ийн нэгж эрхээр гэрчлэгдэх эрх, үүрэг, холбогдох бусад мэдээлэл

ХОС-ийн нэгж эрхээр гэрчлэгдэх эрх, үүрэг

Нэгж эрх эзэмшигч нь дараах
эрхийг эдэлнэ

- ХОМК-аас ХОС-ийн хөрөнгийг энэхүү Дүрэм, Бодлогын баримт бичиг, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, холбогдох хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас баталсан журмын хүрээнд мэргэжлийн түвшинд удирдахыг шаардах;
- ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд өөрийн биеэр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох, хурлаар хэлэлцэж буй асуудалд өөрийн эзэмшлийн нэгж эрхийн тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- Нэгж эрхээ хоёрдогч зах зээлд худалдах;
- ХОС-аас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд өөрийн оруулсан хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн ногдол ашиг хүртэх;
- ХОС-г татан буулгах үед өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах;
- Холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, холбогдох бусад журамд заасан эрх.



103

103

2026-07-20

БҮРТГЭВ-03

СХА

2026-07-20 10:00

БҮРТГЭВ

Нэгж эрх эзэмшигч нь дараах
үүргийг хүлээнэ

- ХОС-г удирдах үйл ажиллагаа, шийдвэрт нөлөөлөх буюу үерийн гэв үйл ажиллагаанаас хараат байлгахад чиглэсэн аливаа үйлдэл, эсвэл үйлдэл гаргахгүй байх;
- Хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр эсхүл шаардлагатай тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон түүнтэй холбогдон батлагдсан журамд заасны дагуу өөрийн хувийн мэдээллийг өөрийн харилцааг УЦК, Мэргэжлийн оролцогчид үнэн зөв, бүрэн гүйцэд мэдэгдэх, мэдээлэх, гаргаж өгөх үүргээ биелүүлэх;
- ХОС-ийн Дүрэмд заасан үүргээ зөрчсөнөөс үүсэх эрх зүйн болон бусад үр дагаврыг бүрэн хариуцах;
- ХОС-ийн Дүрэм болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд идэвхтэй оролцох, нэгж эрх эзэмшигчийн үүргээ биелүүлэх.
- Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх, тайлагнах.
- Нэгж эрх эзэмших, бусдад худалдах, шилжүүлэхтэй холбоотой үнэт цаасны данс нээлгэх, арилжаа хийхтэй холбоотой зардал хариуцах.
- Холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичиг, холбогдох бусад журамд заасан үүрэг.

Нэгж эрх эзэмшигчтэй холбоотой
бусад зохицуулалт

- ХОС-ийн нэгж эрх нь ХОС-ийн хөрөнгөөс өмчлөх хувь хэмжээг гэрчлэх бөгөөд ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд нэгж эрх тус бүрээр саналын нэг эрхтэйгээр оролцох, ХОС-г татан буулгах үед өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах эрхийг гэрчилнэ.
- ХОС-ийн нэгж эрх нь ХОС-ийн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох боловч ХОС-ийн тодорхой нэг хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.
- ХОС-ийн нэгж эрх эзэмшигч нь өөрийн оруулсан хөрөнгөөрөө хязгаарлагдмал хариуцлага хүлээнэ.


ХОС-ийн нэгж эрх эзэмшигч
гишүүдийн бүртгэл

- ХОС-д үйлчилгээ үзүүлж буй Кастодиан нь ХОС-ийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтөлнө.
- ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн бүртгэлийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.
- ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийг улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй.
- ХОС-ийн нэгж эрх эзэмшигчийг бүртгэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг ХОС-ийн Дүрэм, холбогдох дотоод журмаар зохицуулна.



Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан (ETF)-ийн нэгж эрхийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа нь бусад төрлийн хөрөнгө оруулалтын сантай харьцуулахад онцлог шинж чанартай байдаг билээ. Тухайлбал, хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн анхдагч зах зээлийн арилжаанд зөвхөн хөрөнгө оруулалтын сантай гэрээ байгуулсан Мэргэжлийн оролцогч нар оролцох боломжтой ба Мэргэжлийн оролцогчоос бусад хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл дээр хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах замаар хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулагч болох боломжтой.

Зураг 36: Сангийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны зураглал



ХОС нь нэгж эрхийн анхдагч зах зээлд ХОС-ийн Дүрэм, Бодлогын баримт бичгийн дагуу зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын хэрэгслээс бүрдсэн хөрөнгө оруулалтын багцаар Мэргэжлийн оролцогчтой нэгж эрхийг солилцох замаар ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Энэхүү үйл ажиллагаатай холбоотой харилцааг ХОС-ийн Нэгж эрхийг солилцох, буцаан авах, үнийг тодорхойлох журам, Мэргэжлийн оролцогчийн гэрээгээр нарийвчлан зохицуулна. Тус гэрээ болон журамд тусгагдсан голлох заалтууд дараах байдалтай байна.

- **Нэгж эрхийн нэрлэсэн үнэ:** ХОС нь анхдагч зах зээлд нэгж эрхээ анх удаа гаргах үед нэгж эрхийн үнийг нэрлэсэн үнээр тооцох ба энэ нь ХОС-ийн Дүрэмд заасны дагуу 1.000 төгрөг байна.
- **Солилцох нэгж эрхийн тоо, ширхэг болон хөрөнгө оруулалтын багц:** Мэргэжлийн оролцогч нь Мэргэжлийн оролцогчийн гэрээнд заасан тоо ширхэг бүхий нэгж эрхийг тус гэрээнд заасан хөрөнгө оруулалтын багцаар солилцоно. Мэргэжлийн оролцогч нь тус хөрөнгө оруулалтын багцыг Кастодиан дахь ХОС-ийн дансанд шилжүүлнэ.
- **Нэгж эрхийг мөнгөн хөрөнгөөр солилцох тухай:** Мэргэжлийн оролцогч нь зах зээлийн нөхцөл байдал, санхүүгийн чадавх, хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэх хөрөнгө оруулалтын хэрэгслийн хөрвөх чадвар хангалтгүйгээс шалтгаалан ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд хөрөнгө оруулалтын багцаар солих ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх

2026

боломжгүй болсон тохиолдолд ХОС-ийн нийт нэгж эрхийн 30 хүртэлх хувийг мөнгөн б
хөрөнгөөр худалдан авч болно.

БҮРТГЭВ-03
Батаггаан

Баталгаажуулалт: ХОС болон Мэргэжлийн оролцогч нь нэгж эрхийн анхдагч зах зээл дээр нэгж эрхийг хөрөнгө оруулалтын багцаар солилцох даалгавар, холбогдох өмчлөх эрхийн бүртгэлийг Кастодиан болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар гүйцэтгүүлж, баталгаажуулна.

- **Анхдагч зах зээлийн хаалт:** ХОМК нь ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд хөрөнгө оруулалтын багцаар сольж, энэхүү Танилцуулгад заасан хөрөнгийг амжилттай бүрдүүлэн өмчлөх эрхийн бүртгэлийг Кастодиан болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайлан, ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт, ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааны бэлтгэл хангагдсан тухай Хөрөнгийн биржийн дүгнэлтийг Хороонд хүргүүлнэ.

4.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Хөрөнгө оруулагч нь өөрийн харилцдаг ҮЦК-аар дамжуулан ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээл дээрээс нэгж эрхийг худалдан авснаар ХОС-ийн нэгж эрх эзэмшигч болно.

ХОС-ийн Нэгж эрхийг солилцох, буцаан авах, үнийг тодорхойлох журамд тусгасан нэгж эрхийн хоёрдогч зах зээлтэй холбоотой голлох голлох харилцааг дараах байдлаар зохицуулсан байна.Үүнд:

- ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан талаарх тайланг Хороо хүлээн авч, ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгосноор ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.
- Мэргэжлийн оролцогч нь ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг Хөрөнгийн биржээр дамжуулан явуулах ба ХОС-ийн хоёрдогч зах зээл дэх нэгж эрхийн арилжаанд зах зээл үүсгэгчээр оролцоно.
- Мэргэжлийн оролцогч нь ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн эрэлтийг тогтвортой хангах үүднээс ХОС-тай байгуулсан Мэргэжлийн оролцогчийн гэрээгээр тохиролцсон тоо, ширхэг бүхий нэгж эрхийг өөрийн нөөцөд үлдээж, хадгална.
- Мэргэжлийн оролцогч нь ХОС-ийн нэгж эрхийн зах зээлийн үнэ, цэвэр хөрөнгийн үнэлгээний зөрүүг ХОС-тай байгуулсан Мэргэжлийн оролцогчийн гэрээнд заасан хувиас хэтрүүлэхгүйгээр хоёрдогч зах зээл дээр ХОС-ийн нэгж эрхийг эцсийн хөрөнгө оруулагчдад санал болгож, арилжаална.
- Мэргэжлийн оролцогч нь нэгж эрхийн хоёрдогч зах зээлд зах зээл үүсгэгчээр оролцох бөгөөд ХОС-ийн нэгж эрхийн эрэлттэй холбоотойгоор нэгж эрхийг нэмж гаргуулах, буцаах хүсэлтийг системээр дамжуулан ХОС-д гаргана.



4.5
2026

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙГ ХУДАЛДАН АВАХ, ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР


СХА
2026 07 09
МН 01

БҮРТГЭЛТ

Хөрөнгө оруулагч нь Хөрөнгийн биржээр дамжуулан ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээл дээрээс дараах байдлаар ХОС-ийн нэгж эрхийг худалдан авах боломжтой.

Хөрөнгө оруулагч нь Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны дансанд доорх зааврын дагуу мөнгөн хөрөнгөө байршуулан, ХОС-ийн нэгж эрхийг худалдан авах захиалгыг өөрийн харилцагч брокер ҮЦК-аар дамжуулан гаргана. Хөрөнгийн биржид бүртгэлтэй ҮЦК-д үнэт цаасны дансгүй харилцагчийн хувьд шинээр холбогдох дансыг үүсгэн, мөнгөн хөрөнгөө тус дансанд байршуулсны үндсэн дээр ХОС-ийн нэгж эрхийг худалдан авах захиалгаа дараах зааврын дагуу өгнө.

Зураг 37: ХОС-ийн нэгж эрхийг худалдан авах захиалга өгөх заавар



Валютын ханш


ХОС-ийн нэгж эрхийг худалдан авах, худалдах арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр хийгдэнэ.

Арилжааны шимтгэл

ХОС-ийн нэгж эрх худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгож, захиалга өгсөн ҮЦК-д төлөх ба уг шимтгэлд эрх бүхий байгууллагууд болон Хөрөнгийн биржийн шимтгэл багтсан байна. Хөрөнгийн биржийн гишүүн ҮЦК бүрийн шимтгэлийн нөхцөл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

Албан татвар

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл орлого олоогүй боловч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь албан татвар төлөгч байна гэж заасан билээ. Үүний хүрээнд, хөрөнгө оруулагч нь ХОС-ийн нэгж эрхээс олсон орлого (худалдан борлуулсны орлого, ногдол ашгийн орлого зэрэг хамаарна)-д ногдох албан татварыг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу тайлагнаж, төлөх үүрэг хүлээнэ.



107

2026-07-20
4.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ХУДАЛДАН АВАХ
БҮРТГЭЭЛЭЛ

2026-07-19
СЭХ
СЭН

ХОС-д Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд үйлчилгээ үзүүлэх ХОМК нь ХОС-ийн гаргасан нэгж эрхээс 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий нэгж эрхийг худалдан авна.

4.7. ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ НЭМЖ ГАРГАХ, БУЦААН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мэргэжлийн оролцогчид нь ХОС-ийн нэгж эрхийн эрэлт бий болсон үед эрэлтийн хэмжээгээр нэгж эрх нэмж гаргуулах, эрэлт буурсан үед буцаах хүсэлтийг ХОС-д гаргах эрхтэй оролцогч юм. Энэхүү механизм нь хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийн зах зээлийн үнийг нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээтэй ойролцоо байхад чухал үүрэг гүйцэтгэдэг.

ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах, түүнийг хөрөнгө оруулалтын багцаар солилцох үйл ажиллагаа болон нэгж эрхийг буцаан авах, холбогдох хөрөнгө оруулалтын багцыг шилжүүлэх үйл ажиллагаа нь ХОС-ийн Нэгж эрхийг солилцох, буцаан авах, үнийг тодорхойлох журам болон Мэргэжлийн оролцогчийн гэрээгээр нарийвчлан зохицуулагдана.

Зураг 38: ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах, болон нэгж эрхээ буцаан авах үйл ажиллагаа



ХОС нэгж эрх нэмж гаргах, түүнийг хөрөнгө оруулалтын багцаар солилцох үйл ажиллагаа

Мэргэжлийн оролцогчийн гэрээ болон ХОС-ийн холбогдох дотоод журамд ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах, түүнийг хөрөнгө оруулалтын багцаар солилцох үйл ажиллагаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна.

FTI
Futures Tech Innovation
ФТТ
ХАМТЫН БИРЖЭР АРИЛЖААЛАГДАГ
УЛААНБААТАР
108

Хүсэлт гаргах

- Мэргэжлийн оролцогч нь ХОС-ийн нэгж эрхийн эрэлт бий болсон үед Мэргэжлийн оролцогчийн гэрээнд заасны дагуу эрэлтийн хэмжээгээр нэгж эрх нэмж гаргуулахаар хүсэлт гаргаж болно.
- Мэргэжлийн оролцогч нь ажлын өдөр бүр холбогдох журамд заасан цагийн хуваарийн дагуу 10,000 ширхгээр багцлагдсан тоо хэмжээгээр нэгж эрх нэмж гаргуулах хүсэлтийг Хөрөнгө оруулалтын зөвлөхөд гаргана.

Хүсэлтийг шийдвэрлэж, мэдээлэх

- Хөрөнгө оруулалтын зөвлөх нь нэгж эрх нэмж гаргах хүсэлтийг зөвшөөрөх эсхүл түдгэлзүүлэх эсэх шийдвэрийг хологдох журамд тодорхойлсон ажиллагааны цагийн хуваарьт заасан хугацаанд гаргах ба хэрэв нэгж эрх нэмж гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухайгаа Мэргэжлийн оролцогч болон Кастодианд мэдэгдэнэ. (Энэ өдрийг цаашид арилжааны буюу Т өдөр гэнэ).
- Хэрэв Хөрөнгө оруулалтын зөвлөх нь тус хүсэлтийг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн бол холбогдох үндэслэлийн хамт мэдээллийг Мэргэжлийн оролцогчид илгээнэ.
- Хөрөнгө оруулалтын зөвлөх нь нэгж эрх нэмж гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд дараах хоёр үндсэн үйл ажиллагаа хийгдэнэ.
 - ХОС нэгж эрх нэмж гаргах, түүнийг бүртгэлжүүлэх;
 - Мэргэжлийн оролцогч нь холбогдох хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэн, Кастодиан дахь ХОС-ийн дансанд шилжүүлэх;

(1) ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах үйл ажиллагааг дараах дарааллын дагуу хэрэгжүүлнэ.

- Кастодиан нь ХОС-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн холбогдох нэгж эрхийг шинээр үүсгэх маягыг Хөрөнгийн биржид илгээнэ.
- Хөрөнгийн бирж нь тус маягыг үндэслэн холбогдох мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага руу илгээнэ. Тус байгууллага нь Хөрөнгийн биржээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ХОС-ийн эргэлтэд байгаа нэгж эрхийн тоо, ширхгийг нэмэгдүүлэх ба холбогдох тоо, ширхгийг Мэргэжлийн оролцогчийн өмчлөлд бүртгэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

(2) Мэргэжлийн оролцогч нь холбогдох багцыг бүрдүүлэн, Кастодиан дахь ХОС-ийн данс руу шилжүүлэх

- ХОС-ийн нэгж эрхээр солилцох хөрөнгө оруулалтын багц: Хөрөнгө оруулалтын зөвлөх нь нэгж эрх нэмж гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд Мэргэжлийн оролцогч нь холбогдох гэрээ болон журамд тодорхойлсон хөрөнгө оруулалтын багцыг Кастодиан дахь ХОС-ийн дансанд шилжүүлнэ.

Үйл ажиллагаа дуусгавар болох

- ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах, түүнийг хөрөнгө оруулалтын багцаар солилцох үйл ажиллагаа нь Мэргэжлийн оролцогч холбогдох хөрөнгө оруулалтын багцыг ХОС-ийн өмчлөлд, ХОС нь холбогдох нэгж эрхийг Мэргэжлийн оролцогчийн өмчлөлд шилжүүлснээр дуусгавар болно.

Гаргаж байгаа нэгж эрхээ хүчингүй болгох

- Мэргэжлийн оролцогч нь нэгж эрхээр солилцох хөрөнгө оруулалтын багцыг холбогдох журамд заасан хугацаанд ХОС-д шилжүүлээгүй эсхүл Мэргэжлийн оролцогчийн бүрдүүлсэн хөрөнгө оруулалтын багц нь өмчлөх эрхийн зөрчилтэй болох нь тогтоогдсон тохиолдолд ХОС нь нэмж гаргаж байгаа нэгж эрхийг хүчингүй болгоно.

Холбогдох бусад харилцаа

- ХОС-ийн нэгж эрх нэмж гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор ХОС болон Мэргэжлийн оролцогчийн хооронд үүсэх нарийвчилсан харилцааг Мэргэжлийн оролцогчийн гэрээгээр зохицуулна.



2026.07.09

Нэгж Эрхийг буцаан авах, холбогдох хөрөнгө оруулалтын багцыг шилжүүлэх үйл ажиллагааг Э В

БҮРТГЭЛ-03

СЗХ
2026.07.09 өдөр

№ 01

Мэргэжлийн оролцогчийн гэрээ болон ХОС-ийн холбогдох дотоод журамд ХОС-ийн нэгж эрхийг буцаан авах, холбогдох хөрөнгө оруулалтын багцыг шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна.

Хүснэгт 44: ХОС-ийн нэгж эрхийг буцаан авах үйл ажиллагааны дараалал, холбогдох мэдээлэл

Үйл ажиллагаа	Тайлбар
Хүсэлт гаргах	- ХОС-ийн нэгж эрхийн эрэлт багасаж, хоёрдогч зах зээл дээр эцсийн хөрөнгө оруулагчдын нэгж эрхээ худалдах захиалга их байх тохиолдолд Мэргэжлийн оролцогч нэгж эрхийг эцсийн хөрөнгө оруулагчдаас худалдан авч хөрөнгө оруулалтын багцаар солилцоно. - Мэргэжлийн оролцогч нь ажлын өдөр бүр холбогдох журамд заасан хугацаанд 10,000 ширхгээр багцлагдсан тоо, ширхгээр нэгж эрхийг буцаах хүсэлтийг Мэргэжлийн оролцогчийн гэрээнд заасны дагуу Хөрөнгө оруулалтын зөвлөхөд гаргана.
Хүсэлтийг шийдвэрлэж, мэдээлэх	- Хөрөнгө оруулалтын зөвлөх нь нэгж эрхийг буцаах хүсэлтийг холбогдох журамд заасан цагийн хуваарьт заасан хугацаанд тухайн хүсэлтийг зөвшөөрөх эсхүл түдгэлзүүлэх эсэх шийдвэрийг гаргах ба нэгж эрхийг буцаан авахаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай мэдээллийг Мэргэжлийн оролцогч болон Кастодианд мэдэгдэнэ (Т өдөр). - Хөрөнгө оруулалтын зөвлөх нь тус хүсэлтийг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн бол үндэслэлийн хамт холбогдох мэдээллийг Мэргэжлийн оролцогчид илгээнэ. - Хөрөнгө оруулалтын зөвлөх нь нэгж эрх буцаах тухай дээрх хүсэлтийг хүлээн авч зөвшөөрсөн тохиолдолд дараах хоёр үндсэн үйл ажиллагаа хийгдэнэ. - Мэргэжлийн оролцогч нь холбогдох нэгж эрхийг ХОС руу шилжүүлэх буюу ХОС нь холбогдох нэгж эрхийг буцаан авах; - ХОС нь холбогдох хөрөнгө оруулалтын багцыг Кастодиан дахь Мэргэжлийн оролцогчийн дансанд шилжүүлэх.
(1) ХОС нэгж эрхийг буцаан авах үйл ажиллагааг дараах дарааллын дагуу хэрэгжүүлнэ.	- Кастодиан нь ХОС-аас ирүүлсэн мэдээллийг үндэслэн холбогдох журамд заасан хугацаанд нэгж эрхийг буцаан авах тухай маягтыг Хөрөнгийн биржид илгээнэ. - Хөрөнгийн бирж нь тус маягтад үндэслэн холбогдох журамд заасан цагийн хуваарийн дагуу холбогдох мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага руу илгээнэ. Тус байгууллага нь Хөрөнгийн биржээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ХОС-ийн эргэлтэд байгаа нэгж эрхийн тоо, ширхгийг бууруулах ба холбогдох тоо, ширхгийг Мэргэжлийн оролцогчийн өмчлөлөөс хасаж бүртгэх ажиллагааг хэрэгжүүлнэ.
(2) ХОС нь холбогдох хөрөнгө оруулалтын багцыг Кастодиан дахь Мэргэжлийн оролцогчийн данс руу шилжүүлэх	Хөрөнгө оруулалтын зөвлөх нь нэгж эрхийг буцаах хүсэлтийг хүлээн авч зөвшөөрсөн тохиолдолд тухайн өдөрт багтаан ХОС-ийн хөрөнгөөс холбогдох хөрөнгө оруулалтын багцыг Кастодиан дахь Мэргэжлийн оролцогчийн дансанд шилжүүлнэ.
Үйл ажиллагаа дуусгавар болох	ХОС нэгж эрхийг буцаан авах, холбогдох хөрөнгө оруулалтын багцыг шилжүүлэх үйл ажиллагаа нь ХОС холбогдох хөрөнгө оруулалтын багцыг Кастодиан дахь Мэргэжлийн оролцогчийн дансанд шилжүүлж, Мэргэжлийн оролцогчийн буцаасан нэгж эрх нь түүний өмчлөлөөс хасагдсанаар дуусгавар болно.
Холбогдох бусад харилцаа	ХОС-ийн хөрөнгөөс холбогдох хөрөнгө оруулалтын багцыг Мэргэжлийн оролцогчид шилжүүлэх, Мэргэжлийн оролцогчийн өмчлөл дэх нэгж

УЛААНБААТАР ХН
902010933

2026-03-30

БҮРТГЭВ-03

2026-03-30

№ 01

эрхийн тоо, ширхгийг бууруулах гүйлгээний шимтгэлийн зардлыг Мэргэжлийн оролцогч хариуцна.

- ХОС харилцагчаа төлөөлөн нэгж эрхийг буцаах захиалгыг гаргасан тохиолдолд Хөрөнгө оруулалтын зөвлөх, Кастодиан нь Мэргэжлийн оролцогчийн захиалгатай адил авч үзэн, холбогдох журамд заасан цагийн хуваарийн дагуу шийдвэрлэнэ.
- Мэргэжлийн оролцогч нь нэгж эрхийн солилцоонд авсан хөрөнгө оруулалтын багц дахь хөрөнгийг харилцагчийн хүсэл, эрх ашигт нийцүүлэн худалдан борлуулж, төлбөрийг харилцагчийн дансанд шилжүүлнэ.
- ХОС-ийн нэгж эрхийг буцаан авах үйл ажиллагаатай холбоотойгоор ХОС болон Мэргэжлийн оролцогчийн хооронд үүсэх нарийвчилсан харилцааг Мэргэжлийн оролцогчийн гэрээгээр зохицуулна.

Нэгж эрх нэмж гаргах, буцаан авах үйл ажиллагааг түдгэлзүүлэх

Хөрөнгө оруулалтын зөвлөх нь нэгж эрх эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй дараах нөхцөл байдал үүсэхээр бол нэгж эрх нэмж гаргах, буцаан авах үйл ажиллагааг түдгэлзүүлж болно. Үүнд:

- ХОС-ийн эзэмшиж буй хөрөнгө оруулалтын багцын бүрэлдэхүүнд багтах хөрөнгө оруулалтын хэрэгслийн арилжаалагдаж буй үндсэн бирж, эсхүл клирингийн төв, төлбөр тооцооны төвүүдийн хаалттай өдрүүд таарсан;
- ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцад 5%-аас дээш хувийн жин эзэлж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгслийн арилжааг үндсэн Хөрөнгийн бирж дээр зогсоосон байгаа;
- Аливаа нэг нөхцөл байдлын улмаас ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын бүрэлдэхүүнд буй хөрөнгө оруулалтын хэрэгслийг худалдах, худалдан авах үйлдэл нь нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг зөрчихөөр бол;
- Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэлгээг тооцоолох боломжгүй байгаа үед;
- Нэгж эрхээр солилцох хөрөнгө оруулалтын багц нь өмчлөх эрхийн зөрчилтэй байж болзошгүй, зөрчилтэй тохиолдолд.

Дээрх түдгэлзүүлэх үндэслэл арилсан үед ХОС нь нэгж эрх нэмж гаргах эсхүл буцаан авахаар шийдвэрлэж болно.

ХОС болон ХОМК нь энэ хэсэгт тусгагдсаны дагуу Мэргэжлийн оролцогчийн хүсэлтийг түдгэлзүүлсэн болон мөнгөн төлбөр, хөрөнгө оруулалтын хэрэгсэл шилжүүлэхийг хойшлуулсны улмаас Мэргэжлийн оролцогч, нэгж эрх эзэмшигчид нэмэлт зардал, алдагдал гарах тохиолдолд түүнийг ХОС болон ХОМК хариуцахгүй.

ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц, түүнтэй холбоотой мэдээлэл

ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, эрх бүхий байгууллагын холбогдох журам болон ХОС-ийн дотоод журамд үндэслэн ХОС-ийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээг ажлын өдөр бүр тооцож, дараах хөрөнгө оруулалтын багцын мэдээллийн хамт ажлын өдрийн өглөөний 10 цагаас өмнө Хөрөнгийн бирж болон ХОС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

- Тухайн өдрийн байдлаарх ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц, түүний бүтэц (Current basket);
- Т дэх өдөр ХОС нэгж эрх нэмж гаргасан тохиолдолд түүгээр солилцох хөрөнгө оруулалтын багц (Creation basket);
- Т дэх өдөр ХОС-ийн нэгж эрхийг буцаасан тохиолдолд солилцох хөрөнгө оруулалтын багц (Redemption basket).



Зах зээлийн нөхцөл байдал, ХОС-ийн хөрөнгө оруулалтын стратегитай холбоотойгоор дээр тодорхойлсон хөрөнгө оруулалтын багцууд хоорондоо ижил байж болно.

БҮРТГЭВ-03

Түүнчлэн, тухайн өдрийн ХОС-ийн нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээг тухайн ХОС-ийн эзэмшиж буй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өмнөх арилжааны өдрийн хаалтын ханш болон Монголбанкны өмнөх өдрийн албан ханшид үндэслэн дараах байдлаар тооцоолно. Үүнд:

$$\text{ХОС-ийн нэгж эрхэд ногдох ЦХҮ} = \frac{(\text{ХОС-ийн нийт хөрөнгийн үнэлгээ} - \text{ХОС-ийн өр төлбөр})}{\text{ХОС-ийн эргэлтэд байгаа нэгж эрхийн тоо ширхэг}}$$

Мэргэжлийн оролцогчийн хүсэлтээр ХОС нэгж эрх нэмж гаргах, буцаан авах үйл ажиллагааны шимтгэл

Мэргэжлийн оролцогчийн гэрээнд заасны дагуу Мэргэжлийн оролцогчийн хүсэлтээр ХОС нэгж эрх нэмж гаргах, буцаан авах тохиолдолд Мэргэжлийн оролцогч нь дараах хураамжийг ХОС-д төлнө. Үүнд:

- Нэгж эрх нэмж гаргах бол нэмж гаргах үнийн дүнгийн 0.1%-ийн хураамж;
- Нэгж эрхийг буцаах захиалгад буцаах үнийн дүнгийн 0.25%-ийн хураамж;
- Нэгж эрх нэмж гаргах, буцаах захиалгыг хэсэгчлэн болон бүхэлд нь цуцалсан тохиолдолд 100,000 төгрөгийн хураамж;
- Мэргэжлийн оролцогчийн гэрээнд заасан хугацаанд санхүүгийн хэрэгслийг шилжүүлээгүй тохиолдолд 100,000 төгрөгийн хураамж болон уг гэрээнд заасан алдангийг тус тус төлнө.

Мэргэжлийн оролцогч нь дараах тохиолдолд хураамж төлөхгүй. Үүнд:

- ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлд анх удаа ХОС-ийн нэгж эрхийг хөрөнгө оруулалтын багцаар солилцон авах;
- ХОС-ийн нэгж эрхийг Хөрөнгийн бирж дээр анх удаа арилжаалснаас хойш хуанлийн 14 хоногийн хугацаанд нэгж эрхийг буцаах захиалга өгөх үед.

Мэргэжлийн оролцогч нь дээрх хураамжийг нэгж эрх нэмж гаргах эсхүл буцаан авах шийдвэр гарснаас хойш ажлын 2 өдрийн дотор нэхэмжлэлийн дагуу Кастодиан дахь ХОС-ийн дансанд шилжүүлнэ.

Мэргэжлийн оролцогчийн гэрээнд тусгасан бусад голлох зохицуулалт

Мэргэжлийн оролцогч нь дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

- ХОС-ийн нэгж эрхийг хоёрдогч зах зээлд арилжаалах;
- Хоёрдогч зах зээл дээрээс худалдан авсан нэгж эрхээ ХОС-д буцаах захиалга өгөх;
- ХОС-д буцаасан нэгж эрхэд ногдох хөрөнгө оруулалтын багцыг өөрийн дансанд хүлээн авах;
- Хоёрдогч зах зээлийн эрэлтийг хангах зорилгоор ХОС-ийн 10,000-аас багагүй нэгж эрхийг нэмж гаргуулахаар Хөрөнгө оруулалтын зөвлөхөд захиалга өгөх;
- ХОС-ийн нэгж эрхийг өөрийн хөрөнгөөр худалдаж авсан хөрөнгө оруулалтын багцаар солилцох;
- Нэгж эрхийн арилжааг идэвхжүүлэх, сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулах;
- Эцсийн хөрөнгө оруулагчийн хүсэлтээр дамжуулан нэгж эрхийг буцаах захиалгыг өгөхдөө тухайн эцсийн хөрөнгө оруулагчид шимтгэл ногдуулах;
- Тус гэрээ, хууль тогтоомжид заасан бусад.



Мэргэжлийн оролцогч нь дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:

БҮРТГЭВ-03

- ХОС-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлд анх удаа нэгж эрхийг тус гэрээнд заасан хөрөнгө оруулалтын багцаар солих;
- Нэгж эрхийг солилцох хөрөнгө оруулалтыг багцыг өөрийн хөрөнгөөр бүрдүүлэх;
 - Бүрдүүлсэн хөрөнгө оруулалтын багц нь аливаа өмчлөх эрхийн зөрчилгүй талаарх нотлох баримтыг гаргаж өгөх;
 - ХОС-ийн нэгж эрхийг эцсийн хөрөнгө оруулагч буюу олон нийтэд санал болгох;
 - ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, ХОС-ийн нэгж эрхийн зах зээлийг үүсгэх;
 - Кастодиан дахь өөрийн дансыг тус гэрээнд заасан дүнгээр, заасан хугацаанд зузаатгах;
 - ХОС-ийн нэгж эрхээр солилцсон хөрөнгө оруулалтын багцыг тус гэрээнд заасан хугацааны дотор Кастодиан дахь ХОС-ийн дансанд шилжүүлэх;
 - Нэгж эрх нэмж гаргах, буцаах захиалга болон бусад шаардлагатай хүсэлтүүд дээр ногдох шимтгэл, хураамжийг тухай бүр төлөх;
 - Өдөр бүрийн нэгж эрхийн арилжааны мэдээлэл болон ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллээр ХОС-г хангах;
 - ХОС-ийн нэгж эрхийн талаар хөрөнгө оруулагч, олон нийтэд үнэн зөв мэдээллийг цаг тухай бүрд хүргэх, зах зээлийг идэвхжүүлэх;
 - ХОС-ийн нэгж эрхийг мөнгөн хөрөнгөөр худалдан авсан тохиолдолд холбогдох хөрөнгө оруулалтын багц худалдан авахад төлөх зуучлалын хөлсийг нэмж төлөх;
 - Нэгж эрхийг буцаах захиалга өгсөн тохиолдолд тухайн нэгж эрхүүд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд хасагдах хүртэл, тухайн нэгж эрхийг бусдад худалдахгүй байх;
 - Нэгж эрхийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон Кастодианд мэдээлэх;
 - Хөрөнгө оруулалтын багцын төлбөрийг төлөх хугацаа хэтрүүлсэн өдөр тутамд 0.1%-ийн алданги төлөх;
 - Шаардлагатай мэдээлэл, баримт бичиг, мэдэгдэл, баталгааг Хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх;
 - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааны хүрээнд харилцагчийг танин баталгаажуулах, хөрөнгийн эх үүсвэрийг тодруулах зэрэг шаардлагатай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
 - Тус гэрээ, хууль тогтоомжид заасан бусад.

Түүнчлэн энэхүү гэрээгээр ХОС, түүнийг төлөөлж ХОМК нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Мэргэжлийн оролцогчоос тус гэрээний үүргээ биелүүлэх, арилжаатай холбоотой мэдээллийг ХОС-д хүргүүлэхийг шаардах;
- Хоёроос дээш тооны ХОС-ийн шаардлага хангасан Мэргэжлийн оролцогчтой гэрээ байгуулан хамтран ажиллах;
- Мэргэжлийн оролцогчид хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцох зөвлөмж, санал хүргүүлэх;
- Зах зээл үүсгэгч нэмэх зорилгоор бусад ҮЦК-тай хамтран ажиллах;
- Дангаараа, эсхүл бусад байгууллагуудтай хамтран танилцуулга, сурталчилгаа явуулах;
- Бодлогын баримт бичгийг ХОС-ийн ТУЗ-өөр өөрчлөн батлуулах;
- Нэгж эрх нэмж гаргах, нэгж эрхийг буцаан авах эсэхийг шийдвэрлэх;
- ХОС-ийн нэгж эрхийг солилцсон хөрөнгө оруулалтын багцыг тус гэрээнд заасан хугацаанд багтаан ХОС-ийн Кастодиан дахь дансанд хүлээх авах;
- Тус гэрээ, хууль тогтоомжид заасан бусад.

Энэхүү гэрээнд заасны дагуу ХОС, түүнийг төлөөлж ХОМК нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Тус гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөж буй ХОС-тай холбоотой журам, зааврыг Мэргэжлийн оролцогчид танилцуулах;
- ХОС-ийн нэгж эрхийг Мэргэжлийн оролцогчийн хүсэлтээр нэмж гаргах, буцаан авах;



2026-07-09

БҮРТГЭЭ

ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийн талаарх мэдээллийг ажлын өдөр бүр Хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаар олон нийтэд өглөөний 10 цагт багтаан мэдээлэх;
Буцаан авсан нэгж эрхэд ногдох хөрөнгө оруулалтын багцыг тус гэрээнд заасан хугацаанд багтаан Кастодиан дахь Мэргэжлийн оролцогчийн данс руу шилжүүлэх;

- ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
- ХОС-ийн Бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулснаас хойш тухайн өөрчлөлтийг холбогдох хууль болон журамд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэх;
- Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажиллах;
- Тус гэрээ, хууль тогтоомжид заасан бусад.



2026-07-20

БҮРТГЭВ-03

СЭХ
2026.07.09
БҮРТГЭВ
№ 1

ОБ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД



2026-07-30
5.1.

МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

БҮРТГЭЛЭГ

2026-07-09 өдөр
БҮРТГЭВ

№ 01

ХОС-д хөрөнгө оруулахаар сонирхож буй хөрөнгө оруулагч нь ХОС-ийн нэгж эрх гаргах ажиллагаанд оролцож буй дор дурдсан Мэргэжлийн оролцогчид болон/эсхүл өөрийн харилцдаг Хөрөнгийн биржид бүртгэлтэй ҮЦК-аар дамжуулан ХОС-ийн нэгж эрхийг Хөрөнгийн биржээс худалдан авах боломжтой.

Хүснэгт 45: "Апекс Капитал ҮЦК" ХХК-ийн мэдээлэл



"Апекс Капитал ҮЦК" ХХК

Регистрийн дугаар: 5453283
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, олимпын 4, Нью Хоризонс оффис, 901 тоот
Холбоо барих утас: 7510-7500
Цахим хуудас: www.apex.mn

Хүснэгт 46: "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн мэдээлэл



"Голомт Капитал ҮЦК" ХХК

Регистрийн дугаар: 5481589
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плэйс оффисын барилга, 4 давхар, 403,404 тоот
Холбоо барих утас: 7012-1530
Цахим хуудас: www.golomtcapital.com

Хүснэгт 47: "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн талаарх мэдээлэл



"Таван Богд Капитал ҮЦК" ХХК


Регистрийн дугаар: 5469112
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа Улаанбаатар төвийн 1 давхар
Холбоо барих утас: 7272-7282
Цахим хуудас: www.tavanbogdcapital.com

Хүснэгт 48: "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-ийн талаарх мэдээлэл



"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК

Регистрийн дугаар: 5251494
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, энхтайвны өргөн чөлөө, худалдаа, хөгжлийн банкны төв байр
Холбоо барих утас: 7010-0261
Цахим хуудас: www.tdbsecurities.mn





ГОЛОМТ БАНК

“Голомт Банк” ХК

Холбоо барих утас:

(976) 7011-1646

Цахим хуудас:

www.golomtbank.com

ХОС-ийн Кастодиан нь ХОС-ийн хөрөнгийг ХОМК-ийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр, тооцоог гүйцэтгэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ҮЦЗЗ-ийн зохицуулалттай этгээд болох “Голомт Банк” ХК байна.

Кастодиан нь Хорооноос 2014 оны 8-р сарын 27-ны өдөр кастодиан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2017 оны 12-р сарын 15-ны өдөр Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авснаар хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг бүртгэж хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэх, компанийн үйл ажиллагаанд төлөөлөхөөс гадна нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолох зэрэг цогц үйлчилгээг ХОМК-аас хараат бусаар гүйцэтгэж, хөрөнгө оруулагчид болон Хороонд хараат бус бие даасан тайлан мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Кастодиан нь нийт 1,600 гаруй гадаад болон дотоодын иргэн, хуулийн этгээдийн үнэт цаасны хадгаламжийн дансыг нээж кастодианы үйлчилгээг үзүүлж байна. Мөн нийт 20 гаруй хөрөнгө оруулалтын сангуудад үйлчилгээ үзүүлж, 20 гаруй брокерын компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан хамтын ажиллагаагаа өргөжүүлжээ.

Хөрөнгө хадгалах гэрээний талаарх мэдээлэл

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалтыг хөрөнгө оруулалтын сантай байгуулсан хөрөнгө хадгалах тухай гэрээний үндсэн дээр кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхэлнэ” гэж заасны дагуу ХОС нь Кастодиантай Хөрөнгө хадгалах гэрээг байгуулсан болно.

Уг гэрээний дагуу Кастодиан нь ХОС-ийн хөрөнгийг хадгалах, арилжааны төлбөр, тооцоог гүйцэтгэх, ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх, нэгж эрхийн цэвэр үнэлгээг тооцоолох болон кастодианы бусад нэмэлт үйлчилгээг ХОС-д үзүүлж ажиллана.



117

2026.01.01

Хөндлөнгийн хуулийн зөвлөх байгууллага

Хүснэгт 50-Хуулийн зөвлөх байгууллагын мэдээлэл

БҮРТГЭВ

2026.01.01
БҮРТГЭВ
№ 01



“Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс” ХХН

Холбоо барих утас: (976) 11-330048
Цахим хуудас: www.mdsa.mn

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон эрх бүхий байгууллагын холбогдох журамд заасны дагуу ХОС-ийн нэгж эрх олон нийтэд нээлттэй арилжаалагдахтай холбогдуулан ХОС-д хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээг үзүүлж буй “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь Монгол Улсын томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаадын болон дотоодын бизнесийн байгууллагууд дэлхийн хэмжээний мэдлэгийг дотоодын ур чадвартай хослуулан хууль зүйн үйлчилгээг үзүүлж ирсэн туршлагатай.

Хөндлөнгийн хуулийн зөвлөх байгууллага нь хуулийн салбарын олон жилийн мэдлэг, туршлага бүхий 3 партнер, 10 орчим хуульч, эрх зүйч нарын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд энэхүү Хөндлөнгийн хуулийн зөвлөх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-т заасан ҮЦ33-д хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн бөгөөд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажилласан арвин туршлагатай. Тухайлбал,

- “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төсөл;
- “Инвектор Глобал Кью Хамтын биржээр арилжаалагддаг ХОС”-д зөвлөх үйлчилгээ зэрэг байна.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний талаарх мэдээлэл

ХОС нь Хөндлөнгийн хуулийн зөвлөх байгууллагатай байгуулсан Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний хүрээнд дор дурдсан хууль зүйн зөвлөх үйлчилгээг авсан. Үүнд:

- Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-г үүсгэн байгуулах баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, Танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх;
- ХОС-г үүсгэн байгуулагч ХОМК нь хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан эсэх, холбогдох тусгай зөвшөөрөл авсан эсэх, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх;
- ХОМК-ийн Хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх захирал, Хөрөнгө оруулалтын зөвлөх, бусад эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооны тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж буй эсэх;
- Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор Мэргэжлийн оролцогч нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлагыг хангаж буй эсэх.

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь “Фьючер Тек Инновэйшн хамтын биржээр арилжаалагддаг ХОС” үүсгэн байгуулахтай холбогдуулан 2026 оны 01 сарын 14-ний өдөр Д-26/09 дүгээр хууль зүйн дүгнэлт гаргасан болно. Тус дүгнэлтээр ХОМК нь хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах эрх бүхий этгээд мөн гэж үзсэн байна. Түүнчлэн, ХОС үүсгэн байгуулах баримт бичиг, ХОС-ийн дүрэм, Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, ХОС-ийн багц журам, холбогдох гэрээ нь хууль тогтоомжийн зөрчилгүй, ХОМК болон ХОС-ийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөх, бусад эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Хорооны тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж байгаа бөгөөд мэргэжлийн оролцогч нар нь ХОС-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байгаа болохыг тодорхойлсон болно.





“Мэжикконсалтинг аудит” ХХК

Холбоо барих утас:

(976) 7013 1044

Цахим хуудас:

www.magicgroup.mn

ХОС-д хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллагаар “Мэжикконсалтинг Аудит” ХХК байх бөгөөд тус Хөндлөнгийн аудитын байгууллага нь 2007 онд үүсгэн байгуулагдаж, 2010 онд Сангийн яамнаас Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2016 онд Хорооноос ҮЦЗЗ-д оролцогч байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээг тус тус авсан.

Мөн Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, аудитор, үнэлгээчин зэрэг мэргэжлийн цол, эрх бүхий 30-40 орчим ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс жил бүр тодорхойлдог ТОП 20 аудитын компанийн жагсаалтад сүүлийн 6 жил дараалан тодорхойлогдсон байна.

Түүнчлэн, төрийн өмчит хуулийн этгээд, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, төрийн бус байгууллага зэрэг олон төрөл, хэлбэр бүхий харилцагчдад аудитын үйлчилгээг үзүүлж буй туршлагатай юм.

Энэхүү Хөндлөнгийн аудитын байгууллага нь Аудитын Олон Улсын Стандарт, Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт, Монгол Улсын Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу ХОС болон ХОМК-аас ажил төрөл, хувийн харилцаа холбооны хувьд, мөн аудитын үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байх шаардлагыг бүрэн хангаж байна.

Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний талаарх мэдээлэл

ХОС нь Хөндлөнгийн аудитын байгууллагатай Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсны үндсэн дээр аудитын үйлчилгээг авах бөгөөд тус гэрээнд заасан нөхцөлөөр ХОС-ийн 2026 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн байдлын тайлан болон тэдгээрийн тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын шалгалт хийж гүйцэтгэнэ.

Түүнчлэн, уг гэрээгээр дор дурдсан харилцааг голлон зохицуулсан болно. Үүнд:

- Хөндлөнгийн аудитын байгууллага нь ХОС болон ХОМК-аас ажил төрөл, хувийн харилцаа холбооны хувьд, мөн аудитын үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байна.
- ХОС нь аливаа нэг талыг барьсан үзэл бодол болон сонирхлын зөрчилд автаагүй, бусдын нөлөөгүйгээр дүгнэлт, зөвлөмжөө гаргасан, эсвэл дүгнэлт, зөвлөмжөө гаргахын тулд оюун санаа болон бодит хандлагын хувьд хараат бус байна.

